

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-84
1. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/	5-56
2. Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны тайлан	56-69
3. Үндэсний статистикийн хорооны 2024 оны үйл ажиллагааны тайлан	69-84

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны
05 дугаар сарын 14-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 37 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Алдаржавхлан, Н.Батсүмбэрэл, П.Батчимэг, Х.Ганхуяг, М.Мандхай, Р.Сэддорж, А.Ундраа, С.Цэнгүүн, М.Энхцэцэг;

Чөлөөтэй: О.Цогтгэрэл;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Баттулга;

Тасалсан: Ч.Лодойсамбуу.

Хэлэлцэх асуудлын 1 дүгээрт байгаа Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хууль санаачлагч нь байхгүй тул хойшлуулав./10:39/

**Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн
мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Нийслэлийн Засаг даргын орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Амгалан, Нийслэлийн Ерөнхий архитектор Ч.Төгсдэлгэр, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, мөн газрын Салбар дундын зохицуулалт,

төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, мөн газрын ахлах мэргэжилтэн З.Райымбек, Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Балчинлуvsан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Хадбаатар, мөн газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Гантулга, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа, “Сэлбэ 20 минутын корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал У.Баатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдыг хуралдаанд оролцох шаардлагатай тул ирэх хүртэл хугацаагаар уг асуудлыг хойшлуулах горимын санал гаргав.

Горимын саналтай холбогдуулан Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан үг хэлэв.

Р.Батболд: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 11
Бүгд: 13

15.4 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Горимын санал дэмжигдээгүй тул уг асуудлыг хэлэлцэж эхлэв.

Төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа, Л.Соронзонболд, Э.Батшугар, Ж.Ганбаатар, П.Сайнзориг, Г.Лувсанжамц, Б.Мөнхсоёл, М.Бадамсүрэн, О.Батнайрамдал, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, Хүнс, хөдөө аж

ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, М.Бадамсүрэн, О.Батнайрамдал, Б.Мөнхсоёл, Р.Батболд нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Ажлын албаны дарга Б.Итгэлсүрэн, мөн хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Даатгалын газрын дарга З.Батболд, Хадгаламж, зээлийн хоршооны газрын дарга Ц.Алтантуул, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга Б.Долгорсүрэн, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Сэндбоксын албаны дарга Б.Батчимэг, Мөнгө угаахтай тэмцэх албаны дарга У.Ганчимэг, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт Т.Билэгсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны тайланг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын тавьсан асуултад Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны тайлантай танилцлаа.

Уг асуудлыг 14 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Үндэсний статистикийн хорооны 2024 оны үйл ажиллагааны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, мөн хорооны Тамгын газрын дарга Б.Лхагва, Нэгдсэн

статистикийн газрын дарга Ц.Тэгшжаргал, Эдийн засгийн статистикийн газрын дарга М.Оюунжаргал, мөн газрын Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэлийн статистикийн хэлтсийн дарга Э.Мягмарханд, Нийгмийн статистикийн газрын дарга М.Оюунцэцэг, мөн газрын Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн дарга Л.Ундрал, Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын дарга Ш.Ариунболд, мөн газрын Өгөгдөл, судалгаа шинжилгээний хэлтсийн дарга Д.Оюунбилэг, Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газрын дарга Н.Мөнхбаяр, Нэгдсэн статистикийн газрын Олон нийттэй харилцах хэлтсийн ажилтан Б.Цацралт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Үндэсний статистикийн хорооны 2024 оны үйл ажиллагааны тайланг Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Г.Лувсанжамц, О.Батнайрамдал, М.Бадамсүрэн, Р.Батболд нарын тавьсан асуултад Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Үндэсний статистикийн хорооны 2024 оны үйл ажиллагааны тайлантай танилцлаа.

Уг асуудлыг 15 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 43 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим, 10 цаг 37 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Батболд: Гишүүдийн өглөөний мэндийг хүргэе. Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 14-ний хурал хуралд 13 гишүүн ирж, ирц 52 хувьтай болсон учир хурал нээснийг мэдэгдье.

Хуралд ирсэн гишүүдээ танилцуулъя. Бадамсүрэн гишүүн ирсэн байна. Батшугар гишүүн ирсэн байна. Жаргалан гишүүн ирсэн байна. Найдалаа гишүүн ирсэн байна. Энхтүвшин гишүүн ирсэн байна. Бямбасүрэн гишүүн ирсэн байна. Лувсанжамц гишүүн ирсэн байна. Сайнзориг гишүүн ирсэн байна. Батнайрамдал гишүүн ирсэн байна. Ганбаатар гишүүн ирсэн байна. Мөнхсоёл гишүүн ирсэн байна. Соронзонболд гишүүн ирсэн байна. Миний бие байна. Ингээд 13 гишүүн ирсэн байна.

Тэгээд Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Байнгын хорооны хуралдаан 4 асуудалтай байгаа.

1.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025 оны 3 сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай оруулж ирсэн, анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ/

2.“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025 оны 4 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/ явуулна.

3 дугаарт нь Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны тайлан Улсын Их Хурлын 2025 оны 3 сарын 28-ны өдөр ирүүлсэн хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

4 дүгээрт нь Үндэсний статистикийн хорооны 2024 оны үйл ажиллагааны тайлан Улсын Их Хурлын 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдөр ирүүлсэн хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна.

Би өөрөө санал гаргахгүй бол болохгүй юм байна. 1 дүгээр асуудал Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль дээр дэгийн тухай хуулийн 31.5-ыг үндэслээд хууль санаачлагч нь хэлэлцүүлгийн бүх шатад оролцох үүрэгтэй гэдэг. Тэгээд Учрал гишүүн гадаад томилолттой байгаа юм байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх. Тэгэхээр энэ асуудлыг хойшлуулъя гэдэг саналтай байна. Гишүүд ямар саналтай байна.

Тэгэхээр энэ Зөвшөөрлийн тухай хуулийн асуудлыг хойшлууллаа.

10.39 цаг.

2 дугаар асуудал. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Ажлын хэсгийг оруулъя. **“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.**

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийн талаарх Засгийн газрын танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан танилцуулна. Сайнзориг гишүүн горим гаргаж байгаа бол микрофон дээрээ горимын санал гаргая.

П.Сайнзориг: Би зүгээр горимын санал нь тэр дэгийн хууль дээр чинь байгаа Ерөнхий сайдын томилсон сайд гэж байж байгаа. Томилсон шийдвэрийг 1 дүгээрт бид нар үзүүлчих. 2 дугаарт эсвэл тийм шийдвэр байхгүй бол Эдийн засаг, хөгжлийн сайд нь буюу Тэргүүн шадар сайд нь хуралдаа орох хүртэл энийг хойшлуулъя. Энэ 2026 оны Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөний төсөл ярих нь чухал юм уу эсвэл тодорхой нэг төслийн нээлтэд оролцох нь ямар олуулаа нээлтэд ордог юм. Сая өмнөх наад Зөвшөөрлийн хууль чинь хэлэлцэх гэсэн чинь эрхэлсэн сайд нь буюу хуулийн төсөл өргөн барьсан сайд чинь гадаад томилолттой гээд хойшлуулж байна шүү дээ. Асуудлуудыг нь хэлэлцээд явъя гэхээр гадагшаа, дотогшоо, нээлт гээд Улсын Их Хурлын хэвийн үйл ажиллагаанд ингээд халдаад байж болох юм уу. Тийм учраас Тэргүүн Шадар сайд оролцох хүртэл гэдэг юм уу хуралдаа орох ёстой. Тийм учраас горимын санал гаргаж хойшлуулж байна. Хойшлуулах санал гаргаж байна.

Р.Батболд: Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан Танд Ерөнхий сайдаас томилсон шийдвэр байгаа юу. Амарсайхан сайдын микрофоныг өгье. Ажлын хэсгийн 4 номер.

С.Амарсайхан: Үндсэн хууль болон бусад холбогдох хуулиар Засгийн газрын гишүүнийг Монгол Улсын Ерөнхий сайд томилдог. Томилсон Засгийн газрын гишүүд шаардлагатай үед асуудлуудыг танилцуулах үйл ажиллагаанд оролцох бүрэн эрх нь нээлттэй Сайнзориг гишүүн ээ. Одоо жоохон юманд ажил хэрэг талаас нь хандахгүй бол энэ Засгийн газрын гишүүд Ерөнхий сайд эд нар чинь зугаалж яваагүй шүү дээ. Ажлаа хийгээд, асуудлаа шийдээд явж байгаа. Бид энд бас асуудлаа танилцуулах гээд Засгийн газрын гишүүний хувьд, дээрээс нь асуудал хариуцсан яамдын холбогдох Төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга нар ороод ирчихсэн байна. Одоо наад нэг жоохон ойлгомжгүй, юм болгоныг болохгүй талаас нь хардаг, аливаа асуудлыг бодит үр дү үйл ажиллагаа талаас нь биш, улс төрийн попрол талаас нь хардаг юмаа болих нь дээр шүү. Болохгүй гэж байгаа бол. Чи одоо юм юман дээр ингээд л хүн хүн рүү агсардгаа болиорой. Гишүүд яриад байвал бүгд чадна шүү наадах чинь.

Р.Батболд: Санал хураачихъя тэгэх үү. Сайнзориг гишүүний гаргасан горимын саналаар “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлыг хойшлуулъя гэдгийг дэмжье гэдэг томьёоллоор санал хураая. Дэмжих юм бол хойшлуулна гэсэн үг. Дэмжихгүй бол хэлэлцээд явна гэсэн үг. Хойшлууллаа гэж бодоход энэ төлөвлөгөө

маань батлагдах бас хуулийн хугацаатай байгаа. 6 сарын 1 гэхэд хэлэлцсэн байх ёстой байгаа. Тэгэхээр энийг бас бодоорой гишүүд ээ. Тэгээд санал хураалт. Санал 15,4 хувиар дэмжигдсэнгүй.

Тэгэхээр хэлэлцүүлэх ажлаа үргэлжлүүлэе. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийн талаарх Засгийн газрын танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан танилцуулна. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгье.

С.Амарсайхан: Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төслийн талаар та бүхэндээ танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэж, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт Засгийн газар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 5 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Улсын Их Хурал 6 дугаар сарын 1-ний дотор батална гэж тус тус заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан танилцуулж байна.

“Монгол Улсын 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1 дэх заалт, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх гэж, 6.10.2 дахь заалтад санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх гэж заасан шаардлагад нийцүүлэн боловсрууллаа.

Дэлхийн улс орнуудын хамтын хөгжлийн зорилго болсон НҮБ-аас санаачилсан Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний хяналт шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүдийг Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтын шалгуур, үзүүлэлтүүдтэй мөн уялдууллаа.

Дунд хугацаанд макро эдийн засгийн харьцангуй тогтвортой байх боломж өндөр байгаа хэдий ч дэлхий дахинд үүсээд байгаа тодорхой бус байдлын нөлөөгөөр нүүрс, зэс зэрэг манай улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ хэлбэлзэлтэй байна.

2024 онд Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг боловсруулах үед уул уурхайн гол бараа бүтээгдэхүүний үнэ унах эрсдэлийг тооцсон бөгөөд сөрөг нөлөөллийг харьцангуй бага байлгах хүрээнд хил, гаалийн нэвтрүүлэх чадварыг сайжруулж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет

хэмжээг нэмэгдүүлэх, цаашилбал экспортыг төрөлжүүлэх тодорхой ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Засгийн газар түүхий эдийн үнийн эрсдэлээс гадна ган зуд тохиолдох зэрэг байгаль цаг уурын эрсдэл, нийлүүлэлтийн гаралтай инфляцын шок үүсэх эрсдэл, эрчим хүчний хязгаарлагдмал байдал, хилийн боомтууд дээр тээвэр логиستيкийн саатал бий болох зэрэг эрсдэлийг боломжит нөлөөллийн талаар багасгахаар тооцон эрсдэл тохиолдох үеийн сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг бодлогын баримт бичгүүдэд тус тусад нь тусган хэрэгжүүлж байна.

Тухайлбал, хөдөө аж ахуйн салбарт хүнсний нийлүүлэлтийг дэмжих зорилготой хүнсний хувьсгал, хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих Цагаан алт зэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Уул уурхайн салбарт нүүрс баяжуулах үйлдвэрүүд, зэс, гангийн үйлдвэрүүдийн үйлдвэрлэл, технологийн парк хэлбэрээр хөгжүүлэхээр тодорхой ажлууд хийгдэж байна. Мөн эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эрчим хүчний нийлүүлэлтийг дэмжих зорилгоор либералчлахыг үе шаттай хэрэгжүүлж эхэлсэн.

Цаашилбал хилийн боомтууд дээр тээвэр логиستيкийн саатал үүсэхгүй байх зорилгоор зохион байгуулалтыг сайжруулж, зам талбайн өргөтгөлийг барьж байгуулан боомтын үйл ажиллагаануудыг өргөтгөж байна. 2025 онд гадаад эрсдэлээс үүдэлтэй эдийн засаг дахь сөрөг нөлөөлөл хүчтэй байна. Худалдааны дайн, геополитикийн хурцадмал байдал, БНХАУ-ын эдийн засгийн удаашрал зэрэг нөлөөгөөр дэлхий дахинд тодорхой бус байдал Ковид 19 цар тахлын үед тохиолдож байсантай ижил түвшинд хүрч нэмэгдээд байна.

Улмаар манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ 2025 оны эхний улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 40 орчим хувиар унаснаар нийт экспортын орлого өмнөх оны мөн үеэс 17 хувиар буураад байна. Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2025 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 16 хувиар бага байна. Түүхий эдийн үнэ буурсны улмаас бий болсон энэ нөхцөл байдал 2025, 2026 он дамжин үргэлжлэх төлөвтэй байна. Гэсэн хэдий ч хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах замаар Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан том төслүүдийг оновчтой үе шаттайгаар хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлтийг 6-аас дээш хувьд хадгалах боломж байна гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024- 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тодорхойлсон бүсчилсэн хөгжлийн бодлого, хүний хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого, хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэсэн 4 тэргүүлэх чиглэлийг цаашид үргэлжлүүлнэ.

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл нь хүн төвтэй хөгжлийн үзэл санаанд нийцсэн эдийн засгийн эрх чөлөөг цогцлоох төлөвлөгөөг зорьж төсвийн зардлын реформ, төрийн албаны реформ, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформ хэрэгжүүлэх бөгөөд тус реформууд нь ядуурлыг бууруулахад үндсэндээ чиглэгдэнэ.

2026 онд нэн шаардлагатай салбарын реформ тэргүүлэх ач холбогдолтой хөгжлийн 14 мега төслийг эрчимжүүлж, макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, бизнесийн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог эрс багасгах замаар

ядуурлыг бууруулж, эдийн засгийн эрх чөлөөний реформыг хэрэгжүүлнэ. Үүнд төсвийн зардлын реформын хүрээнд төсвийн урсгал зардлыг бууруулж, ДНБ-ий 24 хувиас хэтрүүлэхгүй байх, процессыг нь дахин инженерчлэлийг хийж төрийн үйлчилгээг хялбар, хүн төвтэй, илүү бүтээмжтэй хандлагаар эрчимжүүлнэ. Төрийн албаны реформын хүрээнд төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгаж, төрийн албан хаагчдын тоог багш, эмч нараас бусад салбарынхныг 15 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлж, төрийн байгууллагуудын чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийсний үндсэн дээр зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх замаар төрийн бүтээмжийг дээшлүүлж, төрийн худалдан авах ажиллагаанд хиймэл оюуныг ашиглан ил тод байдлыг сайжруулж үр ашгийг эрс нэмэгдүүлнэ гэж тооцож байна.

Үндэсний баялгийн сан төрийн өмчит компанийн засаглалын реформын талаар:

Энэ хүрээнд төрийн өмчит компаниудын реформыг эрчимжүүлж, зардлыг 15 хувиар бууруулж, төрийн өмчит компаниудын бүтээмжийг 30 хувиар сайжруулж, төрийн өмчит компаниудын хөрөнгийн удирдлагыг илүү сайжруулж, хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлж, үр ашиг, өгөөж, ашигт үйл ажиллагааг улам идэвхжүүлэн сайжруулна.

Баялгийн санг арвижуулж геологи хайгуул болон ашиглалтын түвшнийг нэмэгдүүлэх стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэрэг цогц арга хэмжээ хэрэгжүүлж, стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд бүрэн оруулна гэж төлөвлөж байна.

Бүсчилсэн хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийн эдийн засгийн эрх чөлөөг онцгойлон 1 дүгээрт танилцуулъя.

1.Бүс нутгийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлж, бүсчилсэн хөгжлийн реформыг хэрэгжүүлж, дэд бүтцийг хүртээмжтэй болгож, бүсчилсэн хөгжлийн бодлого, эрх зүйн орчин, тогтолцоог илүү боловсронгуй болгон. Шинэ суурьшлын бүс байгуулах ажлыг эрчимжүүлж, дагуул хотуудын хатуу, зөөлөн дэд бүтцийн бүтээн байгуулалт, эдийн засгийн бүсчилсэн хөгжлийг эрчимжүүлэн дэмжинэ. Хөдөө аж ахуй, мал аж ахуй, аялал жуулчлал, аж үйлдвэр, хүнс, худалдаа, эрчим хүч, үйлдвэрлэл үйлчилгээний салбарыг кластер хэлбэрээр хөгжүүлж, хувийн хэвшлийн оролцоонд тулгуурлан экспортыг дэмжсэн үйлдвэрлэл технологийн паркийг байгуулах замаар бүсийн онцлог, давуу тал, нөөц боломж, эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан хөгжүүлнэ. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд дээрх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр хөдөө, орон нутгийн инженерийн дэд бүтцийн шийдэл бүхий орон сууцад хамрагдсан өрхийг 5683-д, орон нутгийн хөгжлийн индексийг 0,05-д тус тус хүргэнэ.

2.Хүний хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд ядуурал, тэгш бус байдлыг бууруулж, эрдэм боловсролтой эрүүл Монгол хүнийг хөгжүүлнэ. 2026 оны боловсролыг дэмжих жил болгон зарлаж, боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлж, хөрөнгө оруулалтыг өсгөж, 108 сургууль, 95 цэцэрлэгээр нэмэгдүүлж, бүлэг дүүргэлтийг стандарт түвшинд хүргэж, хамгийн сайн цэцэрлэг, сургууль, гэрт ойр хөтөлбөрийг хэрэгжүүлж, хот, хөдөөгийн боловсролын чанарын ялгааг арилгана. Дотоодын болон олон улсын их дээд сургуулиудын хооронд кредит шилжүүлгийн тогтолцоог боловсронгуй болгож, дотоод, гадаадад экспортын

түвшинд суралцаж, экспортын үйл ажиллагааг дэмжиж мөн докторын түвшинд байгаа оюутнуудад зориулсан тэтгэлгийн тогтолцоо бий болгож, дэлхийн шилдэг багш, профессоруудыг Монголд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, сургалтын чанар, багшийн ур чадвар, төгсөгчийн хөдөлмөр эрхлэлт зэрэг үзүүлэлттэй уялдуулан үнэлгээний системийг сайжруулна.

Эрүүл Монгол хүнийг хөгжүүлж, хавдар, зүрх судасны өвчлөлийн эмчилгээний шинэ технологи, туршлагыг нэвтрүүлж, эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийг хиймэл оюун ашиглан боловсронгуй болгож Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж буй тусламж, үйлчилгээний давхардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлнэ. Хүн төвтэй нийгмийн үйлчилгээг нэвтрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээг хүүхэд бүрд хүргэж, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй хөгжлийн цогц үйлчилгээний төвийг аймгуудад байгуулж, зорилтот өрх, хүнийг хөгжүүлэх, чадавхжуулах, бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлнэ. Хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг хамгаалах, дэмжих бодлогыг хэрэгжүүлж, хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн ур чадварт илүү сургах замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах бодлого баримталж, мэдээлэл, харилцаа технологийн ололтод суурилсан хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх төвд нийгмийн үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг өргөжүүлнэ.

Нийгмийн баталгааг хангаж Чингис хаан үндэсний баялгийн сангаар Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан зэргээр дамжуулан ирээдүйд хөрөнгө оруулалт хийх, эрүүл мэнд, боловсрол, орон сууцжуулалт, хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцын хүртээмжийг нэмэгдүүлж, миний түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлж, үргэлжлүүлэн Миний сонголт орон нутаг, Миний амины орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлж, 150 мянган айлын орон сууцыг нийслэл болон хөдөө орон нутагт хүртээмжтэйгээр байгуулж, эдгээр орон сууцын хөтөлбөрийг Монголын аж ахуйн нэгжүүд мөн Монгол Улсын ажиллах хүчнээр гүйцэтгүүлж, ядуурлыг бууруулах гол хэрэгсэл болгосноор орон сууцжуулалт 5 хувиар нэмэгдэнэ.

Монгол хүний хөдөлмөрийн бүтээн цалин хөлс тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, хүний хөгжлийн бодлогын хүрээнд дээрх зорилт, арга хэмжээний үр дүнд ажиллах хүчний оролцооны түвшнийг 63 хувьд, Писа олон улсын үнэлгээний эрэмбийг 52-т тус тус хүргэж, ядуурлын түвшнийг мөн 5 хувиар бууруулна гэж төлөвлөж байна.

3.Эдийн засгийн бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд хүн төвтэй хөгжлийн үзэл санаанд нийцүүлэн бизнесийн орчны реформ ба чөлөөт эдийн засгийг цогцлоох ажлыг эрчимжүүлнэ.

Хүн төвтэй хөгжлийн үзэл санаанд нийцсэн эдийн засгийн эрх чөлөөг цогцлоож, шинжлэх ухаан, инновац, хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологид суурилсан мэдлэг оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах бодлогоор дэмжиж оюуны өмчийн үнэлэмжийг нэмэгдүүлж, тогтвортой хөгжлийн зорилго зорилтуудыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангана.

Шинжлэх ухаан технологийн арга хэмжээний зардлыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. Үүнд, дотоодын бүтээгдэхүүний 0,5 хувийг зарцуулж, шинжлэх ухаан,

инновац, технологид суурилсан мэдлэгийн эдийн засгийн суурийг бэхжүүлнэ. Санхүүгийн салбарын шинэчлэлийг эрчимжүүлж, цахим эдийн засгийн эзлэх хувийг нэмэгдүүлж, ДНБ-д хиймэл оюуны хувь нэмрийг бодитойгоор өсгөж, эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжлийг хангана гэж тооцож байна.

Эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, дамжин өнгөрөх худалдаа, тээвэр логистик үйлчилгээний экспортыг мөн эрчимжүүлэн нэмэгдүүлж, хил холболтын төмөр зам, боомт, чөлөөт бүсийн бүтээн байгуулалтын экспортыг нэмэгдүүлэхэд чиглүүлэн хэрэгжүүлнэ. Нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлж, үйлдвэрлэл, технологийн паркуудын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, үйлдвэрлэлийн салбарт санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлж, шинэ эх үүсвэрүүдийг бүрдүүлэн банк, санхүү, даатгалын салбарын эрх зүйн орчныг шинэчилж, эрсдэлийн удирдлагыг сайжруулан, гадаадын банкны салбар нэгж, хөрөнгө оруулалтыг байгуулах дэмжих нөхцөлийг бүрдүүлэхээр бас төлөвлөж байна.

Жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих, урт хугацаатай, хүү багатай зээлийн бүтээгдэхүүний төрөл хүртээмжийг нэмэгдүүлнэ. Эдийн засгийн бодлогын хүрээнд дээрх зорилт, арга хэмжээг хэрэг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлтийг 6 хувьд хүргэж, инфляцыг 7 хувьд байлгах, хүлээн авах жуулчдын тоог 1,6 саяд хүргэнэ гэсэн тооцоололтой байна.

4.Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд хиймэл оюуныг төрийн бүх шатад нэвтрүүлж, хүн төвтэй төрийн үйлчилгээг бий болгоно. Дэвшилтэт технологи процессын дахин инженерчлэлийг хэрэгжүүлж, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх замаар хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, авлигагүй, хүн төвтэй төрийн үйлчилгээг бий болгоно. Хүний эрхийн хөтөлбөр 2-ыг хэрэгжүүлж, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, улсын батлан хамгаалах бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлж, Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг бататгаж, гадаад харилцааны 1 цонхны бодлого баримтлан энхийг эрхэмлэсэн нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогыг тууштай баримтлан идэвхтэй өргөжүүлнэ.

Төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр процессыг нь дахин инженерчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний хурд, чанарыг сайжруулж, үр ашиггүй давхардсан үйлчилгээг халж, цахим шийдлийг нэвтрүүлэх, бүрэн хэрэглэх замаар зардлыг бууруулж, зорилтот хүн, хуулийн этгээдэд проактив хэлбэрээр хүргэхээр дахин инженерчилж ажиллаж байна.

Төлөвлөлт, төсөвлөлт, хяналт үнэлгээний платформыг хөгжүүлж, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн сан, тогтолцоо, процесс, санхүүжилтийн орчныг улам сайжруулахаар ажиллаж байна. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэх мөн гамшигтай тэмцэх салбарын бааз суурийг нэмэгдүүлэх, хиймэл оюун орчин үеийн техник технологид суурилсан Зэвсэгт хүчнийг хөгжүүлж, цэргийн аж үйлдвэр, дэд бүтцийг хөгжүүлэх, батлан хамгаалах бие даасан байдлыг хангах, иргэдэд эх оронч үзлийг төлөвшүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулна.

Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд дээрх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийг 103-д, авлигын

индексийг 112, шүүхийн индексийг 57-д, шударга байдлын үнэлгээг 78 тус тус хүргэн цаашид ахиулна гэсэн төлөвлөгөөтэй байна.

4 бодлогын тэргүүлэх чиглэлийг амжилттай хэрэгжүүлснээр 2026 онд эдийн засгийн өсөлтийг 6 хувьд хадгалж, 1 хүнд ноогдох ДНБ-ийг 8090 ам.долларт хүргэж ядуурлын түвшнийг 5 хувиар бууруулахаар төлөвлөсөн. Хөгжлийн бодлогын төлөвлөгөөний товч танилцуулгыг та бүхэнд хийлээ.

Ингээд Эдийн засаг, хөгжлийн яамнаас бас дэлгэрэнгүй танилцуулгыг дэлгэц дээр та бүхэнд хийнэ. Ерөнхийдөө бараг танилцуулчихсан учраас шууд явъя.

Р.Батболд: Эдийн засаг, хөгжлийн яам танилцуулах юм уу. Хэрэггүй болсон уу. Шаардлагагүй болсон уу. Ажлын хэсгийг танилцуулъя. Сайнбуянгийн Амарсайхан Монгол Улсын Шадар сайд, Эрдэнэбилигийн Одбаяр Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга, Чинбатын Номин Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Тогтмолын Мөнхсайхан Эрүүл мэндийн сайд, Т.Даваадалай Нийслэлийн Засаг даргын орлогч, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Донжчинбуугийн Бямбадорж Гадаад харилцааны яамны Бодлогын газрын дэд захирал, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нэргүй Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Батсайханы Өнөмөнх Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Даваадоржийн Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Цэцэгмаагийн Уртнасан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ханджавын Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвасүрэнгийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Адьяасүрэнгийн Даваажаргал Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сүхбаатарын Төмөрхүү Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төмөр-Уяагийн Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Пушаагийн Алтан-Од Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Дагвадоржийн Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Шаравын Мөнхцэрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга, Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Анандын Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга, Цэвээндоржийн Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Доржготовын Баттогтох Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга, Пүрэвдоржийн Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа худалдааны нэгдсэн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга, Эрдэнэдэлгэрийн Түвшин Эдийн засаг, хөгжлийн яамны салбарын шинэчлэлийн нэгдсэн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төмрийн Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Жигжидсүрэнгийн Өнөржаргал Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт шинжилгээ,

үнэлгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагвасүрэнгийн Балчинлуvsан Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хуягцогт Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батбаяр Зам, тээврийн яамны Бодлого, зохицуулалтын газрын дарга, Энхтүвшин Эрчим хүчний яамны Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Райымбек Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Галиндэвийн Отгонцэцэг Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Даваасамбуугийн Дэлгэрмаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Түмэндалайн Даваадалай Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан 1 дүгээр орлогч, Дугаржавын Амгалан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Чинбатын Төгсдэлгэр Нийслэлийн ерөнхий архитектур, Пагмажавын Хадбаатар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Болдбаатарын Гантулга Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Улаанхүүгийн Баатар “Сэлбэ 20 минутын хот корпорац” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Д.Энхтуул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч. Ажлын хэсгийг танилцууллаа.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Мөнхсоёл гишүүнийг оруулъя. Ирцээрээ ороод байх шиг байна. Мөнхсоёл гишүүнээр тасалъя. Нэрсийн дарааллаар Бадрахын Найдалаа гишүүн асуулт асууя.

Б.Найдалаа: Баярлалаа. Товчхон хэдхэн асуулт асууя. Засгийн газраас өмнө нь баталсан хөтөлбөр, бодлого дээр 14 мега төсөл гэж байгаа. Тэрийг батлаад, сонгуулиас хойш ажилд ороод бараг 1 жил боллоо. Тэгээд энэ дээр төслүүдтэй холбоотой үр ашгийн эрэмбийн, ач холбогдлын тооцоо судалгаа хийгээд, одоо ямар нэгэн байдлаар эрэмбэ дараа нь өөрчлөгдсөн байдал, эсвэл хасагдах гэж байгаа, нэмэгдсэн ч юм уу тиймэрхүү өөрчлөлт байгаа юу. Бүгдийг нь баталсан чигээрээ ингээд цаашаа явах юм уу. Эсвэл ямар нэгэн тодотгол хийж өөрчлөх юм уу. Олон улсын байдал, эдийн засгийн дотоод байдал, гадаад, дотоод орчин, нөөц, санхүү, хөрөнгө оруулалт гээд бүх юм өөрчлөгдөж байгаатай холбоотой. Энэ дээр ямар нэгэн өөрчлөлт байгаа юу. Эсвэл тэр чигээрээ 14-өөр явах уу.

2-т нь улсын төсвийг алдагдалгүй батална гээд батлуулчихсан. Гэхдээ энэ нь өөрөө алдагдалгүй гээд гоё сонсогдож байгаа боловч яг бодлого талаасаа, мэргэжил талаасаа буруу зүйл гэж үзэж байгаа. Улсын төсвийн бодлого чинь өөрөө алдагдалтай байх, ашигтай байхаараа л дамжиж хэрэгждэг болохоос биш алдагдалгүй гээд таалагдчихаад, хэрэгтэй юмаа санхүүжүүлж чадахгүй, хэрэггүй зүйлд мөнгөө үрээд байхыг хэлэхгүй. Тийм болохоор энэ дээр цаашдаа алдагдалгүй гэдэг дээрээ ингээд яваад байх юм уу. Тэгэхээр ингэх юм төсвөөс биш төсвийн гадуур дахиад төсөв бий болох хандлага, юунууд төрөөд байна л даа. Янз янзын зөв, буруу шийдлүүд. Хөрөнгө оруулалтын ч байна уу, урсгал

зардлын ч байна уу. Энэ дээр Засгийн газар цаашдаа яах юм. Алдагдалгүй төсвөө өргөн барьсаар байх юм уу. Эсвэл өөр бодлого байна уу.

2026 оныг боловсролын жил гэж зарласан. Зарлах нэг хэрэг, тэгээд яг ямар хөрөнгө оруулалт дээр сургууль байна уу, аль чиглэлд урсгал зардал байна уу. Ер нь боловсролын салбарт нэгэнт зарласан юм бол яг ямар хөрөнгө оруулалт дээр ямар зардал дээр, ямар ажил дээр ялгаа гаргах гэж байгаа юм бэ. Энэ дээр жоохон тодорхой мэдээлэл өгөөч. Тэр энэ дотор байна уу. Боловсролын жил гээд яг яах гэж байгаа юм.

Төрийн албаны реформ гээд энэ дээр төрийн албаж албан хаагчдын тоог 9 хувь бууруулна гэхихсэн байна. Зөв. Гэхдээ энэ бас яг тодруулах хэрэгтэй байна. Нөгөө ангиллуудаа яаж өөрчлөх гэж байгаа юм. Хаанаас нь 9 хувь, яаж энэ тоог гаргасан юм бол. Хаанаас нь танах гэж байгаа юм. Энэ талаар мэдээлэл өгөөч гэсэн ийм 4 асуулт байна.

Р.Батболд: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

С.Амарсайхан: Найдалаа гишүүний асуултад хариулъя. 14 мега төсөл хэвээрээ үргэлжилж байгаа. Эрдэнэбүрэн, өнөөдөр нээлтийг нь хийж байгаа Гашуунсухайт, тэгээд нефть боловсруулах үйлдвэр, цаашлаад төмөр замын болон авто замын гээд томоохон төслүүд үргэлжилнэ. Эдгээр 14 төсөлд нийтдээ 43,2 их наяд төгрөгийн санхүүжилт хэрэгтэй гэж туссан байгаа. Мэдээж энэ 14 төсөл бол Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан, тэр дундаа тэргүүлэх чиглэл гэж явж байгаа бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдаж бүсийн хөгжлийг дэмжих, орон нутгийн бие даасан байдлыг бий болгох, ялангуяа эдийн засгийн үйлдвэрлэл зах зээлжсэн ийм тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгдсэн төсөл, хөтөлбөрүүд учраас энэ төсөл хөтөлбөрүүд цаашаа хэвээрээ үргэлжилнэ гэж ойлгож болно.

Дараагийн асуудал бол энэ улсын төсвийн алдагдалтай байдал гэдэг бол ер нь зүгээр энэ төсвийн бодлого талаасаа мэдээж алдагдалгүй улс орны төсөв батлагдаж байвал сайн. Гэхдээ бид хөгжиж байгаа улс орон, дээрээс нь зах зээлээ тэлэх ёстой, нөгөө талаараа эдийн засгийн эргэлтийг бий болгож, төсөв, санхүүгийн эх үүсвэрүүдийг нэмэгдүүлж байж, нэгэнт бид төсөв зарж байж дараагийн орлого, үр өгөөжөө хүртэх ёстой учраас хэт шууд хумьж төсвийг алдагдалгүй байна гэдэг бас нэг тийм оновчтой сайн бодлого биш гэж үзэж байгаа. Тэгэхдээ энийг бол эцсийн байдлаар Улсын Их Хурал төсвийг эцэслэн батлах бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэж байгаа учраас цаашдаа бид хэрвээ улсын төсвийг алдагдалгүй батална гэвэл төсвөөс гадуурх төрөл бүрийн санхүүжилтийн хэрэгслүүд нэмэгдэх, тэр хэрээрээ бас тооцоолол судалгааг нарийвчилж хийх шаардлагууд үүснэ. Манай нөхцөлд бол төсвийг тэнцвэржүүлэх, эсвэл алдагдалгүй байлгана гэдэг бол тийм ч оновчтой шийдэл биш гэдгийг олон талаас нь бид ойлгож байгаа байх гэж бодож байна.

Боловсролын салбарт нийтдээ 39 төсөл 1,3 их наяд төгрөгийн төсөл санхүүжилт, төсөл хөтөлбөрүүд хэрэгжинэ. Энэ төсөл хөтөлбөрүүдээс ерөнхийдөө бол ирэх жил, ялангуяа энэ боловсролын реформыг хийх, боловсролын жилийг 26 он болгож зарласантай холбогдуулан 102 цэцэрлэг, 95 сургууль, тэрнээс 32 нь ирэх жил ашиглалтад орно гэсэн ийм төлөвлөгөө, хэрэгжилттэй явж байгаа. Боловсролын жилийг бид бас ялангуяа энэ эрдэм боловсролтой монгол хүнийг

дэмжих, ирээдүйд илүү өрсөлдөх чадвартай, бүс нутаг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэдлэг, тэр дундаа хөрвөх чадвартай, өрсөлдөх чадвартай ийм Монгол иргэнийг хүмүүжүүлж, төлөвшүүлж боловсруулахад энэ.../минут дуусав/

Р.Батболд: Гүйцээж хариулах уу. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

С.Амарсайхан: Төсвийн зарим, багагүй хувиуд бас тавигдаж байгаа. Жишээ нь үндэсний баялгийн сангаар дамжуулж хуримтлалын нэрийн дансанд төвлөрүүлэх хөрөнгө төсөл хөтөлбөрүүдээс энд ажиллах хүчин оролцооны түвшин, писа олон улсын үнэлгээг бид цааш нь ахиулах гэх мэтийн олон ажлууд, нийгмийн баталгаа багш нар, боловсролын салбарын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, ялангуяа хүн төвтэй төвтэй нийгмийг цогцлоох гэдэг энэ Засгийн газрын үндсэн зорилтыг хэрэгжүүлэхэд цааш нь олон төрлийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

Зөвхөн боловсролын салбарын асуудлыг сургууль, цэцэрлэгээр хэмжихгүйгээр орон сууц, багш, ажилтан, албан хаагчдын оюутан, сурагчдын дотуур байр гэх мэт төсөл хөтөлбөрүүдэд тодорхой хөрөнгө оруулалтуудыг тавьсан байгаа.

Р.Батболд: Найдалаа гишүүн тодруулах уу. Болсон уу. Нөгөө төрийн албан хаагчдын тоог буулгах, цомхотгох гэсэн энэ дээр хэн хариулах вэ. Ажлын хэсгийн 2 номер. Хэн хариулах юм.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар Эрдэнэбат. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд төрийн албаны цогц шинжилгээ хийнэ. Процессыг нь дахин инженерчлэл хийнэ гэсэн заалтууд орсон байгаа. Мөн дээрээс нь 2026 оны нөхцөл байдал, прогнозыг авч үзэхээр эдийн засаг нэлээд бас эрсдэлтэй тоонууд байгаа. Тийм учраас ер нь агуулгын хувьд төрийн урсгал зардлыг бууруулах, урсгал зардлыг бууруулсан хэмжээгээрээ шинэ бүтээн байгуулалт руу, шинэ төслүүд рүү жишээлэхэд саяын хэлсэн боловсролын томоохон төсөл хөтөлбөрүүд рүү зарцуулахаар ийм бодлого явж байгаа. Энэ хүрээнд төрийн албан хаагчид, тэр тусмаа төрийн албан хаагч дотор багш, эмч нарыг оруулахгүйгээр энэ тоонуудыг бид нар судлаад явж байгаа. Саяын процесс .../минут дуусав/

Р.Батболд: Найдалаа гишүүн тодруулж асуух уу. Хүн болгон гүйцээвэл болохгүй шүү дээ. Тодруулаад дахиад асуух уу.

Б.Найдалаа: Тэгээд яах юм. Оршил ярьж байгаад дуусчхаад байх юм уу. Би зүгээр юу л асуусан юм л даа. 9 хувь бууруулна гэсэн. Багш, эмч нараас бусдыг нь бууруулах юм байна зөв үү. Зүгээр энэ дээр дараа нь тодруулаад хариулчих байлгүй. Саналаа хэлчихье. Мега төсөл дээр би жишээлбэл Засгийн газраас энийг ингээд эрэмбэлээсэй гэж бодож байгаа. Богд уулын нүхлэхийг хүндлэл талаасаа ч, төсөв, үр ашиг талаасаа ч, байгаль орчин талаасаа ч энэ бол дэмжмээргүй санагдаж байгаа юм. Энэ дээр Засгийн газар эрэмбэлээсэй гэж бодож байгаа юм. Төсвийн алдагдлыг Их Хурал биш, төсвийг өөрсдөө алдагдалгүй гэдгээ өргөн барьж байгаа нь Засгийн газар юм чинь алдагдалтай байлгая гэж байгаа бол тэрийгээ бас зоригтой өргөн бариасай гэж бодож байгаа юм. Тэгээд тэр төрийн албаны зөвлөлтэй холбоотой төрийн албаны албан хаагчдын юутай холбоотой тодруулаад асуугаад дуусъя.

Р.Батболд: Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Ц.Эрдэнэбат: Энэ хүрээнд түрүүний процессын дахин инженерчлэлийн хүрээнд энэ тоонуудаа бид нар эцэслэн тулгана. Одоогийн бол прогноз тоогоор бол захиргааны албанаас 10 хувь, төрийн тусгай албанаас 25 хувь, үйлчилгээний албанаас 9 хувь, улс төрийн албанаас 9 хувь гэсэн урьдчилсан судалгаа тооцоо гарсан явж байгаа.

Р.Батболд: Амарсайхан сайд хариулъя гэсэн үү. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

С.Амарсайхан: Ер нь төрийн албаны ялангуяа төрийн бүтээмжийг дээшлүүлэхтэй л холбоотой асуудал яригдаж байгаа. Та хэд маань бас энийг олон жил ярьж байгааг мэдэж байгаа. Тэгээд энэ бол давхардуулахгүй байх чиг үүргийг, нөгөө талаасаа үргүй зардлыг бууруулах замаар төсвийн алдагдлыг бий болгохгүй, төсөвт ямар нэгэн ачаалал үүсэхгүй байхад энэ төрийн албаны ялангуяа төрийн төсвийн байгууллагуудын үйл ажиллагааг цомхотгох асуудлууд төлөвлөгдөж байгаа. Тэгэхдээ энэ илүү оновчтой байх талаас нь харж байгаа. Аливаа зүйлд их айхтар хэт явцуу байдлаар туйлширч хандаж хэтэрхий бас буруу зөрүү таналт хийхгүйгээр хамгийн оновчтой хэмнэлтийг хийнэ гэж зорьж байгаа. 1 дүгээрт.

2 дугаарт 14 мега төсөл бол өөрөө эрэмбэлэгдээд явж байгаа. Эрэмбэлэгдэхдээ, салбараараа, мөн нийгмийн ач холбогдлоороо зөвхөн эдийн засгаас гадна нийгмийн урт хугацааны үр ашиг нь юу байх юм..../минут дуусав/

Р.Батболд: Ажлын хэсэг Салдангийн Одонтуяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд орж ирсэн байна. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Энэ өдрийн мэндийг бүгдэд дэвшүүлье. Энэ эдийн засгийн хөгжлийн оны төлөвлөгөө дээр энэ макро тогтвортой орчныг бүрдүүлэх талаар ямар ажил хийх вэ гэдгээ бас тодорхой хэмжээнд хэмждэг ийм төлөвлөгөөтэй болмоор байна. Яагаад энийг ярьж байна вэ гэхээр би Их Хурлаас баталсан нөгөө зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийг хянах ажлын хэсгийг ахалж ажиллаж байгаа. Тэгээд энийг ярихаар эргүүлээд макро тогтвортой орчин бүрдэхгүй байгаа учраас ингээд зээлийн хүү буурахгүй байна гээд яриад байдаг.

Гэтэл манай улсын 2024-2028 оны төлөвлөгөө ч гэдэг юм уу, энэ дээр макро тогтвортой орчныг бүрдүүлэхийн төлөө тэр нь ямар үзүүлэлтүүд байгаа юм, тэрэнд яаж хүрэх гээд байгаа юм. Энэ жилийн төлөвлөгөө нь яагаад зөрөөд байгаа юм бэ гэдэг талаар ерөөсөө ямар ч мэдээлэл байхгүй. Эсвэл тийм мэдээлэл байгаа юм уу. Эдийн засгийн хөгжлийн яаманд Макро тогтвортой орчныг бүрдүүлэх үзүүлэлтүүд нь ийм ийм үзүүлэлт байгаа юм. 2026 оны хувьд ийм байхаар байна. 2025 онд ийм болчихлоо.Одоо бид нар 2028 онд хүрэхийн тулд ингэмээр байна гэсэн ийм төлөвлөгөө байгаа юу гээд 1 асуулт б байгаа юм. Хэрвээ байхгүй байдаг бол энийг бүгдээрээ жил болгон энийгээ ярьдаг, яаж хазайгаад байгаа юм. Энэ 2026 оны хувьд бид нар яагаад үүнээс зөрөх гээд байгаа юм. Зөрөх шалтгаан нь юу юм. Тэгвэл бид нар зайлшгүй ийм шаардлагын үүднээс энийг хийх гээд байна гэдгийг тайлбарладаг ийм болмоор байна гэдэг 1 дүгээр асуулт байгаад байна.

Дараагаар нь болохоор бид нар дотооддоо өөрсдөөсөө Монгол Улсын өөрийнх нь дотоод нөөц бололцоогоор хийх боломжтой зүйлээ бүрэн гүйцэт хийх дээр анхаармаар санагдаад байгаа юм. Сая ингээд ноолуурын асуудал яригдсан. Жилдээ 10 мянган тонн ноолуур авдаг. Энд бол ойролцоогоор 1,2-1,5 их наяд төгрөг хэрэгтэй болдог юм байна. Тэгвэл хэрвээ Монгол Улсын дотоодын ноолуурын үйлдвэрүүд утас ээрэх хүчин чадал нь бүгдийг нь авах хүчин чадалтай байдаг бол тэрийг 3, 4 сард бүгдийг нь авъя л даа. Тэгээд ноолуурын үйлдвэрүүд утсаа ээрээд зарсных нь дараагаар мөнгийг нь цуглуулаад буцаагаад өгдөг ийм санхүүжилтийн хэлбэрүүдийг шийдмээр байна гээд байхгүй юу. Тэгэхгүй бид нар тэр 1,2 их наядаас хэдийг нь шийдээд байгаа юм. Хөдөө аж ахуйн яамны санхүүжилтийн схемээр. Тэгэхээр энэ дээр 2026 онд энэ тал дээр ямар ажлууд төлөвлөсөн байна вэ гэж 2 дахь асуулт байгаад байна.

Дараагаар нь болохоор энэ төрийн албаны реформ хийнэ гээд танилцуулга дээр болохоор 15 хувиар бууруулна гэхихсэн байна. Яг тогтоолын төсөл дээр болохоор бол 9 хувиар бууруулна гэхихсэн байна. Аль нь зөв юм гээд. Ер нь хэрвээ бууруулна гэх юм бол энэ бууруулж байгаагийн чинь хэдэн хувь нь цахимжилт гээд бид нарын хийгээд байгаа хөрөнгө оруулалтаас болж байгаа юм бэ гэдэг асуулт байгаад байгаа.

Дараагийн асуудал нь болохоор бол төрийн өмчит компаниудын цалин бол төсвийн ажиллагсдаасаа бараг 2, 3 дахин их. Хувийн компаниудынхаас 4 дахин их болчихсон байна. Тэгвэл төрийн өмчит компаниуд дээр хийж байгаа энэ бүтээмжийн хэдэн хувийн өсөлт ажиллагсдын бүтээмжийн өсөлт 30 хувиар гээд байдаг яг ажиллагсдын тоотой холбоотой асуудал хэд байгаа юм бэ гэдэг ийм асуулт байна.

4 дүгээрт бол энэ 2025 онд бидний харж байгаагаар нүүрсний экспорт маань буураад 1,2 тэрбум доллароор нүүрсний экспорт тасарлаа гээд яриад байна. 2026 онд хэрвээ энэ байдал хэвээр үргэлжлэх юм бол ер нь эдийн засаг ер нь цаашдаа буурах, агших чиг хандлагатай болох гэж байна.

Р.Батболд: Соронзонболд гишүүнд 1 минут өгье.

Л.Соронзонболд: Тэгэхээр энийгээ дагаад борлуулалт буурна. Аж ахуйн нэгжүүдэд бас байдал хүндэрнэ. Тэгэхээр ер нь аж ахуйн нэгжүүдээ дэмжих талаар 2026 онд ер нь ямар бодлогын арга хэмжээ авах гэж байгаа юм бэ. Татвар талаасаа, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны зардлыг бууруулах талаас ямар арга хэмжээ төлөвлөж байна вэ.

Р.Батболд: Эдийн засаг, хөгжлийн яам. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

И.Батхүү: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Ер нь макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд бол төсвийн хүрээний мэдэгдэл дээр яг Улсын Их Хуралд өргөн баригдаад бас зэрэг хэлэлцэгдээд явж байгаа. Тэр дээр бол ирэх 3 жилийн хугацаанд эдийн засгийн гүйцэтгэл цаашдаа ямар хэлбэрээр эдийн засаг маань өсөх юм бэ, орлого, зарлагаа яаж тооцож байгаа юм бэ, энэ дээр гол эдийн засгийн орлогын бүрдүүлж байгаа хөдөө аж ахуйн салбарын нөхцөл, уул уурхайн салбарын нөхцөл байдал ямар байх юм бэ гэдэг тоонууд яригдана. Тэр дээр бас нарийн дэлгэрэнгүй мэдээллийг өгөх боломжтой. Яг одоо эдийн засгийн тогтвортой байдлыг үзүүлэх гол үзүүлэлтэд бол инфляц байгаа. Гадаад валютын

албан нөөц байгаа. Төсвийн алдагдлыг бууруулах асуудал байгаа. Засгийн газрын өрийн асуудлууд байгаа. Эдгээр асуудлуудыг бол төсвийн хүрээний мэдэгдлийн үеэр дэлгэрэнгүй ярих боломжтой.

Таны хэлж байгаа зээлийн хүүтэй холбоотой гол анх гарах ёстой асуудал бол инфляц байгаа юм. Инфляцын нийлүүлэлтийг 2 талаасаа авах юм бол гадаад гаралтай инфляц, дотоодын гаралтай инфляц гэж үзэж байгаа юм. Гадаад гаралтай инфляц бол мэдээж бүс нутгийн тээвэр логистикийн нөхцөл байдал, геополитикийн асуудлууд тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа. Дотоод нийлүүлэлтийн асуудлууд бол хөдөө аж ахуйн салбарт явж байгаа хөтөлбөрүүд байгаа. Хүнсний хувьсгал, Цагаан алт, Атрын 4 гэх мэтчилэн. Энэ авч хэрэгжүүлж байгаа бодлогын арга хэмжээний үр дүнд бол дотоодын инфляцыг бууруулах ёстой. Тэгэхээр товчхондоо хэлэх юм бол зээлийн хүүг бууруулах гол макро нөхцөл бол инфляцыг бууруулах байгаа.

Р.Батболд: Энэ дотоод нөөц бололцоо, ноолууртай холбоотой асуудал Хөдөө аж ахуйн яам хариулъя. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Т.Жамбалцэрэн: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн. Түүхий эд бэлтгэл, нөөцтэй холбоотой, ялангуяа манай салбар дээр хамгийн үнэтэй бүтээгдэхүүн бол цагаан алт ноолуур байгаа. Энэ жилийн тухайд Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд ноолуур бэлтгэлд нийтдээ 320 тэрбум төгрөгийн эх үүсвэр арилжааны банкны эх үүсвэрээр эргэлтийн хөрөнгийн зээл гаргасан. Энэ дээр нэмэгдээд 100 тэрбум төгрөгийн нэмэлт эргэлтийн хөрөнгийг гаргаад, үндсэндээ нийтдээ 420 тэрбум төгрөг эргэлтийн хөрөнгөд гарч байгаа.

Таны дурдсан үндсэндээ 1,2 их наядын эх үүсвэрийн 3-ны 1-ийг нь л өнөөдрийн байгаа бололцоогоороо шийдвэрлэж байгаа. Энэ жилийн тухайд нэмэлт эх үүсвэр дээр арилжааны банктэй гэрээ байгуулаад, виксель гаргах энэ чиглэлээр ажиллаж байна. Ойрын хугацаанд арилжааны банкнуудтайгаа гэрээ байгуулаад, эх үүсвэрийг нэмэгдүүлээд эхэлнэ. Цаашдаа .../минут дуусав/

Р.Батболд: Гүйцээн хариулах уу. Ажлын хэсгийн 2 номер.

Т.Жамбалцэрэн: Цаашдаа таны хэлсэнчлэн энэ санхүүгийн арга хэрэгсэл арилжааны банкнууд зээл олгох, санхүүжүүлэх хэлбэр дээрээ бид нар жишээ нь санаачилга гаргах шаардлага байгаа. Энэ чиглэлээр бол ямар ч байсан арилжааны банкнуудтайгаа эхний ээлжид виксель гаргахаар ажиллаад, энэ маань үр дүнтэй болох юм бол дараа дараагийн жилүүдэд нөөцөө бүрэн хангаад явах бололцоо бүрдэх болов уу гэж ингэж харж байна.

Р.Батболд: Хөрөнгө оруулалтын чиглэл дээр ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

С.Амарсайхан: Соронзонболд гишүүний асуусан тэр төсөвтэй холбоотой асуудал дээр ялангуяа энэ төсвийн сахилга бат, цаашлах юм бол бид мөнгөний бодлого, гадаад тэнцэл, тэгээд урт хугацааны хөгжлийн бодлого, бүр нарийн яривал энэ институцийн чадавх гээд олон асуудлуудаас энэ төсвийн үр ашигтай байдал, ялангуяа энэ макро эдийн засгийг тэнцвэр төржүүлэх, гадаад экспортоо төрөлжүүлэх, төсвийн зээл тусламжийн зарцуулалтаа илүү үр дүнтэй болгох гээд

маш олон хүчин зүйлүүдээс энэ макро эдийн засгийн асуудал өөрөө шалтгаалдаг, хамаардаг учраас бүх чиглэлээр илүү нарийн төлөвлөлт тооцоотой уялдаа холбоотой ажиллах шаардлага байгаа. Энэ чиглэлээр Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамнууд төсвийн бодлого Монголбанктай мөнгөний бодлогын асуудлуудтай уялдуулж, макро эдийн засгийг тэнцвэржүүлж илүү алдагдалгүй байлгах талаас нь .../минут дуусав/

Р.Батболд: Төрийн өмчийн компани, цалин, бүтээмж ажилчдын тоотой холбоотой төрийн өмчийн хороо хариулах уу. Ажлын хэсгийн 6 номер дээр очиж суухгүй бол наадах чинь ажиллахгүй байгаа. Суудлаа солихгүй бол.

Д.Дэлгэрмаа: 2023 оны байдлаар бол нийт төрийн өмчит аж ахуйн нэгжийн ажиллагсдын тоо бол 58 мянга ажиллагсдын тоо байгаа. Зардлыг 15 хувиар бууруулж, ашигт ажиллагааг 30 хувиар нэмэгдүүлэх ийм тооцоо төлөвлөгөө оруулж байгаа.

Төрийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах хууль маань өргөн баригдчихсан байгаа. Тэгээд энэ хуулийн хүрээнд төрийн өмчит компанийн алдагдалтай ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдийг татан буулгах, нэгтгэх, нийлүүлэх, бүтцийн өөрчлөлтөд оруулах ажиллагаанууд мөн хийгдэж байгаа.

Р.Батболд: Батхүү дарга хариулах уу. Төрийн албаны цахимжилтын талаар асуугаад байна. Яаж бууруулах гээд байгаа юм. Цахимжилттай холбоотой байна уу, үгүй юу гээд.

И.Батхүү: Соронзонболд гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Төрийн албаны төрийн бүтээмжийг сайжруулах том хөтөлбөр арга хэмжээнүүд шат шатад авч хэрэгжүүлж байгаа. Энэ дээр бол боломжтой газрууд нь процессын инженеринг хийгээд, төрийн албанд хийгдэж байгаа ажлуудыг илүү оновчтой бүтээмжтэй болгох, хүний орон тоог аль болох нэмэгдүүлэхгүй байх, цаашдаа тэтгэвэрт гарч байгаа төрийн албан хаагчдын оронд шинээр орон тоонд авахгүй байх зэрэг арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж болно. Тэгээд нөгөө сүүлийн үед хөгжиж байгаа хиймэл оюун ухааныг төрийн худалдан авалт, бусад төрийн үйлчилгээнд нэвтрүүлэх. Өнөөдөр хүртэл гарсан e-mongolia гэдэг ч юм уу, e-government амжилтуудыг бататгаж, илүү дараагийн шатад хүргэх ажлуудыг ер нь төлөвлөж хэрэгжүүлэхээр тусгасан байгаа.

Р.Батболд: Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Тэгэхээр төрийн албаны реформ 9 хувиар хийлээ гэхэд бид нар жил болгон мэдээллийн технологийн чиглэлээр маш их хөрөнгө оруулалт хийж байгаа. Системүүд олон худалдаж авч байгаа. Ингээд цахимжилт гээд л яригдаад байдаг. Энэ цахимжилт чинь явсаар байгаад ажиллагсдын тоон дээр хэдээр бууж байгаа юм бэ л гэж маш энгийнээр асууж байгаа шүү дээ. Тэгэнгүүт та зүгээр 9 хувиар гээд л тооцчихоод байна. Тэр тооцоо чинь цаанаа цахимжилтаас хамаарсан процессын реинженерээс хамаарсан нь хэд юм. Эсвэл бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотойгоос хамаарсан нь хэд юм бэ л гэж асууж байгаа шүү дээ 1 дүгээрт.

2 дугаарт зээлийн хүүг бол зөвхөн инфляцаас гэж Эдийн засаг, хөгжлийн яам бодохоо болих хэрэгтэй. Түрүүн харин Амарсайхан сайд маш зөв хариулж байна. Макро эдийн засгийн бүтэц маань өөрчлөгдөх хэрэгтэй байгаад байна шүү дээ. Түүнийг хийхийн төлөө юу хийгээд байгаа юм бэ л гээд асуугаад байгаа байхгүй юу.

Дараагаар нь тэр аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны зардлуудыг бууруулах талаасаа яг засгийн зүгээс татвар дээр, бусад зүйл дээр юу хийх гэж байгаа юм бэ л гэж асуусан шүү дээ.

Р.Батболд: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

И.Батхүү: Соронзонболд гишүүний холбогдсон макро эдийн засгийн тогтвортой байдлынх нь 1 асуудлыг энд дурдсан нь инфляц байгаа. Мэдээж олон хүчин зүйлээс хамаарна. Банкны салбарын үр ашигтай үйл ажиллагаа, зээлийн хүүгийн зардлын өртөг, бүрдэлт дээр холбоотой илүү оновчтой болох асуудлууд яригдана. Дээр нь нэмээд банкны секторт илүү реформын шинж чанартай ажлуудыг зоригтой хийх хэрэгтэй. Гадаадын хөрөнгө оруулалттай банк, бусад арилжааны банкуудыг, ер нь салбарыг нь өөрчлөх шаардлагатай гэж үзэж байгаа. Энэ талаар урт хугацаанд олон асуудал яригдаж ирсэн. Хэрэгжилт сул байгаа. Энэ дээр анхаарах ёстой.

Цахимжилттай холбоотой тэр их олон процесс, олон үйл ажиллагаа явагдах учраас яг нарийвчлан энэнээс нь тэдэн хувь, энэнээс нь тэдэн хувь гэж гаргахад хэцүү байна. Саяын дурдсан тоо орон тоо бууралттай холбоотой хэмнэгдэх зардлуудын тооцоо бол бидэнд байж байгаа.

Р.Батболд: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

С.Амарсайхан: Аж ахуйн нэгжийн маш чухал асуулт Соронзонболд гишүүн сая асуулаа. Энэ аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хэрхэн дэмжих юм бэ. Татвар хураамжийг яах юм бэ гэж байна. Татварын ачаалал дарамтыг бууруулах зайлшгүй шаардлага бий. Эдийн засгийг тэлэхийн тулд бид аж ахуйн нэгжүүдээсээ зөвхөн татвар хураамж татах биш, эргээд илүү их өгөөжийг бүрдүүлж, татварынхаа бааз хүрээг нэмэгдүүлэх, эдийн засгаа тэлэх, макро эдийн засгийнхаа үзүүлэлтүүдийг сайжруулах чиглэлд ажиллахын тулд бид нар энэ Татварын ерөнхий хууль мөн энэ ААНОАТ, ХХОАТ-тай холбоотой хөрөнгө оруулалтын хуулиудад өөрчлөлт оруулах, нэмэлт, өөрчлөлтийг хийх зайлшгүй шаардлага байгаа. Тэгээд энэ чиглэлээр холбогдох байгууллагууд ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Удахгүй Засгийн газраас Улсын Их Хуралд эдгээр хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар энэ аж ахуйн нэгжүүдийн татварын ачааллыг бууруулж, илүү бизнес, аж ахуй эрхлэхэд таатай орчин нөхцөлийг бүрдүүлж эцэст нь улсын эдийн .../минут дуусав/

Р.Батболд: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

И.Батхүү: Амарсайхан Шадар сайдын хэлсэн дээр нэмээд хэлэхэд Эдийн засаг, хөгжлийн яамнаас татварын ачааллыг бууруулах чиглэл дээр макро агуулгаараа бол зорилтыг тавиад, төсвийн хүрээний мэдэгдэл дээрээ оруулаад явж байгаа. Тухайлбал нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ нь ДНБ-д эзлэх хувь хэмжээ гэж үзүүлэлт байдаг. Энийг бол бид нар 2026 онд 31,7

хувь, 2027 онд 30,4 хувь, 2028 онд 29,6 хувь болгож бууруулна гэсэн зорилт тавьсан байгаа. Энэ нь цаад агуулгаар бол татварын шинэчлэл хийх орон зайг нь гаргаж өгч байгаа гэсэн үг. Татварын багц хуулийн асуудал бас тусгай ажлын хэсгүүд гараад, холбогдох яам нь хариуцаад ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Р.Батболд: Нүүрсний экспортын орлого буурсантай холбоотой Сангийн яам хариулах уу. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя. Нүүрс дээр биет хэмжээний хувьд өнөөдрийн байдлаар Монгол Улс нийт 25 орчим сая тонн нүүрс экспортолсон. 2024 оны бас өнгөрсөн оны мөн үе дээр бол биет хэмжээний үнэд бол бууралт гараагүй 25 сая тонн гарсан. Үнийн хувьд бол 40 хувийн үнийн бууралттай нөлөөлчихсөн. Энэ дээрээсээ бид яг үнэ дээрээс 40 хувийн үнийн бууралттай холбоотой орлого алдаж байна. Яах вэ, сая 4 сарын сүүл, 5 сар гараад нүүрсний үнийн уналт бол жоохон тогтворжих хандлага ажиглагдаж байна. Тэгээд тэр нь бол гадаад хүчин зүйлээс хамаараад цаашдын хандлага нь өсөх, буурах дээр бид бол байнгын ажиглаж бас олон улсын байгууллагуудын мэдээлэл энэ тэртэй анализ хийж байна. АНУ болон БНХАУ-ын хоорондын тарифын бодлого .../минут дуусав/

Р.Батболд: Гүйцээж хариулах уу. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Ганбат: Тарифын бодлого дээрээс үндэслэж, энэ нүүрсний экспортын асуудал бол үнийн асуудалд бас нөлөөлөөд байна. Тэгээд бас сүүлд гарсан мэдээллээр бол харьцангуй нааштай мэдээлэл нь бол хэлэлцээрүүдийн эхний шат нь амжилттай болж байгаа нь эргээд манай экспортод бас эерэг нөлөө үзүүлэх болов уу гэсэн ийм байдлаар бид бол ажиглаж байна.

Эхний 4 сарын байдлаар төсвийн орлого, тэнцвэржүүлсэн орлого 800 орчим тэрбум төгрөгөөр бол буурч байна. Энэ нь бол голлон ерөөсөө нүүрсний экспортын үнийн сая 40 хувийн бууралттай холбоотойгоор төсвийн тэнцвэржүүлсэн орлогын буурсан мэдээ бол ингээд гарч байна. Тэгээд энэ мэдээлэл бол статистик нэгтгэгдээд олон нийтэд мэдээлэгдээд ингээд явна.

Р.Батболд: Энхбаярын Батшугар гишүүн асуулт асууя.

Э.Батшугар: Баярлалаа. Монгол Улсын эдийн засагт өнөөдөр баялгийн болон орлогын тэгш бус байдал үүсчихсэн байгаа юм. 1 ёсны эдийн засгийн статистикаар харахад чинь дотоодын бүтээгдэхүүн 1 хүнд оногддог нь 6 мянган доллар, 8 мянган доллар 2026 онд болно гэсэн тийм төсөөлөл гаргасан. Гэхдээ энэ нь юу гэсэн үг вэ гэхээр дийлэнх ард түмний орлого нь нэмэгдэхгүй байгаа. Хэвээрээ байгаад байгаа, дордоод байгаа. Тэгэхээр хүртээмжтэй өсөлт бий болгоход ямар ямар бодлогын арга хэмжээ авах вэ гэж асууя. Ялангуяа энэ юугаар илэрхийлж байна вэ гэхээр жини коэффициент гэж байдаг. Энэ бол өсөлтийн хүртээмжийг тодорхойлдог. Энэ нь бол Монгол Улсад 0,39 байгаад байгаа юм 2024 оны тоогоор. Тэгэхээр энийг нэмэгдүүлж, өсөлтийг хүртээмжтэй болгож, яаж ард иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх вэ. Статистикийн 6 хувийн өсөлт биш, харин хүртээмжтэй өсөлт бий болгох вэ гэж Эдийн засаг, хөгжлийн яамнаас асууя.

Гадаадын хөрөнгө оруулалтын талаар яаж нэмэгдүүлэх вэ, ямар бодлого баримталж байгаа вэ. Бас Эдийн засаг, хөгжлийн яамтай холбоотой асуудал

байна л даа. Яагаад гэвэл өнөөдөр бол төлбөрийн тэнцэл эхний 4 сарын байдлаар 600 сая долларын алдагдалд орчихсон. Энэ нь юу илэрхийлж байна вэ гэвэл шууд ханш дээр мэдэгдэж байна. Долларын ханш өсөөд, төгрөгийн ханш суларч байна. Үүнийгээ дагаад импортын инфляц ч гэсэн нэмэгдэнэ. Төгрөгийн худалдан авах чадвар өөрөө буурна. Тэгэхээр яг гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд ямар бодлого баримтлах вэ ирэх онд. Яагаад гэвэл өнөөдөр гадаадын хөрөнгө оруулалт нийт дотоодын бүтэц нь 12 хувийг эзэлж байгаа. 12 хувийнх нь 10 хувийг нь нэгж хувь нь цэвэр уул уурхайн бүтээгдэхүүн. Энэ нь бол дийлэнх нь Оюутолгой л ганцаараа байгаа юм. Хөгжиж байгаа улс орнуудыг харахад бол гадаадын хөрөнгө оруулалт нь дотоодын бүтээгдэхүүнтэй харьцуулах коэффициент нь 40-60 хувь байдаг. Манайх 12 хувь байна. Тэгээд үүнийгээ дагаад нөгөө л нэг төлбөрийн тэнцлийн алдагдал, ханшны сулрал, долларын ханш нэмэгдэх гээд бүх юм л яваад байгаа байхгүй юу.

Төсвийн урсгал зардлыг 24 хувь дээр барина гэж байгаа юм. Тэгэхээр 2024 онд урсгал зардал бол 22 их наяд байсан. 27,6 хувь гэж ойлгож болно. 2025 оны төсөөллөөр бол 26,6 хувь болно. Төгрөгөөр илэрхийлэхэд 25,3 их наяд гэж байгаа юм. Тэгэхээр 6 хувийн эдийн засгаа өсгөөд дефлятороо бодоход 2026 оны төсвийн урсгал зардал бол 24 их наяд болох гээд байгаа юм. Энэ оны төсөөллөөс 1 их наядаар бага. Тэгэхээр энэ 1 их наядыг хаанаас, ямар байдлаар хасах юм бэ гэж Сангийн яамнаас асууя.

Төрийн өмчийн компаниуд манай бас гишүүд асууж байна. Зардлыг нь 15 хувиар бууруулна. Бүтээмжийг нь 30 хувиар нэмэгдүүлнэ гээд. Гэхдээ энэ чинь өөрөө ямар зарчмаар бүтээмжийг нь хэмжих юм бэ. Кэй Пи ай гэсэн тийм бүтээмжийг хэмждэг тийм заалтууд байдаг. Энийг ашиглаж эхлэх үү, үгүй юу. Дээрээс нь нэмээд Ретаун эн Эссет гээд нэг ёсны активын өгөөж нь манай төрийн өмчийн компани гэдэг 2 хувиас бага байдаг. Тэгэхээр яг ямар ямар реформууд хийх юм ямар байдлаар өөрчлөлт хий. Заавал төрийн өмчийн компаниудыг салбарын сайд нь удирдаад байх биш, мэргэжлийн нэг ёсны сан байгуулаад баялгийн сандаа оруулах, аль эсвэл Ассет менежерүүдийг ярьдаг юм. Тиймэрхүү байдлаар удирдаад өгөөжийг нь нэмэгдүүлэх нь л зөв гээд хараад байгаа юм. Олон улсын жишиг ч гэсэн яг энэ чиглэл рүү явж байна. Хамгийн сүүлд энэ 2 сард Индонез улс бас төрийн өмчийн компанийн том реформ хийгээд, үүгээрээ баялгийн сан руугаа оруулаад тэгээд .../минут дуусав/

Р.Батболд: Хариулт. Эдийн засаг, хөгжлийн яам. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

И.Батхүү: Батшугар гишүүний асуултад хариулъя. Тантай санал 1 байна. Тогтвортой өсөлтийн хүртээмж бол ажил эрхлэлт, хамгийн гол нь ажил эрхлэлтээр дамжиж, нийт иргэдэд очих ёстой. Мэдээж том агуулгаар бол бол уул уурхайн салбарын орлогын татварын орлого бүрдүүлэлт нь бол эдийн засаг, нийгмийн бодлогын хэрэгжилтээр дамжиж олон нийтэд хүрэх ёстой. Яг микро агуулгаараа бол ажил эрхлэлт айл өрхүүдийн орлогын асуудлыг ярих ёстой. Энэ дээр бид нар хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилтуудыг бол тавьчихсан байгаа. 61-65 хувь хүргээ гэсэн зорилт тавьчихсан байгаа. Үүн дээр бол бид нарын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа төсөл, төслүүдийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, хөдөө аж ахуйн салбарын бодлогын үр нөлөөнд гарах ажлын байрууд чухал хувь оролцоотой байх ёстой. Бүсчилсэн хөгжлийн хүрээнд авч хэрэгжүүлж

байгаа орон нутагт ажлын байр бий болгох аж ахуйн нэгжүүдэд бий болгох арга хэмжээнд бас нөлөө үзүүлэх ёстой.

Дээр нь нэмээд гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбоотой бас тантай бас санал 1 байгаа. Яг энэ нөхцөл байдал гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх, цаашдаа бол төлбөрийн тэнцэл дээр ирж байгаа дарамтыг бууруулахад гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь хамгийн чухал арга хэмжээ. Экспортын орлогын зэрэгцээ. Тэгэхээр энэ дээр бол бид нар Хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчлэх ажлын хэсэг байгуулаад ажиллаж байгаа. Энэ ажлыг Хөрөнгө оруулалтын тухай хуулиар бол яг тухайн хууль дээр заагаагүй ч гэсэн бусад хууль тогтоомжийн 41 заалтаар гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласан, хориглосон, шууд бусаар төвөг, дарамт учруулсан ийм зохицуулалтууд байгаа. Эд нарыг засъя гэсэн арга хэмжээнд явагдаж байгаа. Мөн гаднын хөрөнгө оруулагчдын гомдлыг барагдуулах тогтолцоог сайжруулах хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр бүх төрийн байгууллагуудын үүрэг оролцоо, эрх, үүргийг тодорхой болгох зэрэг олон асуудлуудыг энэ хуулийн шинэчлэлийн хүрээнд зорьж ажиллаж байгаа.

Дээр нь нэмээд зөвхөн Хөрөнгө оруулалтын тухай хууль гэхгүйгээр бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр олон арга хэмжээг бас хийх ёстой. Шүүх тогтолцоог сайжруулах, аж ахуйн нэгжийн бүртгэлээс өгсүүлээд цахилгаан, дулааны техникийн нөхцөл олгох гэсэн олон асуудлыг шийдвэрлэх ёстой. Энэ дээр бид нар оношилгоо хийгээд зохих арга хэмжээнд нь саналыг гаргаад, салбаруудын реформын бодлогоор яамнуудтай хамтраад ажиллаж байгаа.

Монгол Улсын өнөөг хүртэл хийгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ бол 47, 48 орчим их наяд тэрбум доллар хүссэн байгаа. Өссөн дүнгээрээ. Яг өнгөрсөн жилүүдийн хугацааг харахад гадаадын хөрөнгө оруулалт урсгал нь нэмэгдсэн жилүүддээ тэрийг дагаад бас эдийн засгийн өсөлт өндөр байдаг нь бол корляц байгаа нь бол ойлгомжтой. Тэгээд таны хэлж байгаа шиг ирэх жилүүдэд ирэх 3 жилдээ бас гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тал дээр бид нар анхаарч ажиллана. Яг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө хөрөнгө оруулалтын арга хэмжээнд бол 17,5 их наяд төгрөгийн хэрэгцээ шаардлага байгаа. Үүнээс бас улсын төсөв, орон нутгийн төсвөөс гадна гадаадын шууд хөрөнгө оруулалтаар 2,5 их наяд төгрөгийг тодорхой арга хэмжээнд татах ёстой гэж оруулсан байгаа. Дотоодын хөрөнгө оруулалтаар 1,9 их наяд төгрөгийн арга хэмжээ. Энэ арга хэмжээг амжилттай болгож байж энэ жилийн хөгжлийн төлөвлөгөөнд зорьсон үр дүнгүүд гарна гэдгийг бас хэлье.

Р.Батболд: Урсгал зардалтай холбоотой Сангийн яам Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Ганбат: Урсгал зардлыг бууруулах асуудал дээр Улсын Их Хурлын түвшинд бол Улсын Их Хурлын дэд дарга Булгантуяа гишүүнээр ахлуулсан ажлын хэсэгтэй бол хамтарч ажиллаж байгаа. Засгийн газар дээр бол Учрал сайдаар ахлуулсан төрийн хэмнэлт, төрийн бүтээмж гээд энэ зөвлөл дээр бас энэ асуудлыг ярьж байгаа. Тэгээд бид бол урсгал зардлыг бууруулах дээр энэ урсгал зар зардлыг нэмэгдүүлж байгаа хууль, тогтоомжуудын нөлөөллүүдийн асуудал дээр бол нэлээн судалгаа хийж энэ асуудлыг Булгантуяа гишүүнээр ахалсан ажлын хэсэг дээр бол танилцуулж байгаа. Энэ дээр хэд хэдэн шалтгаантай асуудлууд бол байна. Энэ бол нийтлэг хэм хэмжээг салбар бүр тусдаа хуулиар зохицуулах

хандлага бол нэлээн нэмэгдчихсэн. Үүний нөлөөллөөр бол төсвийн урсгал зарлага бол нэмэгдэж байна.

Хуулийн бас ялгавартай зохицуулалтын хүрээнд төрийн албан хаагч хоорондын орлогын ялгаатай байдлыг үүсгэж байгаа ийм бол асуудлууд байна гэж ингэж үзэж байгаа.../минут дуусав/

Р.Батболд: Гүйцээж хариулья.

Ж.Ганбат: Төсвийн орлогыг урьдчилан болон тусгайлсан урьдчилж хуваарилах бол ийм хандлагуудтай бас хууль тогтоомжууд байна. Энэ хүрээнд төсөв зохиохоосоо өмнө бол орлогыг өөрчилж хуваарилах ийм байдлаар татварын орлогыг хуваарилж байгаа нь бас төсвийг дагаад урсгал зардлыг нэмэгдүүлж байна. Үр ашиг багатай, хүнд суртал, шат дамжлагыг нэмэгдүүлэх нөлөөлөлтэй зохицуулалт байсан байна. Бид энэ урсгал зардлыг бууруулахад яг саяын хэдэн нөлөөлөл, энэ дээр нэлээн нарийвчилж байгаад хуулийн өөрчлөлтүүд нь оруулж ирж байгаад энэ урсгал зардлыг бууруулна гэдэг ийм байдал байгаа.

Нөгөө талдаа саяын тэр яригдсан орон тоон дээр бас бүтцийн өөрчлөлтийг оновчтой зохион байгуулах зорилгоор бол урсгал зардлыг бууруулна. Манай урсгал зардлын гол бүтэц дээр гол нөлөөлөөд байгаад нь зардал нь бол цалин, тэтгэвэр тэтгэмж, халамжийн зардал нийт урсгал зардлын 70 орчим хувийг эзэлж байгаа. Би тэгэхээр энэ асуудлыг саяын хэлдэг хуулийн нөлөөллийг нь тооцож байгаад, урсгал зардлыг бууруулах, хэмнэлттэй үр ашигтай болгох ажлыг ирэх жилийн төсөв дээр оруулж ирэхээр .../минут дуусав/

Р.Батболд: Нөгөө төрийн өмчит компаниудын бүтээмжийг хэрхэн хэмжих талаар Төрийн өмчийн хороо хариулах уу. Ажлын хэсгийн 6 номер.

Д.Дэлгэрмаа: Төрийн өмчит компани үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг бол нэгтгэж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар дүгнэдэг байсан. Засгийн газрын тогтоол гараад, Эрдэнэс Монгол, Эрчис Монгол компаниудад бол компаниудыг хариуцуулсан байгаа. Төрийн өмчит компани үйлдвэрийн газрын реформын хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийг 1 сарын 8-нд Улсын Их Хуралд өргөн барьсан байгаа. Уг хуулийн төслөөр бол бүтээмжийг сайжруулах Ки Пи Ай-ыг баталж мөрдүүлэх зохицуулалтыг бол эрх зүйн хүрээнд боловсруулаад оруулчихсан байж байгаа.

Р.Батболд: Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Ж.Ганбаатар: Саяхан бид нар Эдийн засаг, хөгжлийн яамыг шинээр байгуулсан л даа. Тэгээд энэ Сайнзориг гишүүний хэлж байгаа үнэн л дээ. Энэ төлөвлөгөөг бол Эдийн засаг, хөгжлийн яам голлох ёстой шүү дээ. Тэгээд энэ төлөвлөгөө дээрээ үндэслэж төсвөө баталдаг. Тэгээд Монгол Улсад ер нь бараг сүүлийн 8, 10 жил бараг байхгүй хэмжээнд ард иргэд ядуурч байна шүү дээ. Эдийн засгийн тоон үзүүлэлтүүдээ бүгдээрээ мэдэж байгаа юу. Хэдэн тоо хэлж өгье. Мэдэхгүй байж магадгүй зарим нь. Өөр юм руу анхаараад.

Энэ экспорт 5 тэрбум доллар гээд байгаа чинь ихэнх нь Монголд орж ирдэггүй. Мэдэж байгаа биз дээ. Оюутолгойн мөнгө бол зөвхөн татвар нь л орж

ирж байгаа. Нүүрс бол зөвхөн биржээр зарсан 100 сая доллар л орж ирсэн. Тэгээд бусад нь хаагуур зарж байгаа юм мэдэхгүй. Ганбат хариулаарай. Биржээр бус зарж байгаа наад нүүрс чинь тэгээд хаагуур зарж байгаа юм. Эрдэнэс Тавантолгой компани ойролцоогоор 9 сая тонн нүүрс зарсан. Тэгээд 1 нөгөө алдартай 4 компани руугаа өгөөд байгаа юм уу, өөр газраар өгөөд байгаа юм уу. Хууль зөрчиж байна уу гэж.

Инфляц 2024 оны эхний 5 сарын байдал дээр 5,7 хувьтай байсан бол одоо 9 хувь руу орсон байна 2025 онд. Энэ өөрөө цаанаа ямар тоон үзүүлэлттэй билээ гэдгийг эдийн засагч нар бүгд ойлгож байгаа байх. Энд сууж байгаа. Төгрөгийн ханшийн уналт 3350 байсан бол өнөөдөр 3570 хүчээр барьж байгаа юм. 5 тэрбум доллар болсон гээд Сангийн сайд зарласан. Тэгээд зарласан өдөр нь долларын ханш өсөөд байдаг.

Төлбөрийн тэнцэл 2024 онд бол 400 сая долларын ашигтай байсан. Ганбат дарга мэдэж байгаа. Өнөөдөр 614 сая долларын алдагдалтай. Тэгээд юугаар энэ төлөвлөгөөнүүдийг хийж, ямар мөнгөөр энэ ажлуудыг хийх гэж байгаа юм бэ. Ард иргэдийн амьдрал үнэхээр үгүй ээ, та нар намайг хэлж байна гэж бодож байна. Наад эдийн засгийн тоо баримтаа аваад нэг хараарай. Тэгээд бид нарын гаргаж байгаа зардлын гол алдагдал Эдийн засаг, хөгжлийн яам юу хийх ёстой вэ гэвэл наад бид нарт мөнгө байна шүү дээ. Мөнгө бол харьцангуй байна. Үнэхээр оновчгүй зардалтай. Үнэхээр оновчгүй. Тэгээд хэлээд ойлгодоггүй юм байна лээ л дээ. Янз янзын юм хэлэхлээр капиталист энэ тэр янз янзын юмаар дууддаг. Тэгээд оновчгүй, урсгал зардлаа нэмэгдүүлдэг. Тэгээд талын нэг тараагаад хаячихна. Тэгээд л үнэхээр энийг Эдийн засаг, хөгжлийн яам базах ёстой шүү дээ. Наад Сангийн яамаа удирдах ёстой шүү дээ. Тэгээд Сангийн яамдаа базуулчихдаг юм уу.

Нүүрсний экспорт 25 сая тоннд хүрсэн. Эрдэнэс Тавантолгой компани зүгээр надад өгсөн мэдээллээр бол 9 сая тонн нүүрс зарсан юм байна лээ. Үүний байна шүү дээ 1 саяыг нь л биржээр зарсан байна. Ноднин яг бид нар мөн үед 10 саяыг зараад, 8,9 саяыг нь бараг биржээр зарж байсан байна шүү дээ. Тэгээд маш их мөнгөтэй болсон. Монголбанкны валютын нөөц маш их нэмэгдсэн. Тэр хэмжээгээрээ бид нар бараг 90 сая тонн нүүрс зарна гээд төсвөө өсгөж баталсан. Тухайн үед нь битгий өсгө гээд зөндөө хэлсэн юм уг нь. 70 дээрээ бариа. Илүү орлогоо ол. 70 дээрээ бариад баталчихсан бол өдийд ийм асуудал үүсэхгүй байхгүй юу. Юу ч олохгүй хүн өөрөө их мөнгө олно гээд баахан зээл аваад машин авчихдагтай адилхан байхгүй юу.

Р.Батболд: Сангийн яам. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Ганбат: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Би түрүүнд бас хэлсэн. Нийт 25 саяыг гаргаад, биет хэмжээ бол буураагүй. Үнэ буурсан. Энэ үнийн уналт сүүлийн 3 жил болж байгаагүй ийм үнийн уналт үргэлжилсэн учраас үүнтэй холбогдуулаад биржийн арилжаа дээр бол жишээ нь саад болсон юмнууд бол байна. Өнөөдөр яг үнийн уналт бол ингээд дахиад цаашаа үнэ унах үгүй нь бас эргэлзээтэй байгаа тохиолдолд биржийн арилжаанд оролцож байгаа худалдан авагч нар бас энэ дээр оролцох хүлээлтийн байдалтай байгаа. Энэ нь бол биржийн арилжаанд сөргөөр нөлөөлсөн юм байна.

Нөгөө талдаа Эрдэнэс Тавантолгой компани болон Монгол Улсын яг тэр 25 сая нүүрсний арилжааны орлого бүгд Монгол Улсад орж ирж байгаа. Өмнө нь бол нөгөө урьдчилж авсан орлого энэ тэр гээд байсан учраас тэрэндээ суутгагдаад яваад байсан юм байгаа. Өмнө нь биржээр арилжигдчихаад хил нэвтрэлтээр гаргаж чадаагүй бас ийм нүүрсний хэмжээ байгаа юм байна лээ. Энэнтэй холбоотой бол хилээр гарч байгаа нүүрс дээр өмнө нь нөгөө биржээр арилжаад нүүрсний төлбөрийг нь 100 хувь авчихсан нүүрсээ бас гаргаж амжаагүйтэй холбоотой бол энэ дээр зөрүү байгаа. Яах вэ нөгөө худалдан авагч тал нь бас үнэ уначихсан учраас өндөр үнэтэй авсан нүүрсээ татан авалтаа нөгөө хил хүргэлтийг жоохон хүлээлтийн байдалд оруулчихсан бас ийм юм нөлөөлөөд байгаа юм байна лээ.

Тэгэхээр энэ үнийн уналт цаашаагаа тогтворжоод ирвэл энэ дагаад биржийн арилжаа бол бас сэргэнэ гэдэг ийм байдлаар бид бол тооцож хүлээж байгаа. Тэгээд Эрдэнэс Тавантолгой компани эхний одоо яг 5 сарын 11-ний мэдээгээр бол Эрдэнэс Тавантолгой компани 8,8 сая тонн нүүрс гаргаснаас 1,1 саяыг нь биржээр арилжсан гэдэг ийм мэдээллүүд бол байна.

Р.Батболд: Тэр төлбөрийн тэнцэлтэй холбоотой тодруулъя. Ганбаатар гишүүн тодруулъя.

Ж.Ганбаатар: Эдийн засаг, хөгжлийн яам юу хариулахыг нь мэдэж байгаа учраас би зүгээр тодруулъя. Эдийн засаг, хөгжлийн яам энэ төлөвлөгөөг бол ёстой маш чамбай боловсруулаад, энэ яамнуудаа шахах ёстой байхгүй юу. Яг энэ төлөвлөгөөний дагуу л явна. Батлагдсан төлөвлөгөөний дагуу. Тэгээд урсгал зардлыг нэмэгдүүлдэг хөрөнгө оруулалтуудыг хасна гэдэг, хэзээ ч хасдаггүй. Энэ төрийн албан хаагчдыг бууруулна гэдэг дандаа л жил болгон л юм ярина, хэзээ ч буудаггүй. Энэ биржээр зарж байгаа нүүрс чинь үнэхээр би хийсэн ажлаа магтах гээд байгаа юм шиг. Үнэхээр мөнгө Монгол Улсад мөнгө. Тэгээд яаж улсаа хөгжүүлэх гэж байгаа юм бэ мөнгөгүй байж байж. Тэгээд ард иргэдийн чинь амьдрал үнэхээр тартагтаа туллаа шүү дээ. Та нар мэдрэхгүй байгаа байх л даа. Мэдрэх зарим хүмүүс нь мэдэрч байж магадгүй. Би бол жижиг дунд бизнес эрхлэгчтэй ойр байдаг маш сайн мэдэрч байгаа. Санал хэллээ.

Р.Батболд: Ганбаатар гишүүн санал хэллээ. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Би яагаад энэ асуудал дээр сая горимын санал гаргаад байсан бэ гэхээр сая Ганбаатар гишүүн бараг агуулгын хувьд хэлээд байна л даа. Уг нь ирэх жилийнхээ бас төлөвлөгөө энэ яг хэрэгжих үү, үгүй юу. Их л өөдрөг сайхан байна. Танилцуулгаас харахад. Угаасаа жил жил ингэж л орж ирдэг. Тэгээд цаг хугацаа нь шахагдаад баталсан болоод явдаг. Ийм л зүйл байгаа. Хэмжих хэмжүүр байдаггүй. Ерөнхий бүгд ийм лоозогносон, тунхагласан шинжтэй л ийм л байж байгаа. Тэгээд яах вэ зүгээр нөгөө бодитой л юм байгаад байгаа юм.

Сая Шадар сайд бас үгэндээ хэлсэн. Төсөв алдагдалгүй явж байгаа. Зөв өө. Тэгээд ер нь зүгээр цаашдаа Засгийн газар төсвөө барина. Энэ жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулаад. Тэгэхдээ энийг нөгөө хэрэгжүүлээд, ер нь яаж төсвийг батлах нь бас Улсын Их Хурлын бүрэн эрх гэж байгаа боловч, өнөөдөр Үндсэн хууль болон Төсвийн тухай хуулиараа Засгийн газрын өргөн барьсан тэр төсвийн

хүрээ хязгаар дотор л Улсын Их Хурал санал гаргана. Энэ ингээд боломжгүй болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд урсгал зардлыг бид хэд танаж болдоггүй. Яг бодитой алхам хийж болдоггүй. Төрийн албыг өнөөдөр 9 гэж 1 тоо байна 15 гэж 1 тоо байна. Халамжийг хэдэн хувиар бууруулах гээд байгаа юм. Үнэхээр ингээд бид хэд бодитой урсгал зардлаа гаргаад, хөрөнгө оруулалтын зардлууд гардаг болох юм уу, үгүй юу. Мэдэхгүй.

Гэхдээ өнөөдөр 14 мега төсөл, нийслэл дээр 24 ч гэдэг юм уу. Яг энэ 14-өөс зөвхөн 2-ыг л ярья л даа. 2028 онд ашиглалтад оруулна л гэж байгаа юм. Газрын тосны үйлдвэрийг. Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцыг маш хурдтайгаар ашиглалтад оруулаад, баруун бүсийг эрчим хүчний хараат байдлаас гаргана л гэсэн. Бодит байдал өнөөдөр бид нарт тэр зээл нь олоод, мөнгө нь ороод ирчихсэн мөртөө бид ашиглаж чадахгүй байгаа байхгүй юу. Тэр 5,7 их наяд төгрөгийн зээл авчхаад, эндээ хүү төлж байгаа 0.050 хэдэн хувиар. Тэгээд жил тутам 209 тэрбум төгрөгийг нь ашиглаж байгаа. Бүтээн байгуулалтын явц ямар ч байхгүй байгаа. Дээрээс нь ингээд жил тутам 2 тэрбум төгрөгийн нефть бүтээгдэхүүн хэрэглэхээд, энэ үйлдвэр нь 2028 онд лав орохгүй юм шиг байгаа юм. Одоогийн байдлаар. Тэгэхээр энэ дээрээ бид нар гаргалгаа байна уу. Эдийн засаг, хөгжлийн яам ингээд яг бодитой хэлээч. Яг л үнэндээ хэлэхэд, энийг чинь бас ярихын тулд Эдийн засгийн сайд, Ерөнхий сайд байдаг юм уу, кабинет дээрээ шийдвэрээ гаргаад, үнэхээр ингэж бас төсвийн орон зайны хувьд түрүүн Найдалаа гишүүн хэлчихлээ л дээ. Их гоё сонсогдоод байгаа юм алдагдалгүй гэхчээр. Тэгэхдээ яг энэ бодит орон зай чинь бид хэд өнөө маргаашийн гал унтрааж л байгаа болохоос биш ирээдүй 2, 3 жилдээ бид хэд бараг тэтгэвэр, тэтгэвэр тэтгэмж, цалингаа тавьж тавьж чадах юм уу энэ байдлаараа. Ийм л зүйл ингээд болчихоод байна. Тэгэхээр би Эдийн засаг, хөгжлийн яам Батхүү ямар шийдвэр гаргах биш дээ. Тэгээд нэг юм хариулдаг л байх даа. Энэ газрын тос, Эрдэнэбүрэн. Нийслэл дээр мөнгө нь оруулаад ирчихсэн байгаа энэ Сэлбэ төвийн бүтээн байгуулалт чинь яг явах юм уу.

Төсвийн гадаадын зээл тусламжийн энэ зарцуулалт хязгаартаа багтаад энэ чинь явахгүй юм байна лээ шүү дээ. Тэгээд бид хэд магадгүй нефтийн үйлдвэр 2028 онд орохгүй байлаа. Энэ бараг 10-15 жил үргэлжлэх юм байна лээ. Яг энэ горимоор явбал. Тэгэх юм бол жилд 1 тэрбум долларыг дотооддоо үлдээж болох байсан тэр боломжийг л алдаж байгаа байхгүй юу. Тэгээд алдагдсан боломж өсөөд л байна гэсэн үг. Тэгэхээр ингээд Эдийн засаг, хөгжлийн яам маань бас яг бодитой төлөвлөдөг, энэ улс төрийн гарсан шийдвэрээс заримдаа бодит дүгнэлтээ хийгээд ийм байгаа юм. Энэ дээрээ ингэж явна гэдэг зүйлээ яг л энэ хуралдаан дээр хэлээд орж ирэхгүй бол одоо ингээд Засгийн газраас урьдчилсан байдлаар тэр төсвийн хүрээний мэдэгдэл янз бүрийн юм чинь алдагдалгүй л гэж байгаа юм. Тэгээд энэ төлөвлөгөө бол биелэхгүй л гэсэн үг шүү дээ. Тэгээд хэдүүлээ бие биеэ хуураад, яах вэ нэг бичиг баримттай болж байгаа юм.

Тэгээд яг ДНБ өсөлт байна гэж байгаа боловч яг өрх гэр лүү орж байгаа юм хэр байгаа юм. Ганбаатар гишүүн бухимдаад л байна. Бас амьдрал хэцүү байна гээд. Макро эдийн засгийн асуудлыг ярихаар гадаадын хөрөнгө оруулалтын асуудлыг яриад байдаг. Яг бодитойгоор яаж дэмжигдэж байгаа юм гэдэг юу ч байхгүй. Хөрөнгө оруулалт зөвхөн уул уурхайн салбар дээр л эхний ээлжид орж ирнэ. Гэтэл энэ салбарын бодлого нь .../минут дуусав/

Р.Батболд: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

И.Батхүү: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Энэ хөрөнгө оруулалтын төлөвлөлт улсын төсөвтэй нийцэлтэй байгаад байхад түрүүн бас Ганбаатар гишүүн асууж байсан. Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдаад одоо 3 дахь жилдээ ажиллаж байгаа. Улсын хөгжлийн төлөвлөгөө, төсвийн нийцэл нь 2022 оны хувьд 36,1 хувьтай байсан. 2023 онд 47,1 хувьтай болсон. 2024 онд 71 хувьтай болсон. 2025 оны төлөвлөгөө нь төсөвтөө 92 хувийн нийцэлтэй байгаа. Эдийн засаг, хөгжлийн яам бол энэ салбаруудын реформ, бусад энэ хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулахдаа салбарын яамдтай маш сайн нягт хамтарч ажиллаж байгаа. Сангийн яамтай ч гэсэн энэ талаар маш их хамтарч ажиллаж байгаа. Урсгал зардлыг бууруулах чиглэлээр бас бид нар яг өнөөдрийн танилцуулгад байхгүй ч гэсэн төсвийн хүрээний мэдэгдэл дээрээ бас зорилтуудаа оруулчихсан байгаа. Жишээлбэл 2026 онд ДНБ-ий 24 хувьд, 2027 онд 23 хувьд, 28 онд 22 хувьд хүргэж бууруулъя гэсэн агуулгатай байгаа. Энэ нь бол нөгөө төрийн албан хаагчид төрийн албаны нөгөө цалинг инфляцын түвшинтэй, тэтгэвэр, тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулж өсгөхөө тооцоод, цаана нь бусад томилолт, урсгал зардал, эд хогшлын зардлыг бууруулах чиглэлээр бодлогын даалгавар өгч байгаа гэж хэлж болно.

Бас гаднын зээл тусламжтай холбоотой энэ зардлыг яаж шийдвэрлэх вэ гэдэг дээр бас хэлье. Түрүүн дурдсан газрын тос боловсруулах үйлдвэрийн зардал бол ирэх 3 жилдээ шаардлагатай нь 4,6 их наяд төгрөг байгаа юм байна лээ. Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг бол 384 тэрбум төгрөг, Сэлбэ дэд төвийнх одоо яг бидэнд байгаа мэдээллээр 646 тэрбум төгрөг гээд. Энэ 2026 оны бид нарын тавьсан юун дээр 3,7 их наяд төгрөгийн зардал байгаа. Яг энэ дотроо бол гадаад зээл, үнэт цаасан 3,1, орон нутгийн төсөв дээр 1,6 гэсэн энэ тоон дээр бол хүрч хүрч байгаа. 2027 онд 2,3 их наядыг гадаад зээлийн үнэт цаасан дээр тавьсан. 2028 онд 2,6 их наядыг тавьсан байгаа. Энэ нь бол нийлээд энэ 3 жилдээ 8,1 их наядыг хөрөнгө оруулалтын зардал дээр тавьж байгаа юм.

Гадаад зээл тусламжийн төслүүд дээр таны асуусан асуултад хариулахад хамгийн сайн, үр дүнтэй, хурдан шуурхай хэрэгжиж байгаа төслийн зарцуулалт, санхүүжилт нь шууд хамгийн эхэнд гардаг байх ёстой гэдэг зарчим ажиллах ёстой. Муу, хэрэгжихгүй байгаа төслүүдийн зарцуулалт нь хойшоо шийдэгддэг. Энэ төслийн санхүүжилттэй холбоотой санхүүгийн зардлууд хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны зардлыг, шимтгэлүүд төлөх асуудал гардаг. Энийг бол тэр төсөл хэрэгжүүлэгч яам, агентлаг, байгууллага нь өөрсдөө бас хариуцаж ажиллах ёстой. Хариуцлагатай ажиллах ёстой. Энэ дээр шинэ төсөл хэрэгжүүлэхээр төслийн нэгжийг байгуулахад их хугацаа алддаг. Дунджаар 1,8 жил. Төсөл хэрэгжүүлэлтийн явцад янз бүрийн саатал гардаг. Эднийг бол бас тодорхой хэмжээнд тусад нь судалж, шийдлийн арга хэмжээ авах ёстой гэсэн байр суурьтай байна.

Р.Батболд: Тодруулъя. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Тэгээд ингэж л хариулна л даа. Би ч бас зовлонг нь мэдэж л байна. Тэгэхдээ 1 ийм юм байгаа байхгүй юу Батхүү. Гадаадын зээл тусламжийн ашиглалтын байдлаас нь шалтгаалж, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх эрэмбийг тогтооно гээд. Та нар хүчээр энэ гадаадын зээл тусламжийг ашиглуулахгүй байж бүгдийг нь муу зэрэглэлд оруулж байгаа шүү дээ. Ийм төлөвлөлт гарч ирэхээр чинь Монгол Улс ер нь хөгжих юм уу. Эдийн засаг, бизнесийн орчин сайжрах юм уу. Өнөөдөр дөнгөн данган татвар урсгал зардалдаа толгойгоо хөдүүлчхээд, яг ингээд живэх гэж байгаа хүмүүс шиг ингээд чулууны дөнгөн доошоо нуурын ёроол

руугаа живэх гэж байгаа байхгүй юу. Бид хэд толгойгоо гаргаж авч чадах юм уу. Хариултууд чинь ингээд гоё болоод байгаа мөртөө яг бодит байдал чинь эсрэгээрээ байхгүй юу. Өнөөдөр нефтийн үйлдвэр чинь явчихъя, бүтээн байгуулалтаа хийчихье гэхээр та нар 209 тэрбумыг зарцуул гээд хүчээр боож тавьчаад муу ашиглалт руу оруулж л байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм зүйлээсээ бид нар Эдийн засаг, хөгжлийн яам зоригтой яг зарчим, философио хэлээд, бид нар ингээд улс төрийн шийдвэр гаргахдаа ч гэсэн итгэл үнэмшилтэйгээр гаргадаг байхгүй бол хар даа .../минут дуусав/

Р.Батболд: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

И.Батхүү: Зарчмын агуулгын хувьд бол ер нь гадаад зээл, өр үүсгэхээс илүү гадаадын шууд хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль, эрх зүйн хүрээнд томоохон төслүүдээ явуулах нь зөв. Гадаад зээл аваад нэгэнт ашиглачихсан төслүүдийг бол богино хугацаанд хурдан шуурхай хэрэгжүүлж дуусгах ёстой. Үүнд шаардлагатай Төсвийн зардлын хэмжээг нь бол улсын төсвийн зардлын ангилалтай их дүнтэйгээр бол оруулах, өмнө нь бас авч хэрэгжүүлж байсан нэгэнт эхэлчихсэн он дамжиж шилжиж байгаа төслүүдийг хурдан дуусгая гэдэг арга хэмжээнд авч хэрэгжүүлсэнтэй адилхан. Гадаад зээлүүдийн хувьд ч гэсэн энэ бодлогыг ижилхэн хэмжээнд авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Харин тухайн төслийг аль нэг төслийнх нь санхүүжилт өгнө, өгөхгүй гэдэг биш түрүүлж ирсэн санхүүжилтийн хүсэлтээ гаргасан төсөлд нь бүрэн хэмжээгээр олгодог байдлаар явах юм бол жишээ нь газрын тосны төсөл дээр хэдэн тэрбумын санхүүжилтийн хүсэлт ирж байна. Тэр нь түрүүлээд л гараад явах ёстой ийм зарчмаар ажиллах ёстой гэж үзэж байгаа.

Р.Батболд: Дахиад 1 минут Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Ойлголоо. Тэгээд ер нь зүгээр бас бодитой л юмаа хараарай. Эдийн засгийг төрөлжүүлж хөгжүүлье гээд байгаа мөртөө аялал жуулчлалын чиглэлээр нэг их тодорхой юм харагдахгүй байна. Хөдөө аж ахуйг дэмжих юм нөгөө л юмнуудаа хэлээд байдаг. Ядаж жилд эдийн засгийн эргэлтэд оруулж байгаа 20 сая малынхаа түүхий эдийг наад захын анхан шатын боловсруулалт хийх 2, 3 төслийг л зэрэг явуулаад ингээд л л уначхаад байдаг. Ядаж эхлээд энэ Эмээлтийн аж үйлдвэрийн парк дээр байгаа байгааг хурдан дуусах талаасаа бодлогын дэмжлэг үзүүлж болдоггүй юм уу. Бид хэд ингээд ерөөсөө ийм гоё л байна. Тэгээд уул уурхайн бодлогыг яг энэ ирэх оны жилийн төлөвлөгөөтэй бодуулчихвал уул уурхайн бодлогоо гаргаж, яг энэ хөрөнгө оруулалт орж ирэх ганц сектор дээрээ ямар бодлого барихаа илүү хурдан зарлахгүй л бол юу ч орж ирэхгүй Батхүү. Би энийг хариуцлагатайгаар л хэлье. Тэгээд бид хэд ингэж байж энэ улс эх орон чинь жоохон өндийх юм уу, үгүй юу. Зүгээр бид хэд цаг хугацаанд баригдаад, дүр үзүүлээд ийм л байдалтай. Тэгээд зарчим хэлэхээр ингээд попорч байна ч гэдэг юм уу ийм байдлаар бүгдийг нь ингэж хандчихаад эцсийн дүндээ гал .../минут дуусав/

Р.Батболд: Гадаадын энэ зээлийн ашиглалттай холбоотой бас асуудлууд зөндөө байгаад байдаг. Тэгээд 1 талдаа ашиглаж чадахгүй байгаа зээлээ ашиглах, нөгөө талдаа бол энэ нэгэнт зээлээр хэрэгжиж байгаа төслүүд дээр зарцуулалтыг нь бид нар өөрсдөө хянах шаардлагатай болоод байгаа юм. Энэ нөгөө хугацаа

хоцроод юм уу, хойшлоод байгаа төсөл, хөтөлбөрүүд чинь болохоор бид нарын нөгөө авчихсан зээлийг дахиад нааш нь зах зээл рүүгээ оруулж ирэх энэ асуудал дээр маш том саад болоод байгаа. Тэгэхээр энэ дээр бас хариуцлагатай байх, төсөл хэрэгжүүлэгч нар нь ямар хариуцлага хүлээж явах юм. Зээлийн санхүүжилт дээрээ бас ямархуу тэрийгээ тусгаж өгч явах юм гэдгийг манай энэ холбогдох яамнууд зээлээр хэрэгжүүлж байгаа төсөлтэй яамнууд маань бас анхаарч ажиллаарай гэж хэлье. Эдийн засаг, хөгжлийн яам бас энэ дээр анхаарлаа хандуулах ёстой шүү. Хугацаа хоцорч байгаа чинь бид нарын авчихсан зээлийг л оруулж ирэхгүй бас их саад болоод байгаа шүү дээ гол нь. Одоо Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууя.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Эхлээд магтаал ч байна. Ер нь шүүмжлэл ч байна. Эхлээд магтаалаас нь эхлээд хэлье дээ. Хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийгээ тогтвортой хөгжлийн зорилттой нийцүүлсэн байна. Энэ бол шинэлэг зүйл байна. Сайн байна. Баярлалаа.

2 дугаарт нь төлөвлөлт, төсөлд хяналт үнэлгээний платформыг хөгжүүлнэ. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн сан тогтолцоо бүрдүүлнэ гэж байгаа. Энэ бас ахиц байна. Болж байна. Өмнөх жилүүдээсээ илүү сайжирсан төлөвлөгөө болсон байна гэж харж байна.

Гэхдээ нөгөө талдаа бас алдаанууд байгаад байна л даа. Зарим зүйл, заалт нь хүслийн жагсаалт шиг байгаад, эсвэл бодит бус зорилго тавьчихаад байгаа юм. Яамнаасаа хамаараад л байна л даа.

Эхний жишээ Хот байгуулалтын яамнаас асууя. 1 дүгээр хавсралтын 2.6.3.иргэдийн төлбөрийн чадварт нийцсэн инженерийн бүрэн хангамжтай, эрүүл аюулгүй орчин бүхий 150 мянган айлын орон сууцыг барьж байгуулна гэж байна. 1 жилийн хугацаанд бид нар ийм олон орон сууц барих чадал байгаа билүү. Ийм зорилго тавих нь бодитой юу. 3 дугаар хавсралт дээрээ энэ 2.6.3-ын шалгуур үзүүлэлт нь бас байхгүй байгаад байгаа юм. Зорилго нь хийсвэр, хэмжих шалгуур үзүүлэлтгүй бол энэ биелэх боломжгүй. Ийм төлөвлөгөө бол боловсруулмааргүй байна. Засгийн газар чинь ер нь 1 л зүйлийг хэлээд байгаа шүү дээ. Хэмжиж чадахгүй бол удирдаж чадахгүй. Шалгуур үзүүлэлтүүдээ зөв тогтоо. Ямар төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх нь хамаагүй. Иргэд бол үр дүнг л хүсэж байгаа. Тийм л төлөвлөгөө боловсруулж байж бодитой төсвийн хөрөнгө оруулалтаа хийгээд, үр дүн авчрах боломж нь нээгдэнэ.

Ер нь энэ хөгжлийн төлөвлөгөөг хэзээ боловсруулж сурах вэ гэдэг үндсэн асуулт асууя. Эдийн засаг, хөгжлийн яамнаас. Энэ жилийн хөгжлийн төлөвлөгөө бол уг нь их богинохон бичиг баримт. Тийм сүртэй их ажил болохоор зүйл бол биш. 3 зүйлийг л бид нар харах ёстой.

1 дүгээр хавсралт тэргүүлэх чиглэл. Ердөө 12 хуудас.

2 дугаар хавсралт. Төсөл, арга хэмжээний жагсаалт 26 хуудас.

3 дугаар хавсралт Хяналт үнэлгээний жагсаалт. 15 хуудас.

Энэ 50 хүрэхгүй хуудаснуудыг л бид нар хараад, зөв төлөвлөөд явах хэрэгтэй байгаад байгаа юм. Энэ 3 хавсралтын үг, үсэг хоорондоо яг таг таарч байж, бид

нар энэ төсөл, арга хэмжээгээ бодитоор хэрэгжүүлээд, үр дүнгээ зөв хянаж чаддаг болно шүү дээ. Энэ 3-ыг л хооронд нь яг таг нийцүүлмээр байгаа юм.

Дахиад нэг жишээ, уг нь Авлигатай тэмцэх газраас асуумаар байгаа юм. Өнөөдөр байхгүй болохоор чиг үүргийн хувьд Хууль зүйн яамнаас асууя. 1 дүгээр хавсралт дээр тэргүүлэх чиглэлийн 4.4.1.авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлж, авлигын төсөөллийн индексийн оноог сайжруулах нөхцөлийг бүрдүүлнэ. Зорилго нь бол 180 улсаасаа 112-т жагсана гэсэн байна. Бид нар уг нь энэ оноогоо сайжруулах ёстой болохоос биш байр ахина гэсэн ийм хийсвэр зорилт тавьж болохгүй шүү дээ. Бусад улс яадаг юм авлигажаад ирээд, Монгол Улсын оноо, байр нь ахихаар бид нар сайн ажиллачихлаа гэсэн. Яг л өнгөрсөн сард хийсэн тайлангийн дүгнэлтээр гарсан ажлын үр дүнгээ 100 хувиар үнэлнэ гэсэн тийм зүйл төлөвлөөд ороод ирж байгаа байхгүй юу. Сүүлийн 3 жил энэ 33 оноотойгоороо гагцхиад байгаа. Энэ индекс дотор бүрэлдэхүүн шалгуур үзүүлэлтүүд гэж байгаа. Тэр бүрэлдэхүүн шалгуур үзүүлэлтээс бид нар юун дээр нь муу оноо аваад байгаа юм. Тэд нарыг яаж сайжруулах юм гэсэн ажлын төлөвлөгөө хэрэгтэй байна. Авлига, албан тушаалын ийм гэмт хэрэг дээр сайн ажиллаж байгааг нь бол хүлээн зөвшөөрч байгаа. Сүүлийн 3 жилд бол 3 их наяд төгрөгийг энэ хохирлоос төсөвт бүрдүүлсэн. Энэ бол сайн үр дүн байгаад байгаа. Гэхдээ бид нар гол нь энэ авлигын индексийнхээ төсөөллийг сайжруулах хэрэгтэй байгаад байгаа. Тэгж байж бид нар иргэдийн орлого сайжирна. Аж ахуйн нэгжүүд бизнес эрхлэх орчинд таатай болно. Гаднын хөрөнгө оруулагчид Монгол Улсыг сонирхоно. Энэ 14 мега төсөл, нийслэлийн 24 мега төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх хөрс нь бүрдэх гээд байгаа юм. Эхний 3 асуулт дээр хариулт авчихъя.

Р.Батболд: Эдийн засаг, хөгжлийн яам. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

И.Батхүү: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Таны өмнөх намрын чуулганы үеэр хэлж байсны дагуу ажлын хэсэгт бид нар мэдээллээр хангаад хамтарч ажилласан. Тэгээд бид нарын хувьд бол энэ хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан цаглаврын дагуу энэ хөгжлийн бодлогын баримт бичгүүдээ боловсруулж ажиллаж байгаа.

Арга зүйн хувьд бол энэ хуульд заасан шаардлагуудаас гадна бас дээрээс доош, доороос дээш гэсэн 2 чиглэлээр ажиллаж байгаа юм. Дээрээс доош гэдэг дээрээ бол урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд туссан зорилт арга хэмжээнүүдийг оруулах. Тухайн 2026 онд хүрэх түвшин зорилтуудыг нь оруулах талаасаа анхаарч байгаа юм.

Доороос дээшээ гэдэг нь төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, орон нутгийн байгууллага, хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдийн санал, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төслүүдтэй холбоотой улсын хөгжлийн зорилтод нийцэх арга хэмжээнүүдийг тусгаж ажиллаж байгаа. Энэ цаглавруудын хувьд бас цаг хугацааны хувьд ойрхон шахуу байдал бас байдаг. Саналуудаа ирүүлж байгаа яамнуудын хувьд бол бас бидний баримталдаг хууль болон Засгийн газрын 2020 оны 470 дугаар тогтоолоор батлагдсан журам, Эдийн засаг, хөгжлийн сайдын 2020 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан аргачлалтай нийцүүлж ирүүлэхэд бас зарим бэрхшээл гардаг. Бидний хувьд оны эхнээс эхлээд салбарын яамдтай зөвлөн туслах арга хэмжээг авч, олон удаагийн

уулзалт хийж ажиллаж байгаа. Баримт бичгийн хувьд чанар бол сайжирч байгаа гэж ойлгож байгаа.

Таны тухайлан асуусан арга хэмжээ, түүний шалгуур үзүүлэлтийн талаар манай яамнууд, манай газрын дарга хариулна.

Р.Батболд: Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам Эрдэнэбат. Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Ер нь түрүүний бас Ганбаатар гишүүн, Соронзонболд гишүүний асуусан Эдийн засаг, хөгжлийн яамны бодлого юу юм бэ, бодлого нь яаж явж байгаа юм бэ гээд. Тэгээд энэ хүрээндээ болохоор Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн 2 том бид нарын хүрэхийг хүсээд байгаа тоо буюу зорилго байгаад байгаа. Тэр нь ядуурлыг 2 дахин бууруулах, 1 хүнд ноогдох ДНБ-ээ 10 мянган долларт хүргэх гээд. Энэ бодлогынхоо хүрээнд ажиллаж явж байгаа юм. Тэгээд 2026 оны нөхцөл байдал маань их тийм эрсдэлтэй, таамаглашгүй, таамаглах боломжгүй, тогтворгүй, тодорхойгүй ийм нөхцөл байдалд байгаад байгаа.

Тийм учраас энэтэй холбоотой бас нэлээд одоо юу гэдэг юм яамнуудаас нийтдээ 890 бараг 900-аад .../минут дуусав/

Р.Батболд: Гүйцээж хариулъя. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Ц.Эрдэнэбат: Төсөл, арга хэмжээний санал ирээд, саяын дурдсан хуулийн шалгуур болон аргачлалын дагуу 300 орчим төсөл, арга хэмжээ 2026 онд орсон. Тэгээд энэ дотроос түрүүний ярьсан ядуурлыг тоон хэмжигдэхүүнээр, эсвэл тэр урсгал зардлаа тоон хэмжигдэхүүнээр шийдэхээр эрмэлзэж явж байгаа. Тухайлбал экспортлох экспортоороо валютын орлогоо нэмэгдүүлж, төгрөгийн орон зайгаараа бүтээн байгуулалтаа явуулах ийм үндсэн бодлого явж байгаа. Энэ хүрээнд дэд бүтэц болон боловсруулах үйлдвэрийн чиглэлд тухайлбал зам, тээвэр болон эрчим хүчний чиглэл дээр нийт ингээд 10-аад их наядын төсөл арга хэмжээ орж байгаа. Үүн дотор 150 мянган айлын орон сууц нь ядуурлын дорвитой бууруулах, бүр одоо бид нарын тооцоогоор бол 150 мянган айлын орон сууцын эффект нь ядуурлын 3,6 функтээр буулгахаар байгаад байгаа юм. Тэгэхээр 24 .../минут дуусав/

Р.Батболд: Хууль зүйн яам. Ажлын хэсгийн 1 номер. Төмөрхүү дарга ажлын хэсгийн 5 номер дээр очоод сууж байх уу. Дараа нь харуулна. Ажлын хэсгийн 1 номер.

Н.Мягмар: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Засгийн газар бол авлигатай тэмцэх үйл ажиллагааг өмнөх Засгийн газрын үед ч хэрэгжүүлж байсан. Одоо үргэлжлүүлээд хэрэгжүүлнэ. Томоохон жишээ бол “5ш” ажиллагаа гээд шүгэл, шүүр, шилэн, шилжүүлж авах энэ тэр гээд ийм ажиллагаануудаа бол үргэлжлүүлж хэрэгжүүлэхээр Засгийн газрын хөтөлбөртөө туссан.

Олон улсын түвшиндээ авлигатай тэмцэх асуудал дээр олон улсын түвшинд ингэж оноо байр эзлүүлж, улс орнуудын индексээр нь ингэж байр эзлүүлдэг. Энэ аргачлалаараа үндсэндээ авлигатай тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтийг

үнэлье. Шалгуур үзүүлэлтийг нь тавья гэж ингэж ярьж байгаа. Тэгээд энэ индексийн үзүүлэлт дотроо 5 үзүүлэлтээс хамаардаг ийм үзүүлэлт байгаад байгаа юм. Тэгэхээр энэ үзүүлэлтээр оноо, байр гэдэг 2 асуудал гарч ирж явдаг. Тэгээд энийг нь сайжруулна гэдэг маань бол оноо, байр аль алиных нь түвшинд сайжруулах энэ агуулгыг л .../минут дуусав/

Р.Батболд: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

С.Төмөрхүү: Ер нь Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамнаас бол Засгийн газрын мөрийн хөтөлбөрт 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт 150 мянган айлын орон сууц барих ийм зорилт тусгагдсан. Энэ 150 бол 4 жилийн тоо байж байгаа. 2025 онд бол бид нар 35 мянган айлын орон сууцыг ашиглалтад оруулна гэдэг ийм төсөөлөл тавьсан. 2026 онд. Тэгэхээр энэ бол зөвхөн нийтийн орон сууцын тухай бид нар ярихгүй байгаа. Инженерийн дэд бүтцэд холбогдсон амины орон сууц бас энд орно. Амины орон сууцыг мөн ипотекийн зээлд хамруулах энэ чиглэлийн ажлууд хийгдэж байгаа. Энэ чиглэлээр бол манай яамнаас бас нэлээд ажлуудыг хийж байгаа. Банкнууд маань ипотекийн зээлд амины орон сууцыг хамруулахын тулд баталгаажуулах асуудал ярьж байгаа. 2024 оны 12 сард бид бест гэр гэж гамшигт тэсвэртэй, эрчим хүчний хэмнэлттэй барилгын стандартаа .../минут дуусав/

Р.Батболд: Гүйцээж хариулъя. 5 номер.

С.Төмөрхүү: Аргачлалаа баталсан. Ирэх 7 хоногоос аудиторуудаа бэлдэх сургалтаа эхэлж байна. Ингээд аудитортай болоод энэ дээр зориулсан мэдээллийн технологийн платформыг нь оруулаад, амины орон сууцыг бол нэлээд түлхүү дэмжинэ. Энэ чиглэлээр дүүргүүдэд амины орон сууцын технологи дамжуулах төвүүд ажиллаж байгаа. Сая 5 сарын 4-7 хооронд Сүхбаатарын талбай дээр мөн дулаан байшин гэж өдөрлөгөөр амины орон сууцын мэдээллүүдийг өгч, 10 мянга гаруй иргэдэд үйлчилсэн ийм тооцоотой байж байгаа. Тэгэхээр Солонго 1, 2 төсөл ашиглалтад орно. 1008 айлын төслүүд ашиглалтад орно. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойбалсан зэрэг хотуудад Залуус, Ирээдүй хорооллууд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар инженерийн дэд бүтцүүд баригдсан байж байгаа. Энэ төсөл хөтөлбөрүүд ашиглалтад ороод бид нар 35 мянган айлыг инженерийн дэд бүтцээр хангагдсан орон сууцад оруулах зорилтоо биелүүлнэ гэж тооцож байгаа.

Р.Батболд: Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Эдийн засаг, хөгжлийн яамнаас тодруулж асууя. Хавсралт 1, 2, 3 үг, үсэггүй, хоорондоо таарах ёстой. Тэргүүлэх чиглэл байгаад, тэр чиглэлдээ нийцсэн төсөл арга хэмжээ байгаад, төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтүүд нь зөв байх ёстой шүү дээ. Хууль зүйн яам бол сая байр ахиулна, оноог ахиулна гэж байгаа. 3 дугаар хавсралт дээр тийм шалгуур үзүүлэлт байхгүй байгаа байхгүй юу. Зөвхөн авлигатай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Тэр хэрэгжилтийнхээ хувийг өсгөнө л гэсэн шалгуур үзүүлэлт байгаад байгаа юм. Хот байгуулалтын яам энд 2025 онд бол 35 мянган айлын орон сууц, 2026 онд бас 35 мянган айлын орон сууц гэж ойлголоо. 3 дугаар Хавсралт дээрээ тэр тоо нь байхгүй байгаад байгаа юм. Энэ 2.6.3-ын энэ зорилт маань 3 дугаар хавсралт дээр тусаагүй байна гэдэг чинь бид нар энэ төсөл арга хэмжээгээ үнэлж чадахгүй буюу татвар төлөгчдийн

мөнгө үргүй зарагдах гээд байна гэсэн үг. Энийгээ яаж засах вэ гэдэг ерөнхий асуултыг Эдийн засаг, хөгжлийн яамнаас асууя.

Р.Батболд: Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Ц.Эрдэнэбат: Лувсанжамц гишүүнтэй санал 1 байна. Тэр 1, 2, 3 дугаар хавсралт яг цав нийцэх ёстой. Хуульдаа бол уг нь бид яг 2, 3 дугаар хавсралттай байхаар байсан авч яг сүүлд Улсын Их Хурлын тогтоолоор тэргүүлэх чиглэл буюу 1 дүгээр хавсралт орж ирсэн. Тэгээд 1 дүгээр хавсралт тэргүүлэх чиглэл дээрээ яг тухайн жилийн онцлох ажлууд, тэргүүлэх ажлуудаа багцлаад, түүнийхээ задаргааг 2, 3 дугаар хавсралт руу явж байгаа. Энэ дээр түрүүний хэлсэн нөгөө ажлын хэсэг гараад ажиллаж байгаа шиг бид нарын төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжих хяналт үнэлгээний энэ тогтолцоо руу шилжих хүртэл мөн энэ тогтолцоо дээрээ бид нар сайжруулалт хийж байж энэ бид нарын энэ баримт бичиг төгс төгөлдөр болох юм. Бид нар сайжруулалт хийгээд явж байгаа. Аль болохоор тоонууд маань нийцэлтэй байж байгаа. Тэгээд яг .../минут дуусав/

Р.Батболд: Хариулт хангалтгүй гэж байна. Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Их олон ажлыг хийж байгаа. Ажлын хэсгүүд өдөр, шөнөгүй ажиллаж байгааг бол маш сайн ойлгож байгаа. Гэхдээ миний энэ гол хэлээд байгаа санаа бол бүх яамнууд, Тамгын газар, нийслэл ирчихсэн байгаа энэ байршил дээр бид нар хөгжлийн төлөвлөгөө гэдэг юмаа зөв боловсруулж сурцгаая гэдэг л зүйлийг хэлэх гол зорилго байгаад байгаа юм. 185 дугаар тогтоолоор крi шалгуур үзүүлэлтийг оновчлох энэ бодлогын бичиг баримтуудыг төлөвлөлтийг зөв болгох ажлын хэсэг ажиллаж байгаа. Тэгээд энэ дээрээ сая хэлсэн бүх яамнуудтай нийслэлийг оролцуулаад төлөвлөгөө, төсөвлөлт, хяналт үнэлгээ, шалгуур үзүүлэлтийг зөв болгох ажлыг идэвхтэй хийх учраас та хэд маань бас өргөнөөр оролцоосой гэж хүсэж байна. Энэ 5 дахь өдөр 2 цагаас “Жанжин Сүхбаатар” танхимд ажлын хэсгийн 2 дугаар хурлаар хэлэлцүүлэг зохион байгуулна. Та нар маань аль болох Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн газар ч юм уу, газрынхаа хүмүүсийг явуулаарай гэж хүсэж байна.

Р.Батболд: Санал хэллээ. Одоо Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Б.Мөнхсоёл: Сайн байцгаана уу. Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр чухал асуудал хэлэлцэж байна. Энийгээ бид нар сайн хийхгүй бол түрүүний удаа бүгдээрээ мэдэж байгаа үнэлгээ дээр бид нар унасан. Анхнаасаа төлөвлөхдөө сайн байхгүй бол үнэлж чадахгүй байгаа гээд Лувсанжамц гишүүний хэлсэн бол маш чухал, магадгүй сонсоход уйтгартай юм шиг боловч маш чухал асуудал. Лувсанжамц гишүүн сая нөгөө хуудасны тоо яриад байна. Хуудасны тооноос гадна бас дотор нь агуулга маш чухал байна шүү дээ. Энэ чинь хаана, юуг, яаж, хэрхэн тооцох вэ гэдэг том ажил явж байгаа буюу жишээлбэл хөгжлийн бодлого төлөвлөлтийнхөө хуулийн 14.1-14.5-ын заалтын дагуу 2026-2030 оны хөгжлийн төлөвлөгөө бодлого гарчихсан байх ёстой. Энэ эхэлсэн үү. Үүнийхээ хүрээнд энэ 2026 оны хөгжлийн бодлогоо төлөвлөж чадаж байна уу.

2 дугаар асуулт. Түрүүн гишүүд бас хэлээд байх шиг байна. Тухайн ажил, төсөл үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд юу хэрэгтэй юм. Мэдээж мөнгө санхүү. Тэгэхээр энэ зорилго зорилтуудаа хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн нарийн тооцоо

хийсэн үү. Ямар байдалтай байгаа вэ. Энэ асуулт байна. Энэ бол суурь гол асуудал гэж бодож байна. Тэгээд Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний 2024-2028 оны төлөвлөгөөний хэд нь энэ 2026 оны төлөвлөгөөнд орсон бэ гэж бас асуумаар байна.

Ингээд нарийвчлаад үзвэл мянган асуулт байж болно. Товчлоод жишээ болгоод ганц 2 асуулт нэмээд асууя.

Тэгэхээр 2 дугаарт миний бас асуух гээд байгаа юм. Жишээлбэл 333 тэрбум төгрөгийн өртөгтэй спорт заал барина гэхихсэн байгаа. Нэр нь президент гээд байгаа юм уу даа. Нийгмийн салбарын бодлогын хүрээнд, зээлээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд. Тэгэхээр бид нар өнөөдөр хүртэл, өчигдөр хүртэл байнга яригдаад байгаа асуудал юу вэ гэхээр гадаад өр энэ өрийн ашигтай байдал, зээлийн ашигт зарцуулалт. Тэгэхээр ийм 333 тэрбум төгрөгөөр тухайн спорт заалыг барих нь зүйтэй юу. Яагаад. Яг ийм үр дүн авчрах уу гэдэг асуулт байна.

2 дугаарт нь болохоор жишээлбэл хүүхэд, гэр бүлийн хөгжлийг дэмжих шинжлэх ухаан, технологийн паркийг бас байгуулах гээд. Яг ийм шинжлэх ухаан, технологийн парк үнэхээр хэрэгтэй юм уу. Тэгээд хэрэгтэй, үнэхээр хэрэгтэй гээд байгаа бол энийг заавал энэ хөтөлбөрт оруулахгүйгээр хувийн сектор энийг санаачлаад барьдаггүй юм уу. Бид нар чинь нээлттэй зах зээлтэй шүү дээ эдийн засгийн. Тэгэхээр эрэлт, нийлүүлэлтийнхээ онолоор явах ёстой бус уу. Яах вэ, бодлогоор хувийн секторыг мотивацилж, өдөөж болох юм.

Дараа нь нэг асуулт бас жишээлбэл яриад байгаа. Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдэд үзүүлэлтийн төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээтэй хэр уялдаж байгаа вэ. Ганцхан жишээ хэлье. Энэ дээр ингэсэн байна. Олон улсад өрсөлдөхүйц чанартай, тэгш хүртээмжтэй ерөнхий боловсролыг хөгжүүлнэ. Тэр дотроо зорилтот, үр дүнгийн шалгуур үзүүлэлт нь писа гээд олон улсын үнэлгээний эрэмбэ байна гэхихсэн байгаа. Энэ үнэлгээ зорилтдоо хэрхэн хүрэх юм бэ гэсэн чинь сургууль барих, спорт заал барих мэтийн ийм үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ орчихсон. Тэгэхээр чинь энэ чинь яг үр дүнд шууд нөлөөлөхөөр байж чадаж байгаа юм уу гэх мэт ийм логик ийм алдаа гарчихсан зүйлүүд багагүй цөөнгүй байна. Ингээд товчхон асуучихъя.

Р.Батболд: Эхний асуултад нь Эдийн засаг, хөгжлийн яам хариулах уу. Ажлын хэсгийн 3 номер. Номин сайд та ирцэд орчих юм бол шууд суудал дээрээ хариулж болно шүү дээ. Орчихсон байгаа юу.

И.Батхүү: Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Таны асуусан тэр хөгжлийн бодлого, төлөвлөлт, удирдлагын тухай хуулийн 14.3-д заасан улсын хөгжлийн 5 жилийн хөтөлбөр 2026-2030 оныхыг бид нар боловсруулж байгаа.

Хуулийн заалтаар зөвхөн манай яам биш, салбарын яам, шинжлэх ухааны байгууллагууд, хувийн хэвшил бүгд хамтарч боловсруулах ёстой. Тэгэхээр саналуудыг авах ажлууд хийгдээд явж байгаа. Боловсруулж ажиллаж байгаа.

2 дугаарт нь бол бид нар өнгөрсөн намар Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөрийг боловсруулж бас Их Хурлаар батлуулсан. Үүний агуулга маань бас 2030 онтой нэлээн адилхан уялдаатай байх ёстой. Энэ тал дээр

бид нар хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдааг хангах дээр онцгойлон анхаарч ажиллаж байгаа.

Сая таны асуусан тэр Ерөнхийлөгчийн ордон гээд 330 тэр тэрбум гэдэг бол энэ БНХАУ-ын буцалтгүй тусламжаар санхүүжих төсөл гэж ойлгож байгаа. Бусад төслүүдийн мэдээллийг манай яам, газрын дарга нар хариулчих байх.

Р.Батболд: Номин сайд хариулах уу. Номин сайдын микрофон.

Ч.Номин: Эдийн засаг, хөгжлийн яамнаас бараг хариулчихлаа даа. Тэр президент цогцолбор бол спортын том хэмжээний цогцолбор бөгөөд хүүхэд залуучуудын нийтийн биеийн тамираар хичээллэх боломжийг бий болгож байгаа.

Ирээдүйд аливаа өгөөжийг бас бид нар харахдаа мэдээж эдийн засгийн өгөөж талаасаа харна. Нөгөө талдаа нийгмийн үр нөлөө талаасаа бас тооцох нь зүйтэй. Тэгэхээр энэ бол ирээдүйд хүүхэд, залуучуудад чиглэсэн, дээрээс нь нийтийн биеийн тамирыг дэмжсэн ийм төсөл байгаа. 2 дахь гол энэ дээр хаанаас ямар мэдээлэл авсныг мэдэхгүй байна. Тодорхой зүйл юу вэ гэхээр энэ бол ямар нэгэн зээлд хамрагдаагүй. Буцалтгүй тусламжаар хийгдэж байгаа ажил. Тэгэхээр гишүүдэд байгаа мэдээллийг бас үнэн зөв болгох нь зүйтэй болов уу гэж бодож байна. Хэрэгжүүлэгч байгууллага нь бол Барилга, хот байгуулалтын яам дээр хэрэглэгдэж байгаа төсөл байгаа.

Р.Батболд: Мөнхсоёл гишүүн тодруулъя.

Б.Мөнхсоёл: Ерөнхийдөө бол тэгж байгаа, ингэж байгаа гээд хэлээд байгаа. Тэгэнгүүтээ бодит байдал дээр тэгж байгаагүй, ингэж байгаагүй байдаг байхгүй юу. Жишээлбэл ээлжит бус чуулганы хурал дээр бид нар дарааллаа зөрчөөд хөгжлийн төлөвлөгөөг баталсан. Холбогдох тэр санхүүгийн эх үүсвэр, төсөв тооцоолол оруулж ирнэ гээд оруулж ирээгүй шүү дээ одоог хүртэл. Тэгэхээр ингээд нөгөө хуурмаг байдлаар цаг нөхцөөж, аргацаагаад байгаа юм нь бид нар бол хууртахгүй. Одоо үүнээс хойш бусад гишүүдийн хэлээд байгаачлан 1 л эх оронтой, 1 л үр хүүхдүүд маань амьдрах улс яг чин сэтгэлээсээ сайн ажилламаар байна. Хурлын асуултад аргацааж өнгөрөөж ерөөсөө болохгүй. Харъя. Тэгээд тэр одоогийн явцыг нь ч гэсэн хармаар байна. Маш олон этгээдүүдийг тэр төрийн нарийны хэлж байгаа шиг оролцуулах ёстой шүү дээ. Төлөвлөгөөнийхөө боловсруулалтад. Одоо явж байна гэдэг чинь хэрвээ 20, 30 хувьтай бол амжихгүй. 4 сарын өмнө үнэлгээгээ хийж эхлэх ёстой. Танилцуулах ёстой. Тэгэхээр энэ хугацаа дээр би эргэлзэж байна.

Р.Батболд: Мөнхсоёл гишүүн санал хэллээ. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

М.Бадамсүрэн: Шинэ парламент бол анх удаа хөгжлийн төлөвлөгөөг хэлэлцэж байна гэж ойлгож болно. Цаг хугацааны хувьд. Тэгэхээр энэ дээр бол хариуцлагатай хандах ёстой гэж үзэж хэдэн асуулт асууя.

1 дүгээрт энэ үнийн өсөлтийг хязгаарлах талаар ер нь Эдийн засаг, хөгжлийн яам, бусад яамтай хамтраад яг ямар арга хэмжээ авч байгаа вэ. Би яг тийм тодорхой хариулт авмаар байна. Ерөнхий хариулт бол сонсохгүй.

2-т нь хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар яг ямар бодлогын арга хэмжээ авах вэ. Эдгээр асуултууд нь яг Их Хурал Эдийн засгийн байнгын хороо яг ямар шийдвэр гаргах ёстой вэ гэдэг дээр илүү тулгуурлаж бас хариулаач гэж хүсэж байна.

Дараагийнх нь энэ өрх айл, бичил жижиг бизнесийг дэмжих чиглэлээр яг ямар ажил хийх вэ. Яг ямар ажил. Энийг ер нь хэр судалсан байдаг вэ.

4-д нь айл, өрхийн хамгийн хайртай хүн болох хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр яг ямар арга хэмжээ авах вэ. Зөвхөн сургуульд боловсролын байгууллагад найдаад орхих уу. Зөвхөн хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал гэж яриад, хөгжлийн асуудлыг нь орхиод байгааг яаж энийг ер нь сайжруулах вэ. Би тэгээд дахин давтаад хэлээд байгаа нь ерөнхий хариулт бол ерөөсөө авахгүй. Телевизээр ярьдаг юмыг бол бүгдийг нь сонсож байгаа, мэдэж байгаа. Тэгэхээр энэ дээр тодорхой, ажил хэрэгч хариулаач ээ. Өөрөөр хэлбэл хүүхэд бүр хөгжихөд нь хүн бүр хийж чаддаг, багш нар нь сургалтын төв ажиллуулахад нь, секц дугуйлан ажиллуулахад нь, өрх айл ногоо тарих, хувийн аж ахуйгаа хөгжүүлэхэд нь зориулж яг энэ улс орны хамгийн анхан шатын нэгж болсон өрх айлыг бичил, жижиг бизнесийг дэмжих чиглэлээр яг өмнөх онуудтай харьцуулахад энэ 2026 онд буюу энэ парламентын анхны хөгжлийн төлөвлөгөө батлах энэ төсөлд яг ямар зүйлийг оруулж ирж байгаа вэ. Хариулт бол их тодорхой авъя гэж бодож байна.

Дараагийнх нь энэ 2 дахь хэсэг нь төсвийн урсгал зардлыг бууруулах талаар ер нь бэлтгэл ажлаа хэр хангаж байгаа вэ. Түрүүн төрийн нарийн хариулсан. Гэхдээ энд яг ямар бэлтгэл ажил хийж байгаа вэ. Энэ чинь гэнэт шийдээд, гэнэт хэрэгжүүлчихдэг ажил биш шүү дээ. Олон удаа энэ дээр бодлого гаргасан боловч эсэргүүцэлтэй тулгараад больчихоод байдаг. Тэгээд энэ дээрээ ямар сургамж авч, ямар ажил хийж байгаа вэ.

Төрийн албан хаагчдын тоог бууруулахдаа одоо ажиллаж байгаа төрийн албан хаагчдын ажлаасаа болилоо гэхэд тэдний эрх ашгийг хамгаалах чиглэлээр ямар хувилбар, ямар сонголт өгч байгаа вэ. АНУ-д саяхан төрийн албаны тоог бууруулалтаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг та бүхэн мэдэж байгаа.

Дараагийнх нь төр өөрөө энэ газрын хэвлийн нөөцөө олж мэдэх, газрын хэвлийн ашигт малтмалын нөөцийг олж мэдэхэд зориулж ер нь хөрөнгө санхүүжилтийг хэр нэмэгдүүлэх вэ. Ингэхгүй бол ямар зүйл ороод байна гэхээр ингээд Онтера гээд л асуудал яригдаж байна. Оюутолгой гээд л яригдаж байна. Олон ордууд яригдаж байна. Тэгээд бид нар өөрөө нөөцөө мэддэг байгаад, өөрөө ингэж үнэ хаялцуулаад, өрсөлдүүлээд том орд дээрээ гэрээ байгуулахгүй. Тэгээд хувийн хэвшил хайгуул хийсэн гэдэг нэрээр тэд нар давуу байдлаар ордоо олгочоод, дараа нь бараг гуйж гэрээ байгуулах гээд байгаа юм шиг энэ урвуу тогтолцоогоо ер нь яаж засах вэ.

Монголын газрын тосны үйлдвэрт хэрэгцээтэй түүхий тосоор хангах зорилт тавьсан. 3 жилийн дараа ашиглалтад орно гэж байгаа. 7,4 их наяд төгрөг зарцуулж байгаа. Тэгээд энэ эх орныхоо түүхий тосоор нөөцөө хангахын тулд яг ямар бодлого яг одоогийн байдлаар хийгээд байна. Гадаадын компаниас олборлолтоо нэмж өгөөч гэж гуйх юм уу. Төр өөрөө энэ дээр ямар оролцоотой байх юм. Төрийн өмчит компани байх юм уу. Яг ямар бодлого хэрэгжүүлэх юм. Одоо 1 жил нь ингээд өнгөрвөл тэгээд цаана нь үндсэндээ ингээд 2 жил үлдэнэ.

Ашигт малтмалын нөөцийн төлбөр, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30-аас доошгүй хувийг орон нутагт хуваарилуулах чиглэлээр ямар бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа вэ.

Р.Батболд: Хариулт. Ажлын хэсгийн 3 номер.

И.Батхүү: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Энэ үнийн өсөлтөөс хязгаарлах ямар арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэх вэ.

1 дүгээрт нь бол түрүүн хэлсэн. Гадаад валютын нөөцийг тогтвортой хадгалах, нэмэгдүүлэх, төгрөгийн ханшийг бас тогтвортой хадгалах асуудал чухал байгаа.

2 дугаарт нь бол үнийн инфляцад нөлөөлдөг гол бүтээгдэхүүн бол хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийг бас онцгойлон анхаарах ёстой. Тухайлбал энэ хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийн үр дүнд хүнсний бүтээгдэхүүнээ нийлүүлэлт дотоодоосоо ханган нийлүүлэх, хангах асуудлыг бол онцгойлон анхаарах ёстой. Бас гадаад гаралтай инфляцыг нөлөөллийг бууруулахын тулд хил, гааль дээр аливаа саатал, бэрхшээл гаргахгүй тээвэр логистикийн оновчтой зохион байгуулалтад бас анхаарч ажиллах ёстой. Дээр нь бас төсвийн бодлого талаасаа, төсвийн алдагдлыг хязгаарлах бодлого нь бас энэ дамаар нөлөөлнө. Бас яг богино хугацааны асуулт асууж байгаа учраас хэмнэлтийн тухай хуулиар бас 5 сарын 31 гэхэд гэрээ байгуулж амжаагүй ажлууд бас санхүүжилт гарахгүй.

Тэгэхээр энэ ондоо бол инфляц дээр гол нөлөөлөх зүйлс бодлогын арга хэмжээнд бол эдгээр зүйлс байна. Урсгал зардалтай холбоотой макро эдийн засаг талаасаа ДНБ-д эзлэх хувь хэмжээг бууруулах асуудлуудыг түрүүн төсвийн хүрээ дээр явж байгаа асуудлаа танилцуулсан байгаа. Яг тодорхой арга хэмжээнүүдийг нь бол бас хариуцсан яамнууд нь хариулна. Бид нарын хувьд зүгээр урсгал зардал дээр төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, тэтгэмжийн инфляцын түвшинтэй нь нийцүүлж өсгөхөө тооцоод, цаана нь гадаад, дотоод томилолт, эд хогшил, худалдан авах зардал зэрэг бусад төрлийн зардлуудыг оновчтой болгох, бууруулах чиглэлээр ажиллах нь зүйтэй гэж үзэж байгаа. Энэ дээр бас тодорхой нарийвчилсан төлөвлөгөө гараад ажиллах байх. Бусдыг нь салбарын яамнууд хариулчих уу.

Р.Батболд: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Л.Мөнхзул: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхзул. Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд хүүхдийн хөгжил оролцоог дэмжих чиглэлээр 3 үндсэн ажил тусгагдсан байгаа.

1 дүгээрт ер нь Гэр бүлийн төв, Хуримын ордон, Хүүхдийн хөгжлийн ордон, Ахмад настны өргөө, Ахмадын хөгжлийн ордон гээд өөр өөр нэр бүхий маш олон барилга байгууламжууд улсын төсвийн хөрөнгөөр энд тэнд баригдсан байдаг. Гэсэн хэдий боловч тэр дээр яг нэгдсэн зохицуулалт бүхий үйлчилгээ маш ховор. Нөгөө талаасаа төр ба хувийн хэвшлийн түншлэл бага учраас төрийн албан хаагчид бараг манаачийн үүрэг гүйцэтгээд ингээд тэр ордны үйл ажиллагаа зарим газар боловсон хүчний дутагдалтайгаас болоод ажилладаггүй..../минут дуусав/

Р.Батболд: Гүйцээж хариулъя.

Л.Мөнхзул: Тийм учраас 2025 онд гэр бүлийн хөгжлийн эдгээр төвүүдийг үйлчилгээний төв байдлаар төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллах ажилд тусгагдсан. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр шинжлэх ухаан, технологийн парк байгуулах ажил бас үе шаттай эхлүүлэхээр 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан. 2026 онд бол зөвхөн төр хувийн хэвшлийн түншлэлээр энэ паркийн зураг төсвийг зохиох ажил дээр л төр оролцох юм. Үүнээс цаашаа бол хувийн хэвшлийн түншлэлтэй хамтарна гэж төлөвлөлт нь дунд хугацааны төлөвлөлтөд орсон. Боловсролыг дэмжих жилийн хүрээнд гэр бүлийн боловсролыг дэмжих үндэсний үйл ажиллагааг зохион байгуулахаар оролцож байгаа. Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжихээр амралт, чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, хөгжлийг дэмжих, зуслангийн үйл ажиллагааг өргөжүүлэх 4 ээлжээр ажиллуулах чиглэлээр ажил зохион байгуулахаар мөн төлөвлөлтөд тусгагдсан.

Р.Батболд: Одонтуюа сайдын микрофоныг өгье.

С.Одонтуюа: Хүүхдийн асуудал дээр нэмээд хариулъя. Өнгөрсөн Засгийн газрын хуралдаан дээр нөгөө хүүхдийн байгууллагын 100 жилтэй холбогдуулж бас хэд хэдэн чухал шийдвэр гаргахаар болсон. Ер нь бид хүүхдийг хамгаалах, нөгөөдөх нь бол хөгжүүлэх гэсэн ийм 2 чиглэл байгаа.

Хамгаалах дээр бол хамгийн чухал асуудал бол Гэр бүлийн тухай хууль 4 парламент дамжсан. Тэгэхээр энэ удаагийн парламент бол ямар ч байсан ер нь 2026 онд Гэр бүлийн тухай хуулийг оруулж ирж батлах нь бол туйлын чухал юм аа гэдгийг бас хэлсэн байгаа. Манай Улсын Их Хурлын гишүүд бас энийг онцгой анхааралдаа аварай.

2-т хүүхдүүдэд зориулсан орчин үеийн технологи, хиймэл оюун ухаанд суурилсан ийм өндөр технологийн төвийг байгуулъя. Хуучнаар бол Залуу техникчдийн ордон гэж байсан ийм төвтэй болъё гэсэн. Нөгөөх нь бол арт маягийн соёлын бас чиглэлээр ийм .../минут дуусав/

Р.Батболд: Уул уурхайн яам хариулах уу. Хаана байна. Сангийн яам түрүүлээд хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Ер нь бол зарлагыг бууруулах чиглэлээр тодорхой ажлуудыг бид хийгээд эхэлчихсэн байгаа. Засгийн газрын хувьд Төрийн бүтээмж, хэмнэлтийн зөвлөл дээр бид төлөвлөгөөгөө танилцуулсан. Мөн Улсын Их Хурлын даргын захирамжаар гарсан ажлын хэсэг дээр Булгантуяа даргаар ахлуулсан ажлын хэсэг дээр бас төлөвлөгөөгөө гаргаад танилцуулаад явж байгаа. Ер нь товчхондоо хэлэх юм бол манай зарлагын бүтэц маань өөрөө харах юм бол нийгмийн хамгааллын салбарууд маань дийлэнх хувь хэмжээг эзэлж байгаа. Эдийн засгийн ангиллаар нь үзэх юм бол цалин хөлс, халамж, тэтгэвэр тэтгэмж маань бол нийлээд 70 орчим хувь руу дөхөж байгаа ийм төсөвтэй. Манай бүтэц өөрөө. Нөгөө талдаа бол хувийн хэвшлээ илүү дэмжсэн гэж хэлж болохоор хөрөнгө оруулалтын зардлууд маань бол харьцангуй бага байдаг ийм төсөвтэй улс байгаа юм. Тэгэхээр бид хэрвээ хэмнэлтийг хийе ээ гэх юм .../минут дуусав/

Р.Батболд: Тодруулах уу. Гүйцээж хариулъя. 4 номер.

М.Санжаадорж: Баярлалаа. Тэгэхээр хүссэн, хүсээгүй энэ зардлууд дээрээ л бид нар ажиллахаас өөр аргагүй болж байгаа. Яг одоо Төсвийн байнгын хороо бол хуралдаж байна. Энд нөгөө талд Төсвийн хүрээний мэдэгдэл тэнд хэлэлцэгдээд явна. Төсвийн хүрээний мэдэгдэл бол энэ жилийн түвшинд байж байгаа. Ер нь зүгээр энэ гадаад зээлийн ашиглалтыг яаж нэмэх ёстой юм бэ гэдэг дээр уг нь өнгөрсөн 2024 оны тодотголоор бид энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулаад гарцыг нь бол гаргасан юм. Суурь зарлага гэж нэрлээд бид татварын орлогоор буюу төсвөөсөө санхүүжүүлэх ёстой зарлагуудаа нэг тусад нь авч үзье. Нөгөө талдаа зээлийн ашиглалтаар зарцуулах энэ зардлуудаа буюу бонд, зээлийн эх үүсвэртэй зардлаа бас тусад нь авч үзье гэдэг ийм бодлого оруулж ирж батлуулсан юм. Одоо бол бид нар алдагдалгүй төсөв тавьчихаад байгаа. Суурь зарлага маань уг нь бол алдагдалгүй байх ёстой гэдэг бодлого оруулж байсан боловч томоор нь нийт зарлагаа алдагдалгүй гэххээд байгаа юм. Тэгэхлээр алдагдалгүй төсөв гэдэг маань өөрөө зээл битгий ав гэдэг ийм л бодлого болчихоод байгаа юм. Тэгэхээр .../минут дуусав/

Р.Батболд: Уул уурхайн яам. АМНАТ-ийн талаар Сангийн яам хариулах уу. Ажлын хэсгийн 4.

М.Санжаадорж: Уучлаарай. Ер нь төсвийн орлогын нийт орлогын 33,4 их наяд төгрөгийн орлогын 11 их наяд нь уул уурхайтай холбоотой орлогууд байгаа. Үүнийх нь яг тал нь бол АМНАТ. Үлдсэн нь бол аж ахуйн нэгж, хувь хүн гээд ийм нэг зүйлүүдээр орж байгаа юм. Нийт АМНАТ-ийг бид нар аваад үзэх юм бол говийн бүс дангаараа 90 хувийг оруулж байгаа. Уул уурхайтай холбоотой орлогыг. Бид аль болох өмнө нь тэгшитгэн хуваах бодлого хэрэгжүүлдэг байсан юм бол одоо бол уул уурхайгаа яаж илүү дэмжих вэ, компаниудад яаж боломжийг нь гаргаж өгөх вэ гэдэг агуулгаар бол илүү түлхүү хуваарилалтыг тухайн уул уурхайн орлого олж байгаа тэр аймгууд руу чиглүүлсэн байдлаар эхний бодлогуудыг гаргаж ирээд явж байгаа. Энэ жилийн төсвөөр мөн адил энийгээ улам илүү нэмэгдүүлэх тийм бодлого бол бид оруулж ирнэ гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Баярлалаа.

Р.Батболд: Бадамсүрэн гишүүн тодруулах уу. Болсон уу. Тэр хайгуулаа нэмэгдүүлэх тал дээр асуусан. Уул уурхайн яам. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Б.Өнөмөнх: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Өнөмөнх. Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Ер нь геологи хайгуулын ажлыг эрчимжүүлэх, ашигт малтмалын батлагдсан нөөцийг нэмэгдүүлнэ гээд энэ төлөвлөгөө бол хэрэгжээд явж байгаа. Энэ 2023, 2024 онд агаарын геофизикийн аргаар геологийн судалгаа, шинжилгээний ажил хийгдэж байгаа. Тэгээд энэ ажил бас тодорхой хэд хэдэн шалтгааны улмаас бас саатсан. Гүйцэтгэл бол ер нь 33,5 хувьтай явж байгаа. Энэ дээр шалгарсан компанитай холбоотой бас төлбөр тэнцлийн асуудлын маргаан бас гарсан юм байна лээ. Тэгээд энийг геологийн албанаас тодруулаад холбогдох ажиллагааг хийгдэж байгаа. Ер нь бол улсын төсөв дээр төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа геологи хайгуулын ажлын төсөвт өртөг нь өөрөө бага байдаг. Тэгээд энэ дээр бол ер нь төсөвт өртгийг нэмэгдүүлэх, үнэхээр нөөцөө нэмэгдүүлэх ажил дээр хангалттай төсөв тавигддаггүй учраас энэ ажил маш удаашралтай явж байгаа гэдгийг хэлмээр байна.

Р.Батболд: Бадамсүрэн гишүүн тодруулъя.

М.Бадамсүрэн: Гишүүдтэй санал 1 байгаа. Эдийн засгийн яам бол ийм ямар зүйл хийвэл Монголд эдийн засгийн үр ашигтай байх вэ гэдэг рүү тэмүүлэх ёстой байхгүй юу. Сангийн яам магадгүй нягтлан нярвууд ийм падаан фактур бүрэн, өр тооцоонд орохгүй байна гэдэг шиг хямгадаж байж магадгүй. Тэгэхээр миний хэлээд байгаа зүйл нь энэ нөөц баялгаа өөрөө олж тодорхойлоод, тэгээд энэ дээрээ хамгийн ашигтай хэлцэл хийх зүйл рүүгээ явах ёстой байхгүй юу. Тэгээд энэ шалтгийг бол их олон жил сонсоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг өөрчлөөч ээ. Тэгэхэд яах гээд байгаа юм бэ гэж байгаа юм.

2 дугаарт нь тэр гэр бүлийн яамнаас бол наана чинь бүр бүтнээр нь таны хэлж байгаа тайлбарыг өөрчлөх ёстой шүү. Та нар зөвхөн ордон бариад зөвхөн нийслэлд юм уу, аймгийн төвд барьснаараа хүүхдийн хөгжлийн асуудал чинь хангагдахгүй. Тэр сум болгон хөдөө байгаа хүүхдүүдийг яаж хөгжүүлэх вэ гэдэг дээр ерөөсөө бодлогоо чиглүүлэх ёстой. Би ярианахаа эхэнд хэлсэн шүү дээ. Иргэн баян бол улс баян гэдэг. Айл өрх болгоны тэр хүүхэд өрх гэр бүлийн хөгжлийг дэмжих асуудал чинь амин чухал байхгүй юу.../минут дуусав/

Р.Батболд: Бадамсүрэн гишүүн санал хэллээ. Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууя.

О.Батнайрамдал: Баярлалаа. Өнөөдөр 5 сарын 14-ний өдөр Монгол Улсад магадгүй эдийн засгийн хамгийн өндөр ач холбогдолтой явж ирсэн боловч 18 жил гацсан Ганцмод-Гашуун Сухайт төмөр замын холболтын бүтээн байгуулалт маань 2 орны Засгийн газрын хэлэлцээрийн хүрээнд өнөөдөр ингээд нээлтээ хийж байгаа бас нэг түүхэн өдөр. Тэгэхээр энийг бас ажил хэрэг болгоход оролцсон бүх Монгол Улсын Засгийн газрын төлөөллүүд, ажилтан, албан хаагчид та бүхэндээ бас чин сэтгэлээсээ баярласнаа бас энэхүү түүхэн өдөр илэрхийлье гэж бодож байна.

Хүн төвтэй хөгжлийн үзэл санаанд нийцсэн эдийн засгийн эрх чөлөөг цогцлоох 2026 оны хөгжлийн төлөвлөгөө сонгуулийн лоозон шиг л сонсогдож байна л даа. Тэгээд сайхан сонсогдож байна. Гэхдээ яг сайхан сонсогдож байгаа шигээ тэгээд бүгдээрээ хэрэгжүүлж чадах уу.

Надад хэд хэдэн асуултууд байна. 1 дүгээрт бид нар 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг ярьж байхад ч гэсэн тэрнээс хиймэл оюун гэсэн үг сая Шадар сайдын дээр нэлээн хэдэн удаа давтагдлаа. Тэгэхээр хиймэл оюуныг төрийн бүх шатад нэвтрүүлэх гээд энэ санаа зөв. Бид нар хоцрох ёсгүй. Хиймэл оюуныг аль болох бүтээмжээ сайжруулахад ялангуяа төрийн үйлчилгээ дээр ашиглах нь зөв. Хамгийн гол нь бид нар энд бэлэн үү. Бэлэн байдлыг хангах хүрээнд юу хийгдэж байгаа вэ. Хиймэл оюуныг сайн ашиглая гэх юм бол өөрөө биг дата нь бүрдэх ёстой. Энэ хэр явж байгаа вэ. Одоо гол нь Монгол Улс хиймэл оюуны бэлэн байдлын үнэлгээгээ хийлгээд, үндэсний стратегиа тодорхойлох ёстой. Тэгээд тэр маань хийгдсэн үү. Хийгдэж байна гээд олон сар боллоо шүү дээ. Тэгэхээр тэрнээс л эхэлнэ гэсэн үг.

Реформын шинж чанартай томоохон реформууд зарласан байна. Төрийн албаны реформ, хиймэл оюун ашиглана. Төсвийн зардлын реформ урсгал зардлыг 15 хувиар бууруулна гэдэг бол бас маш том амбицтай реформ хэлж байна л даа. Тэгэхээр урсгал зардал 15 хувиар бууруулна гэдэг нь яг хэдэн хүн энэ

дээр төрийн албан хаагчдаас цомхотгоно гэсэн үг вэ. Энийг яг тоо баримттай хэлээч. Тэр хүмүүсээ бас яах вэ гэдэг цогц бас төлөвлөгөө бий юу. Төрийн өмчит компанийн бүтээмжийг 30 хувиар сайжруулна гээд. Энэ бол үнэхээр том амбиц сонсогдож байна шүү. Бид нар 30 жилийн хугацаанд 3 хувиар сайжруулж чадсан уу. Тэгэхээр 30 хувийг 1 жилийн дотор бид нар яаж амжуулах гэж байна. Энэ дээр ямар төлөвлөгөө гарч байгаа вэ. Мөн энэ 2026 оны хөгжлийн төлөвлөгөө маань улсын төсөвтэйгөө бол нэлээн уялдаад, жил болгон сайжраад явж байгаа нь сайн хэрэг. Харин том зургаараа Засгийн газрын үйл ажиллагааныхаа 4 жилийн хөтөлбөртэй хамтарсан засгийн үйл ажиллагааны хөтөлбөртэй хэр бас уялдаж байгаа вэ. Яг энэ 2026 оны хөгжлийн төлөвлөгөө хэдэн хувиар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдана гэж тооцоолсон бэ.

Дараагийн нэг асуулт нь тоо статистиктай холбоотой. Аялал жуулчлал дээр 2024 онд бид нар 800 мянган жуулчин авсан. Тэгээд 1,6 тэрбумын орлого олсон. 2026 онд 1,6 сая гээд бараг 2024 оны гүйцэтгэлээ бараг даблдах тоо харагдаж байна. Энэ хэр бодитой вэ. Мөн дарга аа, үргэлжлүүлээд 1 минутаа бас авчихъя.

Дараагийн 1 багц асуулт нь Оюутолгойтой холбоотой. Оюутолгой дээр бид ингэж дүгнэсэн байна л даа. Оюутолгойн гүний уурхайн нөлөөгөөр баяжмал дахь зэс, алтны агуулга өсөх нь салбарын өсөлтөд томоохон .../минут дуусав/

Р.Батболд: Батнайрамдал гишүүнд 1 минут.

О.Батнайрамдал: Энэ дүгнэлтээр бол ер нь Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалт цаашаа сайжраад, илүү эерэг нөлөөтэй гэж тооцсон байна л даа. Энийг би 2025 оны хөгжлийн төлөвлөгөө дээр бас ярьж байсан. Энэ Оюутолгой том төслийн хүрээнд бол энэ шилжилтийн үеэр орж байгаа юм. 16 жил мега төсөл явж ирсэн энэ төсөл маань бүтээн байгуулалт нь дуусаад, 20 гаруй тэрбум долларын зээлийн санхүүжилтээр бас энэ далд уурхайн бүтээн байгуулалт дуусаж байгаа байхгүй юу. Тэр он нь 2026 онд тохиож байгаа шүү. Тэгэхээр энэ цаашаагаа тогтвортой зүгээр олборлогч компани болоод явахаар бүтээн байгуулалтын тэр санхүүжилт нь байхгүй ээ. Тэгэхээр тэр саб контрактаар ажиллаж байгаа 20 мянган ажилчин тэгэхээр яг яах билээ. Ер нь бол ажилгүй болно гэж шууд л ойлгочхож болох байхгүй юу. Тэгэхээр тэр ажилчныг, тэр ажиллах хүчний стратеги төлөвлөгөө бас энэ 2026 оны төлөвлөгөөнд туссан уу. Би энийг бол 2 дахь жилдээ асууж байна шүү. Хариултаа авчхаад нэмж асууя.

Р.Батболд: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

И.Батхүү: Батнайрамдал гишүүнтэй санал нэг байна. Хиймэл оюуны хөгжил, бусад энэ дэлхий нийтэд гарч байгаа хөгжлийн шинэ чиг хандлагуудаас Монгол Улс хоцрох ёсгүй. Хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй холбогдох асуудлыг тусгаад явж байгаа. Яг энэ чиглэлээр бол Ерөнхий сайдын ажлын албан даалгавар гаргаад бас холбогдох яамд, бүх байгууллагууд бас үүрэг аваад ажиллаж байгаа. Хиймэл оюун шилжих шилжилтийн бэлтгэл ажил дээр.

Цахим яам дээр маань бас энэ стратегитай холбоотой асуудлууд хийгдэж байгаа. Тэрийгээ танилцуулах байх. Биг датаны хувьд бол Үндэсний статистикийн хороо дээр энэ Азийн хөгжлийн банктэй хамтраад энд бэлтгэл төсөл 1 жилийн өмнөөс хэрэгжээд явж байгаа. Манай яам ч гэсэн үүнтэй хамтраад ажиллаж байгаа. Нөгөө талаас бас аж ахуйн нэг, байгууллагуудын санхүүгийн мэдээлэл,

санхүүгийн тайлан, татварын тайлан цахимаар өгөгддөг болоод 10-аад жил болж байгаа. Энэ бас их том ач холбогдолтой, бүтэцтэй мэдээлэл бий болж байгаа. Манай яамны зүгээс Төрийн худалдан авалтын тухай хуулийн шинэчилсэн өөрчлөлт дээр аж ахуйн нэгжүүдийн яг бүтэцтэй датаг ашиглаад, аж ахуйн нэгжүүдийн чадавхыг үнэлдэг хиймэл оюун нэвтрүүлэх тодорхой саналуудыг өгөөд явж байгаа.

Бас хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн сан боловсруулах дээр бас манай яамны хүлээсэн үүрэг байгаа. Энэ сангаа бүрдүүлэхдээ газар зүй, орон зайн мэдээллээс гадна хиймэл оюун ухаанд түшиглэсэн бас шийдвэрүүдээ зохицуулалтуудыг оруулъя гэж ажиллаж байгаа. Тэгээд бусад асуултууд дээр холбогдох яам мэдээлэл нэмээд өгчих үү.

Р.Батболд: Номин сайдын микрофоныг өгье.

Ч.Номин: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Энэ аялал жуулчлалын салбар дээр алдаа гарсан юм шиг байгаа юм. Манай салбарын хувьд 2030 он хүртэлх стратегия тодорхойлоод, үүн дээрээ бид нар 2030 он гэхэд 2 сая жуулчин, 4 тэрбум долларын орлого олно гэсэн ийм тодорхой тоо гарсан байгаа. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд аялал жуулчлалын салбарын өсөлт бол ойролцоогоор 9 орчим, 7-9 хувьтай жил бүр нэмэгдэж яваа. Бидний хувьд бол зорилт жилд 16 хувиар нэмэгдүүлнэ гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Тэгээд үүгээрээ үзэх юм бол бид нар 2026 он гэхэд 1 сая жуулчин хүлээж авахаар төлөвлөгөөтэй байгаа.

Гэхдээ ингэхдээ бид нар бас ажил хийх шаардлагатай байгаа. Энэ нь төр хувийн хэвшил нийлсэн 4 тэрбум долларын хөрөнгө оруулалт Монголд орж ирж хийгдэж байж буюу дэд бүтцээ нэмэгдүүлэх, нислэгийн тоогоо нэмэгдүүлэх, дээрээс нь жуулчин ирээд ая тухтай байх орчнуудыг бүрдүүлэх ажлуудыг бол бид нар хийж хэрэгжүүлэх шаардлагатай байгаа. Тэгэхээр яг тодорхой хэлэхэд бол 2026 онд бид нар 1 сая жуулчин авахаар төлөвлөгдсөн байгаа. Тэгэхээр энэ нөгөө хууль дээр тавигдахдаа тооны алдаа гарсан байна гэж харж байна.

Р.Батболд: Одонтуяа сайдын микрофоныг өгье.

С.Одонтуяа: Хиймэл оюун ухаан дээр манай яам БНСУ-ын мэргэжилтнийг нөгөө зөвлөхөөрөө авч ажиллуулж байгаа. Тэгэхээр энэ дээр бол нэлээд бас гайгүй үр дүн гарах болов уу гэж бодож байна. Яагаад гэхээр манай яамны манай салбар өөрөө их өргөн хүрээтэй салбар. Маш олон мэдээллүүд нь тархуу байдаг, хүмүүс олоход хэцүү. Тэгэхээр энэ хиймэл оюун ухааны тусламжтайгаар бид нар энэ бүх мэдээллийг бүгдийг нь хүн дор бүрд нь авах энэ боломжийг бүрдүүлэхээр ингээд мэдээллийн сангаа нэгтгээд ажиллаж байгаа. Энэ бүтээмжийг дээшлүүлбэ, төрийн албаны хүнд суртлын багасгая гэдэг дээр манай яам дээр бол бид 12 хуулийн төслийг Улсын Их Хурлаар оруулах гэж байгаа. Тэрний хамгийн чухал хууль нь Байгаль орчны үнэлгээний тухай хууль. Хуучин бол том уул уурхай ч адилхан, жижиг эмнэлгийн лаборатори ч адилхан бүгд 150 хоног дамжиж байж энэ зөвшөөрлийг авдаг. Одоо бид бүгдийг нь цахимжуулаад, зарим жижиг дундууд бол зүгээр цахимд бүртгүүлээд л болно. Зөвшөөрөл шаардахгүй болгоно. Мэдээж том том уул уурхайн аюултай хог хаягдлынх бол тодорхой зөвшөөрөл авна. Тэгэхдээ хугацааг нь 4 дахин богиносгоод явж байгаа.

Одбаяр сайдын яамтай манай яам хамтраад, төрийн байгууллагад хийх нөгөө процессын дахин инженерчлэл гээд чухал төсөл эхлүүлчихсэн. Бүх судалгааг манай яаманд хийгээд өгчихсөн. Энэ бол бүтээмжийг дээшлүүлэх маш чухал арга хэмжээ болж байгаа. Өөрөөр хэлбэл хөндлөнгөөс харахгүй бол манай салбарт ажиллаж байгаа хүмүүс чинь бүр ийм хуучин юмнаасаа салахгүй л байгаад байдаг. Нөгөө л бичиг цаасандаа дарагдаад байдаг. Тэгэхээр энэ процессын дахин инженерчлэл бол манайд их чухал үүрэгтэй өөрчлөлтийг авчирна.

Дээрээс нь бид мэргэжлийн нэгдсэн холбоод руу маш олон үүргийг шилжүүлж өгч байгаа. Тусгай зөвшөөрлүүд шаардлагагүй зүйлийг бүгдийг нь мэргэжлийн нэгдсэн холбоодын хууль гарсан учраас шилжүүлж байна. Төрийн бус байгууллагууд руу бас маш олон үүргийг бол шилжүүлж байгаа. Тэгэхээр энэ 2026 онд манай салбарын хувьд бол бүтээмж дээшлэх ийм боломж гарна гэж харж байна.

Р.Батболд: Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

П.Алтан-Од: Цахим хөгжлийн яам Алтан-Од. Гишүүний асуултад нэмж хариулъя. Цахим хөгжлийн сайд 2025 оны 2 дугаар сарын 27-ны өдөр ажлын хэсгээ гаргаж, Оксфорд Инсайт индикатор тавьж үнэлдэг олон улсын байгууллагатай хамтарч Монгол Улсын бэлэн байдлын индексийн үзүүлэлтүүд, цаашид хиймэл оюуны стратегийг ямар түвшинд хэрэгжүүлэх вэ, хэзээ батлах вэ гэдэг асуудлуудаар өргөн хүрэлцээтэй олон улсын эрдэмтдийг урьсан ийм хэлэлцүүлэг зохион байгуулсан. Ингээд Монгол Улс 2023 онтой харьцуулахад 2024 онд нийт 188 улсаас 11 байр урагшилж, 98 дугаар байрт эрэмбэлэгдсэн байгаа. Энэ нь бол засаглалын хувьд 3 үндсэн бүлгийн 11 дэд бүлэгт хуваарилагдсан. 40 орчим үзүүлэлтээр энэ үзүүлэлтүүдийг нарийвчилж гаргадаг ингээд .../минут дуусав/

Р.Батболд: Ажлын хэсгийн 4 номер.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Ер нь төрийн албаны урсгал зардлыг хэмнэх ажлыг зайлшгүй хийнэ. Энэ дээр 2 янзаар хийж явъя гэж тооцож байгаа юм.

Эхний асуудал бол ер нь бид нар төрийн албан хаагчийн цалин хөлс нийгмийн баталгааны асуудлыг нэгдсэн 1 хуулиар зохицуулъя гэдэг асуудал оруулж ирэхгүй бол салбар болгон өөрсдөө хуулиараа зохицуулчихсан. Салбар болгон нэгнийхээ дээр гарах гээд ингээд орлогын тэгш бус байдал үүсгээд байгаа юм. Энийг бүгдийг нь нэг хуулиар зохицуулах, 1 зарчимтай болгох энэ асуудлыг хийж явах шаардлагатай байгаа.

Нөгөө талдаа чиг үүргийн шинжилгээ гэдэг зүйлийг бид нар өргөн хүрээнд бүх зүйлээр бол хийе гэж үзэж байгаа. Одоогийн байдлаар нийтдээ нийт хуулиас үзэхэд бол 208 хуульд 1028 төсөвтэй холбоотой заалтууд байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл төр санхүүжүүлнэ гэхээр төрийн чиг үүрэг гэдгийг бол заагаад ирчихсэн. Тэгэхдээ аль ч хууль дээр нэгдсэн байдлаар бол төрийн чиг үүрэг яг аль нь юм бэ гэдэг зүйл нь бол тодорхойгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ төрийн чиг үүрэг дээрээ илүү анализ хийх хэрэг .../минут дуусав/

Р.Батболд: Ажлын хэсгийн 3 номерын микрофон.

И.Батхүү: Батнайрамдал гишүүний асуултад бас нэмж хариулъя. Оюутолгойн зэсийн агууламж нь нэмэгдээд бас алтны агууламж нь нэмэгдэж байгаа учраас эдийн засгийн өсөлт бол нэгж хувиар нь өсөлт авч ирж байгаа. Үнэн. Тэгээд 2026 оноос бүтээн байгуулалтын цикл нь дуусаад, цаашаагаа энэ туслан гүйцэтгэгчид энд ажиллаж байгаа болон өнгөрсөн хугацаанд ажилласан боловсон хүчнийг яах вэ гэдэг асуудал. Засгийн газраа тавьж байгаа ирэх 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт 149 томоохон төсөл, арга хэмжээ туссан. Бидний зүгээс 14 мега төсөл гэж бас яриад байгаа юм. Эдгээр төслүүд дээр бас ийм чадварлаг туслан гүйцэтгэгчид, инженер, техникийн ажилтны хэрэгцээ шаардлага маш их байгаа. Тэгэхээр бас энэ хувийн хэвшлийн орон зай бас цаашаа хадгалагдаад шилжилт явагдаад ажиллана гэж үзэж байгаа юм.

Р.Батболд: Ажлын хэсгийн 3 нэмж хариулъя.

И.Батхүү: Энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө бол үйл ажиллагааны хөтөлбөртэй 100 хувийн нийцэлтэй байгаа. Бид энэ дунд хугацааны, урт хугацааны бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн 2026 онд хүрэх түвшнийг голлон анхаарч, дээд талаасаа бодлогын баримт бичиг талаасаа анхаарсан. Доод талаасаа буюу доороосоо дээшээ арга зүйгээр бол бүх төрийн байгууллага агентлаг, төрийн өмчит компанийн, аж ахуйн нэгжүүдийн бас хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажлуудыг анхаарч энэ саналдаа тусгаж ажилласан.

Р.Батболд: Батнайрамдал гишүүн тодруулах юм уу.

О.Батнайрамдал: Ялангуяа тэр Оюутолгой өөрөө нэлээн комплекс шүү. Энэ олон үйл явдал өрнөөд байгаа байхгүй юу. Тэгэхээр Оюутолгойн жишээлбэл борлуулалтын орлого 2025 оноос 4,2 тэрбум буюу 2024 онтой харьцуулах юм бол бараг 2 дахин сайжирч байгаа. Яах вэ тэгэхээр бид нарт АМНАТ-ийн илүү орлого л орж ирэх байх л даа. Гэхдээ тэр 4 тэрбум доллар орж ирэхээр эдийн засагт шууд нөлөөлчихнө гэдэг буруу ойлголтыг өгч болохгүй шүү. Монгол руу орж ирэх урсгал нь буцаад яг зөвхөн Монголд үүсэж байгаа тэр үйл ажиллагааны болон капитал зардлаа л хаах мөнгө нь орж ирэхээс биш бусад орлого, нэмэлт орлого нь бол Монголд орж ирэхгүй шүү. Тэгэхээр тэрийг эдийн засгийн нөлөөнд тооцоод байх юм бол наадах чинь буруу тооцоолол болно шүү.

2 дугаарт би хариултаа авахгүй л байна л даа. Тэр төрийн өмчит компанийн бүтээмжийг 30 хувиар сайжруулна гээд маш том амбиц байна шүү дээ. Тэгэхээр тэрийг яаж хийх гээд байгаа юм бэ. Тэрийгээ бас нэмэлтээр асуумаар байна. Яг 30 хувь гэдэг тооцоолол хаанаас гарсан юм.

Р.Батболд: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

Д.Дэлгэрмаа: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Яг нарийн тооцооллыг бол хариуцаж байгаа, төрийн өмчит компанийн асуудлыг хариуцдаг Баяр-Эрдэнэ дарга эзгүй байгаа учраас би оронд нь оролцож байна. Хуулийн хэлтсийн дарга Дэлгэрмаа байна. Би түрүүн бас хэлж байсан. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг Нийтийн өмчийн тухай хууль болгоод Улсын Их Хуралд өргөн барьж байгаа. Дээрээс нь Бүтээмж ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийг өргөн барьсан байгаа. Энэ хуулийн хүрээнд төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг ойлголт байхгүй. Энэ үйлдвэрийн газруудыг нэг бол ашгийн төлөө компани хэлбэрт

оруулна. Нэг бол татан буулгах, үйл ажиллагааг нь нэгтгэх, нийлүүлэх ийм зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд үйлдвэрийн газар, компани төрийн өмчит үйлдвэрийн газрын бүтээмж үр ашиг, зардал нь багасаж үр ашиг сайжрах ю гэсэн ийм хариултыг өгье.

Р.Батболд: Хариулт хангалтгүй гэж байна. Батнайрамдал гишүүн ээ, байж байгаарай. Би нэг юм хэлчихье. Сая ямар сонин юм ярьчихав. Нөгөө бүтээмжийг сайжруулна гэсэн чинь аж ахуйн нэгжүүдтэйгээ өрсөлдөөд, төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдээ бүгдийг нь ашгийн төлөө болгоод явах гэж байгаа юм уу. Сая тиймэрхүү утгатай юм ярьчих уу. Энэ маш хариулт өгчихсөн. Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

Д.Дэлгэрмаа: Нийгмийн хариуцлагын хүрээнд ажиллаж байгаа компаниуд байгаа. Дээрээс нь аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа боловч алдагдалтай олон жил ажилласан компаниудыг үйл ажиллагааг нь сайжруулахын тулд үйлдвэрийн газрыг хуулийн хүрээнд бол үйлдвэрийн газар гэдэг хуулийн этгээдийн ангилал байхгүй болж байгаа. Компани хэлбэрт оруулж ашигтай ажиллуулах хэлбэр лүү явуулна. Алдагдалтай ажиллаж байгаа үйлдвэрийн газруудыг бол татан буулгах нөгөө хуулийн этгээдийн реформ хийх юм.

Р.Батболд: Батнайрамдал гишүүн тодруулъя.

О.Батнайрамдал: Яах вэ хариуцсан хүн нь байхгүй байх шиг байна. Буруу хариулж байна шүү. Төрийн өмчит компанийн бүтээмжийг 30 хувиар сайжруулна гэдэг бол маш том амбиц. 30 жил бид нар хийж чадаагүй амбиц байхгүй юу. Төрийн өмчит компанийн бүтээмжийг сайжруулахад улс төрийн шийдвэр л гаргах ёстой юм. Сайн менежмент авах ёстой. Улс төрөөс хараат бус байлгах ёстой. Монголын хөрөнгийн бирж дээр гаргах ёстой. Хаанаас эхэлнэ гээч. Оюутолгойгоос эхлэх хэрэгтэй. Оюутолгойг тойрсон бүх гэрээ дээр бол заалт нь нээлттэй байгаа шүү. Монгол Улсын Засгийн газар шийдвэр гаргах л дутуу байгаа. Хөрөнгийн бирж дээр гаргаад, ил тод байдлыг хангаад, энэ нь өөрөө тэр бүтээмжээ өөрсдөө сайжруулаад явж байна. Тэрнээс биш төр бүтээмж сайжруулах гээд ардаас нь хөөцөлдөөд биш байхгүй юу. Тэгэхээр энэ логикийн алдаа явж байна. Ер нь бол төрийн өмчит компаниуд томорсон болохоос биш бүтээмж нь сайжирсан компани маш цөөхөн шүү дээ. Тэгэхээр энэ улс төрийн том шийдвэрүүдээ гаргахгүй бол энэ юун 30 хувь. 3 хувиар сайжруулна гэдэг чинь .../минут дуусав/

Р.Батболд: Санал хэллээ. Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Өнгөрсөн намар бид нарыг Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, 2025 оны улсын төсөв баталж байх цаг үед бол бас эдийн засгийн нөхцөл байдлын талаар маш өөдрөг төсөөлөлтэйгөөр тоонууд орж ирсэн. Тэр өөдрөг төсөөллөө бол бид нар бас баталсан байж байгаа. Харамсалтай нь тэр өөдрөг төсөөллүүд бол бас бодит амьдрал дээр төдийлөн биеллээ олохгүй байгаад байна. Нөхцөл байдал бол бас эрс өөрчлөгдөж байна гэсэн үг. Тэгэхдээ яах вэ угаасаа л манай Монгол Улсын эдийн засаг түүхий эдийн үнийн мөчлөгөөс хамааралтай, эдийн засгийн бас тийм сул талтай олон жил явж ирлээ. Харамсалтай нь бол яах вэ өнгөрсөн хугацааны түүхий эдийн үнийн өсөлтийг бас төдийлөн бид сайн ашиглаж чадсангүй. Ингээд дахиад нэг ийм мөчлөгтэй золгож байх шиг байна. Тэгэхээр энэ удаад бид нар бол маш ухаалаг байдлаар энэ хөгжлийн төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдэл, ер нь энэ жилийнхээ төсвийг

тодотгох, ирэх жилийн төсвийг бол бас их ухаалаг байдлаар л батлах хэрэгтэй байгаад байгаа юм л даа. Тэгэхээр тэр нь бол заавал танана гэсэн ч үг биш. Ер нь Монгол Улсын хувьд эрэмбийн хувьд юу чухал юм бэ. Ирэх 3 жил бид нар яг ямар зүйлүүд хийж хэрэгжүүлж амжих юм бэ гэдэг зүйлүүд дээрээ бол энэ Улсын Их Хурал, Засгийн газар нэлээн нухацтай яримаар санагдаад байгаа энэ завшааныг ашиглаад.

Хөгжлийн төлөвлөгөөгөө бол Эдийн засгийн хөгжлийн яамнаас оруулж ирж байгаа. Тэгээд эдийн засгийн эрх чөлөөний реформ нэртэй бас ийм реформын шинж чанартай төлөвлөгөө оруулж ирж байгаад бол баяртай байна. Тэгээд энэ төрийн албыг илүү оновчтой болгох, төрийн өмчит компаниудын бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх гэх зэргээр эдийн засаг дахь төрийн оролцоо бол хэрээс хэтэрлээ гэж бид бас яриад удаж байна шүү дээ. Тэгэхээр яг энэ зүйлүүдийг барьж авч байгаад нь бол талархаж байна. Тэгээд энэ завшааныг ашиглаад энэ Сангийн яам маань энэ Татварын багц хуулиа яагаад оруулж ирэхгүй байгаад байгаа юм бэ. Хэрэв жишээлбэл төр төсөв талдаа иймэрхүү реформууд хийгдэж байлаа гэж үзэхэд бас яг хувийн хэвшлээ дэмжих, хувийн хэвшил дээр ажлын байрыг нэмэгдүүлэхийн тулд татварын хувь, хэмжээ бууруулах асуудлууд юу болж байна. Яагаад энэ татварын бас реформын шинж чанартай зүйл орж ирэхгүй байна гэдгийг Сангийн яамнаас асууя.

Тэгээд ер нь 2025 оныхоо төсвөө ч гэсэндээ нэгмөсөн тодотгоод урагшаа явчих нь зүйтэй гэсэн байр суурийг би бол илэрхийлээд л байгаа. Нэг тусгайлсан хэд хэдэн тодорхой асуултууд байна. 2024 оны төсвийн тодотголыг бид энэ Их Хурал дөнгөж байгуулагдсан даруйдаа ээлжит бус чуулганаар хийсэн. Тэгээд тэр төсвийн тодотголд болохоор нэлээн өндөр дүнтэй ТЭЗҮ-ний зардлууд багтсан байсан. Тэгээд Амарсайхан сайд гараад явчихсан байна. Бүсийн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төслүүдийн ТЭЗҮ, зураг төсөв гээд 70 тэрбум. Үүгээр ямар ТЭЗҮ-үүд хийгдсэн бэ. Өөдөө тэмүүлэх ган татлагат гүүр 28,6 тэрбум. Энэ юунд зарцуулагдсан бэ. Хөшгийн хөндийн туннел төсөл 55,3 тэрбум. Шинэ их тойруу хурдны зам 23 тэрбум гэх мэт маш өндөр дүнтэй ТЭЗҮ-ийн төсвүүд 2024 оны төсвийн тодотголд тавигдсан л даа. Тэгээд эд нар нь юу болсон бэ. Энэ дээрээ маш тодорхой хариулт авмаар байна шүү.

14 мега төсөл гээд байгаа. Би бол түрүүн хөгжлийнхөө төлөвлөгөөг, дунд хугацааны бас зорилтуудаа тодотгохын тулд яг ямар төслүүдийг хэрэгжүүлэх юм бэ гэдгээ нэлээн нухацтай ярьчихъя гээд байгаа. Тэгээд энэ 14 мега төслийн дунд Тавантолгой цахилгаан станц орсон байгаа л даа. Тэгээд энэ болохоор хөгжлийн төлөвлөгөөнд зүгээр гадаад, дотоодын хөрөнгө оруулалт гээд эх үүсвэр нь тодорхойгүй 2,3 их наяд гээд тавигдсан байж байна. Энэ юу болж байгаа вэ.

Р.Батболд: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон. Сангийн яам хариулах уу.

М.Санжаадорж: Сангийн яамны Санжаадорж. Жаргалан гишүүний асуултад хариулъя. Татварын реформтой холбоотой асуудлаар бид судалгааны шатанд хийгээд явж байгаа. Нөгөө талдаа бас мөн олон улсын түншлэгч байгууллагуудтай танилцуулах, энэ нь цаашаа төсвийн импакт нь зөвхөн төсвөөсөө гадна хувийн хэвшил дээр ч гэсэн яаж үзүүлэх вэ гэдэг дээр ажлууд бол хийгдээд явж байгаа. Тэгээд яах вэ, татварын формыг угаасаа нөгөө хуулиараа юу гэж заасан бэ гэхээр жилийн төсвийн хуультай хамт оруулж ирэх хуулийн заалт байгаад байдаг. Өөрөөр хэлбэл энэ маань өөрөө төсвийн орлого дээр нөлөөлдөг учраас. Тийм

учраас намар оруулж ирнэ гэсэн ийм юутай байгаа. Наана нь бол хэлэлцүүлгийг бүх шатад бол хийгээд явж байгаа ийм зүйл байгаа.

Р.Батболд: ТЭЗҮ-үүдийн гүйцэтгэл. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Дэлгэржаргал: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Сангийн яам, Дэлгэржаргал Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар. 2024 оны төсвийн тодотголоор яг Улаанбаатар хотод хийгдэх томоохон бүтээн байгуулалтуудтай холбоотой бэлтгэл ажлыг хангах дээр нийтдээ 7 төсөл, арга хэмжээ дээр 258,8 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдчихсан. Энэ төслүүдийн хувьд бол 2024 онд яг хэрэгжиж дуусахаар батлагдсан учраас оны төгсгөлийн санхүүжилтийг бол захиалагч байгууллагын хүсэлтээр барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байгаа. Төслүүдийн яг одоогийн авсан мэдээллээр бол гэрээ байгуулах үйл ажиллагаанууд явагдаж байгаа. Энэ төслүүдийг бүхэлд нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлж байгаа учраас яг одоо явц болон хэрэгжилтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх байх.

Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан санхүүжилтийн хувьд бол энэ оны 8 сарын 30-ны дотор 100 хувийн гүйцэтгэл гарч дуусахаар байгаа.

Р.Батболд: Нийслэл нэмж хариулах уу. Нийслэл энэ дээр тайлбар хийх үү. Ажлын хэсгийн микрофон дээр очиж суухгүй бол. Амарсайхан сайд хариулж байх уу. Амарсайхан сайдын микрофоныг өгье.

С.Амарсайхан: Жаргалан гишүүний асуултад тодорхой хариулъя. Бүсчилсэн хөгжилтэй холбоотой асуудал, бүсийн хөгжлийн гол үндсэн шалгуур, шаардлага нь өөрөө зөвхөн зам, дэд бүтэц, бүтээн байгуулалт, ахуйн шинж чанартай хөрөнгө оруулалтаас илүүтэй хүний хөгжлийн асуудал 1 дүгээрт байх ёстой. Энэ нь өөрөө хүн эрүүл, боловсролтой, өрсөлдөх чадвартай, мөн хөрвөх чадвартай байж байж өөрөө тухайн бүс нутагт хүн оршин тогтнох, тэр хэрээрээ ажиллаж амьдрах, нөгөө бүсийн хөгжлийн гол хүн суурьтай, хүн төвтэй хөгжил болж үр дүнгээ өгөх ийм боломж нөхцөл бүрдэнэ. Тийм учраас бид нар бүсчилсэн хөгжлийн чиглэлээр хийгдэж байгаа аливаа ажил дэд бүтцээсээ эхлээд цаашлах юм бол нийгмийн дэд бүтэц болсон сургууль, цэцэрлэг, тэгээд бусад нийгмийн бүтээн байгуулалтад соёл спорт мөн эрүүл мэндийн чиглэлийн үйлчилгээнээс эхлээд сургалтын хөтөлбөр, арга барил, тэгээд амьдрах ухааны хөтөлбөрүүдтэйгээ уялдсан байдлаар орон нутагт хэрэгжих боломжийг нь бүрдүүлэхээр ажиллаж байгаа. Жишээ нь ганцхан жишээ хэлэхэд говьд бол НҮБ-ын хүн амын судалгаагаар нийт улсын хүн амын 6 хувь ажиллаж амьдарч байгаа. Гэтэл тэнд өнөөдрийн байдлаар 19-25 насны залуучууд буюу ид хөдөлмөрийн сурч боловсрох насны залуучуудын эзлэх хувь багассан байна. Мөн цаашлах юм бол ажиллах хүчний дутагдалд орох ийм эрсдэлтэй байна. Хүн тогтож амьдрах нөхцөл бүрдэхгүй ингээд бол 2030 он гэхэд тэнд хүн амын тоо 5,7 болж буурах ийм эрсдэлүүд бий болсон байгаа юм. Тэгэхээр энэ юуг хэлж байна гэхээр бид нар зөвхөн говийн бүс гэлтгүй бүх бүсүүдэд хүн ажиллаж амьдрах орчин нөхцөлийг 1 дүгээрт бүрдүүлээд, тэндээ бусад бүтээн байгуулалт болон эдийн засгийн төрөлжсөн .../минут дуусав/

Р.Батболд: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Т.Даваадалай: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Засаг даргын 1 дүгээр орлогч Даваадалай. 2024 оны Засгийн газрын 249 дүгээр тогтоолоор ТЭЗҮ-

ийн ажил нийслэл дээр 5 ТЭЗҮ явагдаж байна. Нийслэл рүү шилжиж ирсэн юугаар бол нийт 42,9 тэрбум. 5 ТЭЗҮ.

1 нь болохоор трамвааны 1, 2 дугаар шугамын ажлуудын ТЭЗҮ-үүд бол нийт 5,5 тэрбумаар, одоо үйцэтгэл 95 хувийн гүйцэтгэлтэй явж байна. Зам, тээврийн яам дэргэдэх шинжлэх ухааны дэд зөвлөлөөр орсон. Ирэх 7 хоногт Зам, тээврийн яамны дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр оруулаад, авто тээврийн төв дээр батлагдаад, энэ сардаа батлагдаад трамвааны 1, 2 дугаар шугамын ТЭЗҮ бол нийт 5,5 тэрбумын ажлын гүйцэтгэл 95 хувьтай явж байн.

Мөн уулзваруудын нэвтрэх чадварыг сайжруулах талаар техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажил 20 хувийн гүйцэтгэлтэй гүйцэтгэж байгаа. 4,5 тэрбумын төсөвтэй 2024 оны 2 .../минут дуусав/

Р.Батболд: Гүйцээж хариулъя.

Т.Даваадалай: Шинэ тойрог авто замын 1 дүгээр тойрог авто замын урьдчилсан техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах ажил 16,9 тэрбумын үнэлгээтэй. Энэ ажил ойролцоогоор 70 хувийн гүйцэтгэлтэй явж байгаа. 6 сарын 20-ны өдөр дуусгана гэсэн урьдчилсан ийм төлөвлөгөө гаргаад, ТЭЗҮ-ийн ажил бол үргэлжилж байгаа.

Мөн Улаанбаатар хотын шинэ тойрог замын 2 дугаар тойрог замын хурдны авто замын ТЭЗҮ-ийг бид нар Зам, тээврийн яам дээр гүйцэтгэсэн ажлыг бол эрхийг нь шилжүүлж аваад, үргэлжлүүлэн ажиллаж байгаа. Ийм явцтай нийслэл хот дээр нийт 42,9 тэрбумаар 5 ТЭЗҮ-ийн ажил бол гүйцэтгэж байна.

Гүүр болон Богд уулын ТЭЗҮ-ийн ажлууд Зам, тээврийн яам дээр хэрэгжүүлж байгаа.

Р.Батболд: Эрчим хүчний яамнаас 5 толгой цахилгаан станцтай холбоотой асуудал байгаа. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

О.Хуягцогт: Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газраас Хуягцогт. Жаргалан гишүүний асуултад хариулъя. Тавантолгой ДЦС төслийн нийтдээ 696 сая орчим долларын ийм төсөвтэй ТЭЗҮ нь батлагдсан. Энэ төслийг 70 хувийг нь бол хөрөнгө оруулагч, гүйцэтгэгч талаас санхүүжилтээ босгох, 30 хувийг нь Эрдэнэс Монгол энэ дотоодын эх үүсвэрээс шийдвэрлэх ийм нөхцөлтэй Засгийн газрын чиглэлийн дагуу 2023 онд тендер зарлагдсан. 2023 оны тендер бол зарлагдаад шалгарсан боловч энэ дээр гүйцэтгэгч тал өрсөлдөгч талуудаас тендерийн маргаан гарч 3 шатын шүүхээр хэлэлцэгдээд 2024 оны 12 сард шүүхийн эцсийн шийдвэр гарч, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүчингүй болгосноор тендер шалгаруулалт маань цуцлагдсан. Ингээд дахиад тендер зарлах гэхээр тендерийн 20 .../минут дуусав/

Р.Батболд: Гүйцээж хариулъя.

О.Хуягцогт: Дахиад энэ шүүхийн шийдвэр эцэслэн гарсан тул дахин тендер зарлахад 2024 оны 1 сарын 1-ээс хэрэгжсэн тендерийн хуулиар түлхүүр гардуулах нөхцөлөөр тендер зарлахыг хязгаарлачихсан ийм хуулийн орчин бүрдчихсэн. Тэгэхээр энэ төслийн онцлог нь бол И Пи Си нэмэх нь санхүүжилтээ гүйцэтгэгч тал

нь өөрөө 70 хувийг нь босгох ийм нөхцөлтэй тендер шалгаруулалт нэлээн том 14 мега төслийн 1. Тэгэхээр энэ дээр бол эрх зүйн орчныг нь том төслүүд явуулах боломжтой болгож өөрчлөх ажлууд яам болон Засгийн газрын түвшинд зохион байгуулагдаж байна. Ингээд 2025 ондоо тендер шалгаруулалтыг дахин зарлаж, хэрэгжилтийг эхлүүлэх ийм зорилттой ажиллаж байна.

Р.Батболд: Жаргалан гишүүн тодруулъя.

Б.Жаргалан: 2025 ондоо тендер зарлаад, тэгээд дараа нь нөгөөдөх нь хэзээ баригдаад явах юм. Ийм удаан бас ажилламааргүй байгаад байна. Тэгэхээр Засгаас жишээлбэл хэрэв эрх зүйн орчин нь хангалтгүй байгаад байвал хууль оруулж ирэх боломж бол зөндөө л байлаа. Тэгэхээр ингэж удаан ажиллах бол сонин байна.

Тэр Сангийн яамнаас болохоор 258,4 тэрбумын ТЭЗҮ-г барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан энэ тэр гээд ярьчих шиг боллоо. Тэгэнгүүт түүнийг чинь болохоор 40 гаруй нь л нийслэл дээр байгаад байгаа юм байна шүү дээ. Тэгээд нөгөө бусад тэр ТЭЗҮ-үүдийн үйл явц ер нь юу болж байгаа вэ. Энэ хөгжлийн төлөвлөгөөнд багтсан, ялангуяа нөгөө томоохон төслүүдийн ТЭЗҮ-үүд ер нь ямар шатдаа яваа вэ. Хэдэн төсөл нь яг ТЭЗҮ-тэй байгаа вэ гэдэг дээр мэдээлэл авмаар байна. Сангийн яамнаас. Бичгээр авъя тэгэх үү.

Тэгээд Амарсайхан сайдаас болохлоор би нөгөө 70 тэрбумын ТЭЗҮ-ийн төсвийг чинь асуусан юм. 2024 оны төсвийн тодотголтой холбоотой. Тэрүүгээр юу хийгдэж байгаа вэ.

Р.Батболд: Амарсайхан сайдын микрофоныг өгье.

С.Амарсайхан: Жаргалан гишүүний асуулт. Энэ 14 мега төслийн болон бусад төсөл хөтөлбөрийн ТЭЗҮ-үүдээр ялангуяа энэ төслийг түргэвчлүүлэх эрчимтэй үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэл дээр ажлын хэсгүүд байгуулагдаад ажиллаад явж байгаа. Одоогийн байдлаар 2 ажлын хэсэг байна. Дээрээс нь энэ Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн дээр бүсийн хөгжлийг эрчимжүүлэхтэй холбоотой гол ажлууд дээр төсөв, зураг төслүүд тавигдсан. Энэ зураг төслүүдийг тавихдаа үндсэндээ бүсүүдээс сонгогдсон гишүүдээс болон салбарын яамдаас авсан санал дээр үндэслээд дэд бүтцүүдийн төсөл хөтөлбөр, тэр дундаа яг энэ бүсчилсэн хөгжлийг сум, аймагт хэрэгжүүлэхтэй холбоотой үндсэн дэд бүтцүүдийг тавихад 1 дүгээрт.

2 дугаарт энэ бүсүүдийн эдийн засгийн чиг үүргийг тодорхойлохтой холбоотой ТЭЗҮ-үүдийг хийгээд, 3 дугаар .../минут дуусав/

Р.Батболд: Гүйцээж хариулъя.

С.Амарсайхан: 3 дугаарт энэ 21 аймгийн 330 сумын төвүүдэд, ялангуяа 91 төвийг байгуулахад эдийн засгийн тусгай бүс, үйлдвэрлэл технологийн паркууд, аялал жуулчлалын төвүүд гээд ийм төвүүдийн эдийн засгийн үндэслэлийг хийхэд энэ төсөл хөтөлбөрүүд төсөв хөрөнгүүд тавигдаад, төрийн худалдан авах ажиллагааны газар дээр сонгон шалгаруулалт нь хийгдээд явж байгаа. Одоогийн байдлаар төсөл сонгон шалгаруулалтууд бас үргэлжилж байгаа учраас энэ төсвийн хууль, төсвийн хэмнэлтийн тухай хуультай уялдуулан цаг хугацаанд нь

төсөл сонгон шалгаруулалтаа хийж, зураг төслийнхөө ажлуудыг дуусгахаар Үндэсний хүрээлэнгээс хяналт тавьж ажиллаж байна.

Р.Батболд: Хариулт хангалтгүй гэж Жаргалан гишүүн нэмэлт тодруулга. Жаргалан гишүүний микрофон өгье.

Б.Жаргалан: Энэ хөгжлийн төлөвлөгөө дээр маш олон төслүүд ерөөсөө огт санхүүжилтийн үнийн дүн байхгүй байдлаар орж ирчхээд байгаа байхгүй юу. Тэгээд би энэ ТЭЗҮ асуугаад байдаг нь бас тийм учиртай. Уг нь бол 2024 оны төсвийн тодотгол дээр чинь бид нар ингээд урам зоригтойгоор маш олон том ажлуудыг хийнэ. Тийм ч учраас бичиг баримтууд дээрээ мөнгө тавья гээд тавьчихсан байж байгаа. Гэтэл тэр бичиг баримтуудын явц ямар байгаа талаар бол бидэнд ерөөсөө мэдээлэл байхгүй байгаад байна. Тэгээд энэ мега төслүүдэд орсон зарим 1 төслүүд ч гэсэндээ ямар ч үнийн дүнгүй, санхүүжилтийн эх үүсвэр нь ч тодорхойгүй ийм байдлуудаар хөгжлийн төлөвлөгөөнд ороод ирчихсэн байж байгаа байхгүй юу. Тэгэхээр өөрөөр хэлбэл бид нар бол ерөөсөө ямар ч тийм төлөвлөлт бас хийж чадахгүй байна л гэсэн үг. Тэгэхээр энэ завшааныг ашиглаад хэдүүлээ яг үнэндээ яг аль аль төслүүдээ явуулах юм бэ гэдгээ маш тодорхой ярьчихмаар байгаад байгаа юм. Тэгээд тэр хөрөнгө оруулалтын орон зайнууд нь хаана байгаа юм, алийг нь концессоор, алийг нь улсын төсвөөр, алийг нь гадаадын зээл тусламжаар, гадаадын хөрөнгө оруулалт татах бодитой төслүүд байгаа юм уу энэ тэр гэдгийг чинь ярихгүй бол ерөөсөө энэ эдийн засгийн асуудлаа томоор нь харж чадахгүй байгаад байна шүү дээ.

Р.Батболд: Жаргалан гишүүн санал хэллээ. Ер нь нийслэл, Сангийн яам 2 энэ ТЭЗҮ-тэй холбоотой асуудлаараа, бичгээр бүр ингээд сайхан тайлан гаргаад хүргүүлэх хэрэгтэй байх. Тэгэхгүй бол бид нар яг үнэндээ Их Хурлын гишүүд ч гэсэн ямар ч ойлголтгүй, одоо үйл ажиллагаа нь яаж явж байгаа нь ч ойлгогдохгүй ийм байдалтай байгаад байгаа. Амарсайхан сайдын микрофон өгье.

С.Амарсайхан: Жаргалан гишүүний хэлж байгаа бас зөв зөв. Бид нар бас гүйцэтгэл өөрөө маш чухал. Ер нь гүйцэтгэл дээр хяналт тавих асуудал өөрөө сул байдгаас шалтгаалаад төсөл хөтөлбөр удааширсан, хөрөнгө оруулалт нэмэгдэх, төсвийн хөрөнгийн үр ашиг алдагдах, алдагдалд орох гээд маш олон асуудлууд бий. Тэрний ганцхан жишээ гэхэд Солонгосын санхүүжилтээр хэрэгжиж байгаа энэ аймгуудын ДЦС байна. Үндсэндээ үйл ажиллагаа нь зогсчихсон. Энэ бол бас салбарын яамнаас тавьж байгаа хяналт, зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа зөвлөх компаниудын хариуцлагатай бас холбоотой асуудал. Тухайн цаг үед нь хянаад шалгаад болж байгаа бол болж байгаа, болохгүй бол ингэнэ, тэгнэ гэдэг хяналтаа тавиад, үр дүнг нь тооцох асуудал дээр ер нь бол төрийн байгууллагууд анхаарах ёстой. 1 дүгээрт.

2 дугаарт энэ мега төслүүд жишээ нь Гашуунсухайтын томоохон төмөр замын холболтыг хийж байгаа энэ төслийн төсөл хөрөнгө хөрөнгө оруулалт бол тодорхой байгаа. Их Хурлаар орж хэлэлцэгдсэн. Эрдэнэбүрэнгийн УЦС-ынх тодорхой бий. Нефтийн үйлдвэрийн санхүүжилт нэмэгдэж, дахиж үргэлжилж байгаа. Их Хурлаар хэлэлцэгдсэн бас тодорхой бий гэх мэтээр тодорхой зураг төсөлтэй төсөв хөрөнгөтэй ийм ажлууд явж байгаа. Гэхдээ энэ дунд төсөв, хөрөнгө нь тодорхой болоогүй, цаашаа судалгаа тооцоог нь нарийвчилж гаргаж, эдийн засгийн өгөөж талаас нь юм уу, эсвэл нийгмийн өгөөж талаас нь тодорхойлж, ялгаж салгаад зайлшгүй хэрэгжүүлэх ёстой төсөл дээр нийгмийн ач холбогдол нь энэ, эсвэл

эдийн засгийн өгөөж нь энэ гэдгийг бас илүү мэдээллээр хангах ёстой. Үүнтэй санал нэг байгаа. Хамгийн сүүлд хэлэхэд бүсчилсэн хөгжлийн шугамаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн явц бол маш тодорхой байгаа. Зарлагдсан зарим нь зураг төсөл нь хийгдээд явж байгаа ажлууд дээр нарийн гүйцэтгэлийн мэдээллийг бас албан бичгээр хүргүүлье гэж бодож байна.

Р.Батболд: Тийм гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Батнайрамдал гишүүнээр тасаллаа. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн үг хэлье.

Л.Соронзонболд: Би түрүүн нэг ярьсан макро тогтвортой орчны талаар бас тодорхой зорилтууд урт хугацаандаа тавиад, тэрийгээ бас энэ хөгжлийн жилийн төлөвлөгөөндөө хянаад явах тухай яриад байгаа юм. Энэ юуг хэлээд байна вэ гэхээр өнөөдөр манай улсын эдийн засгийн бүтэц маань уул уурхайн салбараасаа хамааралтай байна. Бид нар үүнээс салъя гээд байгаа. Гэхдээ энэ маань 5 жилийн хугацаанд гэхэд бид нар уул уурхайн бус салбар нь хэдэн хувь болох ёстой юм. Эрчим хүчний хувьд бид нар хэдэн хувиа өөрсдөө бие дааж үйлдвэрлэдэг болох ёстой юм. Хөдөө аж ахуйн салбар маань ямар хэмжээний экспорт хийдэг болох юм бэ гэдэг ийм зорилтууд урт хугацаатай тавих ёстой гэдэг үүднээс нь би яриад байгаа юм.

Тийм учраас энэ талаар бол Эдийн засаг, хөгжлийн яам маань анхаарч ер нь бол ажиллах ёстой. Энэ зээлийн хүүг бууруулах тухай ярингуут, эргээд макро орчны асуудал үүсээд гадаад хөрөнгө оруулагчдыг татъя. Гадаад валютын нөөцөө нэмэгдүүлье гээд явсаар байгаад уул уурхайн салбараа дагаад, мөчлөгөө дагаад эдийн засаг маань унаад байдаг. Энэ байдлаас бид нар яаж гарах ёстой юм бэ гээд. Энд бид нарт ийм оновчтой эдийн засгийн бүтэц маань ойрын 5 жилдээ харахад ийм бүтэц байна. Тэгэхээр энэ бүтэц рүүгээ бид нар дөхөхийн тулд жил бүр ийм ажил хийх ёстой гээд ингээд хөгжлийн төлөвлөгөө маань хоорондоо уялдах ёстой гэж харж байгаа. Тийм учраас би энэ асуудлыг ярьж байгаа юм.

Р.Батболд: Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн үг хэлье.

М.Бадамсүрэн: Асуулттайгаа уялдуулаад энэ хөгжлийн төлөвлөгөөнд тусгах саналаа хэлчихье. Хэлэлцүүлгээр орж ирэхэд зарчмын зөрүүтэй санал гаргаж болно. Гэхдээ Шадар сайдын хувьд бас бүсчилсэн хөгжлийн асуудлыг хариуцсан учраас анхаараад бас тусгаж өгөх талаар тодорхой санал хэлье.

1 дүгээрт нь энэ хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр зөвхөн байр нэгтгэхээс гадна тоног төхөөрөмж, тэгээд энэ төрийн байгууллагуудын байрыг шилжүүлэх, түрээсгүйгээр хүүхэд сургалтын төвүүд ажиллуулах, багш нарыг бас нэмэлт орлоготой болгох. Тэгээд хөдөө орон нутгийн хүүхдүүдийг бас секц дугуйланд хамрагдаж, өөрийгөө хөгжүүлэх боломжийг олгох чиглэлээр энэ дээр тодорхой бодлогын арга хэмжээ буюу энэ дээр санхүүжилт хэрэгтэй байгаа юм. Бид нар материаллаг байшин барилга, цементээр яаж энэ хөгжлөө хэмжээд яваад байх юм бэ. Тийм учраас энэ дээр тодорхой хөрөнгө төсөв тавьж өгөөч ээ. Үнийн дүнг нь бас тооцоолоод.

2-т нь эдийн засгийн салбар дээр энэ хугацаа урттай, хүү багатай, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг хамгийн багадаа 10-20 дахин нэмэгдүүлэх

хэрэгтэй. Энийг тодорхой нэр зааж тусгаж өгөөч. Тэгэхгүй бол тунхгийн чанартай яваад байна. Яг үнэндээ ингээд дэлхийн улс орнуудад жижиг дунд бизнес эрхэлж байгаа тэр эдийн засаг ДНБ-д хэмжээ нь хамгийн багадаа 40-80 хувь хүртэл байгаа байхгүй юу. Монголд хэд гэж бодож байна. 5.5 хувь. Тэгэхээр энэ яг тийм эдийн засгийн хямралд, гадаад, дотоод нөхцөл байдалд хамгийн бага өртдөг авч явдаг салбар чинь хувийн хэвшил шүү дээ. Одоо эдийн засаг хүнд байна гээд байдаг. Яг үнэндээ энийг чинь авч явж байгаа чинь хувийн хэвшил, жижиг бизнесүүд байхгүй юу. Тэгэхээр энийг ингэж хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг гол нь урт хугацаатай 10-20 дахин нэмэгдүүлнэ гэж оруулж өгөөч ээ.

Дараагийнх нь бол төрөөс геологи хайгуулын ажлыг хийх улсын төсвийн хөрөнгийг 5 дахин нэмэгдүүлэх ёстой. Тэгээд бид нар өөрөө ийм зүйл байна. Энэ дээрээ хөрөнгө оруулъя гээд өрсөлдүүлж, Монголд ашигтай хэлбэрээр хийхгүй бол энэ байдлаараа явах юм бол тэр компани чинь хайгуул хийсэн давуу байдлаараа л энэ лицензийг чинь ашиглалтын болгоод яваад байгаа байхгүй юу. Энийг ингэж оруулж өгөөч. Орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр ялангуяа бүсийн хөгжлийг дэмжих чиглэлээр энэ бүс орон нутгийн хөгжлийг төсвийн хувьд дэмжих бие даалгах бодлогын хүрээнд АМНАТ, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30-аас доошгүй хувийг энэ олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа бүс, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн санд хуваарилах энэ эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх хэрэгтэй байгаа юм. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг Засгийн газар өргөн барьсан. Энэ дээр бол мэдээж гишүүд ийм саналтай Сангийн яам, Уул уурхайн яам бүгдээрээ л энэ дээр бол үндсэндээ үнэнд гүйцэгдсэн гэсэн үг. Ингэхгүй бол ер нь уул уурхайн салбар явахгүй юм байна гэдгийг. Яагаад гэвэл нүдэн дээр нь баялаг гараад байдаг. Тэр орон нутаг чинь хөгжихгүй байгаад байхаар яагаад ч энийг дэмжихгүй шүү дээ. Тэгээд суурь гогцоо асуудал нь эндээ байгаад байгаа юм. Энийг тусгаж өгөөч ээ.

Дараа нь энэ бүсчилсэн бодлогыг дэмжиж, зөвхөн улсын төсвөөс хэрэгжиж байгаа ажлыг хүлээхгүйгээр энэ АМНАТ-ийн төлбөрөөр тодорхой хөрөнгө орон нутагт хуваарилагдаад ирэхээр энэ мөнгийг зөв зүйлд яаж зарцуулах вэ гэдэг асуудал дахиад урган гарна. Одоогийн байдлаар юу гэж харж байна гэхээр ингээд орон нутагт мөнгө өгчихөөр энд үр дүнгүүд зарцуулж магадгүй гэсэн ийм нэг болгоомжлол байгаад байх шиг байх юм. Тэгвэл энэ улсын төсвөөс хэрэгжүүлж байгаа бүсийн чанартай томоохон зүйлүүдийг аймаг, сумын төсөвтэй хамтарч хэрэгжүүлдэг энэ механизмыг бүрдүүлэх хэрэгтэй байгаа.

Би өмнөх төсөв дээр бол бас саналаа хэлж байсан. Тэгээд тэр дэмжигдээгүй л дээ. Юу вэ гэхээр төрийн албан хаагчийн орон сууц гээд 90 гаруй орон сууц улсын хэмжээнд барьж байгаа юм уу даа. Энийг аймаг сумын төсөвтэй хамтраад байвал $3 \times 9 = 27$ гээд 270 буюу 300 сум чинь бүгдээрээ төрийн албан хаагчдын орон сууцтай болох боломж байсан байхгүй юу энэ 3 жилд. Гэтэл энийг зүгээр л улсын төсөв, аймаг, сумын төсөв хамтарч болохгүй гэдэг, дандаа болохгүй гэдэг талаас нь хөгжил рүү тэмүүлэхгүй Сангийн яам бол болохгүй гэдэг талаас нь хаагаад, Эдийн засгийн яам нь илүү хөгжүүлэх талаараа явах ёстой байхгүй юу. Тэгж байж энэ 2 чинь балансална. 1 нь хөгжил рүү тэмүүлдэг бас тодорхой зардал гаргадаг, 1 нь тэрийг ариг гамтай зарцуулан хянадаг тэгж байж энэ тэнцэл дээр чинь энэ хөгжлийн асуудал явагдана шүү дээ. Ингэхгүй хааснаас болоод явахгүй байгаа энийг бүрдүүлчих юм.../минут дуусав/

Р.Батболд: Отгоншарын Батнайрамдал гишүүн үг хэлье. Мөнхсоёл гишүүнийг үг хэлэх нэр дээр нэмээрэй.

О.Батнайрамдал: Энэ нэг чухал асуудал байгаа юм. Энэ 2026 оны хөгжлийн төлөвлөгөө дээр 17,5 их наяд төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон байгаа. Энэ 17,5 их наядын 42,9 хувь нь бараг хагас нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр гадаадын зээл, гадаадын хөрөнгө оруулалтаар гэж байгаа юм. Тэгэхээр хагас нь ерөөсөө энэ 3 зүйлээс хамаарна. Тэгэхээр энэ 3 дээрээ жишээлбэл тэр төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн шинэчлэл, гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчлэл. Энэ 2 хууль нэлээн реформын шинж чанартай шинэчлэгдэхгүйгээр бид нар нөгөө 17,5 их наядынхаа хагасыг нь авах тэр чинь том асуудал үүснэ шүү. Тэгэхээр тэр 2 хуулиа яаралтай өргөн барьж, өргөн барихдаа нэлээн реформын шинж чанартай өөрчлөлтүүд заавал хийж байж энэ 17,5 их наядын 43 хувь нь 1 ёсондоо босно гэсэн үг. 1 дүгээрт.

2 дугаарт буцаад нөгөө төрийн өмчит компанийн бүтээмжийн 30 хувь руу л ормоор байна л даа. 30 хувиар төрийн өмчит компанийн бүтээмжийг сайжруулъя гэж байгаа бол энэ дээр маш том реформын шинж чанартай агуулга ард нь байна гэж шууд ойлгож байна. Юу гэсэн үг вэ гэхээрээ ашиггүй ажиллаж байгаа, эсвэл үнэхээр төрд шаардлагагүй хувийн хэвшилтэй давхцаж байгаа, төрд байснаараа ямар нэгэн давуу тал үүсгэдэггүй тэр бизнесүүдээ бүгдээс нь гарах хэрэгтэй. 30 жилийн хугацаанд бараг хийгдээгүй шахам реформ энэ л үлдчихсэн байгаа. Тэгэхээр энийг хэрвээ зоригтой хийж чадах юм бол 30 хувийн бүтээмж өөрөө дайвраар өөрөө гарч ирэх дагалдах зүйл байхгүй юу. Тэгэхээр төрийн өмчит компаниудыг бол 2 малгай доор гаргасан.

1 нь бол Эрдэнэс Монгол гээд баялгийн сангийн хүрээнд байгалийн баялгийг ашиглаж байгаа төрийн өмчит компаниуд.

Нөгөөдөх нь бол уул уурхайн бус Эрчис Монгол гээд. Тэгэхээр энэ 2 компани дээр нэг ёсондоо менежментийн ч бай, тэгээд портфолио буюу тэр охин компаниудаас төрд шаардлагагүй бизнесүүд нь шууд гарах тэр зоригтой реформуудыг хийж байж нэг ёсондоо 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний Эдийн засгийн эрх чөлөөний реформ гэдэг мундаг үг маань бага ч гэсэн хэрэгжих боломжтой л гэж харж байгаа юм л даа. Тэгэхээр бараг тэр урсгал зардлаасаа илүүтэйгээр бодитой харагдаж байгаа нь бол төрийн өмчит компаниудын томоохон шинэчлэл дээр зоригтой шийдэл гаргах хэрэгтэй.

Ер нь 2026 онд дэлхийн эдийн засгийн геополитиктой холбоотой томоохон эрсдэлүүд гарч байгааг харсан ч гэсэн ер нь 2026 оны дүр зураг бол бодож байснаас илүү жоохон саарал дүр зураг гарах байх. Олон улсын байгууллагууд дэлхийн эдийн засгийн өсөлтийг ч гэсэн тооцоолохдоо ер нь бууралтаа цаашаагаа гаргаж байна. Нэлээн том геополитикийн тооцоолоход хүнд бэрх эрсдэлүүдтэй тулгарах нь ойлгомжтой болж байгаа юм. Гэхдээ энэ нөгөө талаасаа томоохон реформ хийх боломж шүү дээ. Эдийн засаг сайхан үед реформ хийе гэхээр бүгд болоод байгаа болохоор тэрийг гаргаж ирдэггүй. Ажил хэрэг болдоггүй. Гэхдээ хүнд үе нөгөө талаасаа бол маш том реформуудыг шинэчлэлээр нь хийх боломж шүү. Тэгэхээр энэ эдийн засгийн эрх чөлөө гэдгийг би тэгж л ойлгож байна. Эдийн засгийн эрх чөлөө гэдгийг төрийн өмчит компаниуд дээр томоохон шинэчлэл хийх юм байна.

Тэгээд хиймэл оюуныг ашиглах хэрэгтэй. Ашиглах гэж оролдох хэрэгтэй. Ялангуяа төрийн үйлчилгээ дээр илүү сайжруулах хэрэгтэй. Гэхдээ энэ дээр бол маш олон бэлтгэл ажлыг бид нар заавал хангах ёстой шүү. Тэгэхээр хиймэл оюуныг шууд ашиглаад гэнэт ажил хэрэг болчихдог бас зүйл биш. Бусад орны жишгээс маш сайн суралцах ёстой. Тэгээд дээрээс нь төсвийн зардлын реформыг бас зоригтой урсгал зардлаа бууруулах дээр бол хийх хэрэгтэй л гэж хэлмээр байна.

Р.Батболд: Баатаржавын Мөнхсоёл гишүүн үг хэлье.

Б.Мөнхсоёл: Түрүүн асуулт асуухад бас нэлээн гол юмнуудаа хэлчихсэн болохоор зүгээр энэ төлөвлөлт бодлогоо сайжруулахын тулд хэдэн тодорхой бас саналаа хуваалцчихъя. Тэгээд олон юм байж болно. Жишээлээд байгаа гээд түрүүн хэлсэн.

1 дүгээрт нь 2.3 дээр ер нь бол хардаа төсөл, арга хэмжээ дунд зорилт байхаар тийм төсөл, арга хэмжээнүүд цөөнгүй байгааг сайн харах ёстой л гэж хэлмээр байна. Тухайлбал 1 дүгээрт нь 2.3 дээр олон улсад өрсөлдөхүйц, чанартай, тэгш хүртээмжтэй ерөнхий боловсролыг хөгжүүлсэн байна. Үр дүнгээс нь олон улсад өрсөлдөхүйц гэдгийг хасвал зүгээр гэсэн ийм саналтай байгаа. Олон улсад өрсөлдөхийн тулд яг юуг, яаж хийж байж тэрийг биелүүлэх вэ гэдгээ бодох ёстой болохоос биш ерөнхий зорилт тавьчихсан. Туссан төсөл арга хэмжээнүүд нь ихэвчлэн дотоод төсөл арга хэмжээнүүд байгаад байна. Тэгээд ер нь бол олон улсад өрсөлдөхүйц гэх нь бас зайлшгүй шаардлагатай юу, үгүй юу гэж бодож байгаа юм. Яагаад вэ гэхээр ерөнхий боловсрол шүү дээ. Энэ Боловсролын сайдад бас хамаатай байх л даа. Батжаргал Төрийн нарийн бичгийн дарга байна.

Дараагийнх нь 2.12.1.1 дээр үндэсний баялгийн сангаар дамжуулж хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэн бүрд хуримтлалын нэрийн дансанд хөрөнгө хуримтлуулах гэх мэт ийм өдөр тутмын хийх ёстой ажлаа хийж байгаа үйл ажиллагаануудаа энэ төлөвлөгөөндөө тусгах хэрэгтэй байна уу. Энэ чинь арай макро түвшний юм бай.

Дараагийн 1 санал. Тухайлбал, 2.13.2.1 дээр хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлэх гэхихсэн байгаа юм. Энэ дээр төсөв санхүүжилтийг нягт нямбай, ул суурьтай тооцох, төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тооцож тусгаагүй байгаад байна.

Дараагийн бас 1 санал. 3.3.1.2 дээр ноос, ноолуур, арьс ширний бэлтгэл үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх гэхихсэн ийм мэтийн арга хэмжээ, төслийг тусгамааргүй байгаа байхгүй юу. Энэ нь өөрөө бас зорилт шиг сонсогдоод байгаа биз. Тэгэх, ингэх гээд. Ер нь бол анхнаасаа танилцуулгыг ч гэсэн сонсоход нөгөө бид нар олон жил шүүмжлээд байсан Үндэсний хөгжлийн бодлого гээд аль 2000-аад оны эхээр гарахад бид нар дандаа хүслийн жагсаалт болчихоод байна. Санхүүгийн эх үүсвэргүй, хүсэл мөрөөдлөө биччихдэг тийм баймааргүй, хэрэгжихүйц, бодит, хэмжигдэхүйц баймаар байна гээд олон жил ярьсан. Энэ алдаа засагдахгүй хуримтлагдаад байгаа болохоор тодорхой жишээгээр хэлчихье. Батхүү Төрийн нарийн бичгийн дарга аа.

Р.Батболд: Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Ажлын хэсгийнхнээсээ үзэхэд энэ гишүүдээс гаргаж байгаа асуултууд, тэгээд хэлж байгаа үгэнд нь

дурдагдаж байгаа санаануудыг ажилдаа авч хэрэгжүүлэхийг анхаарч ажиллахыг хүсье.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны гаргах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал уншиж танилцуулна.

13.41 цаг.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэнэ.

Энэ ирцэд орсон гишүүд маань танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудал 3. Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж эхэлье.

Тайлангийн танилцуулгыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц хийнэ. Ажлын хэсгийн 4 номерын микрофоныг нээнэ үү.

Т.Жамбаажамц: Эдийн засгийн байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

2024 оны Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны тайланг танилцуулъя.

2024 онд Санхүүгийн зохицуулах хороо ажлын албаны дараах бүтэцтэйгээр ажилласан. 9 газар, 5 хэлтэс, 5 албатайгаар ажилласан. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасан санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах энэ хүрээндээ ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хороо нийтдээ 29 бие даасан хуулийн хэрэгжилтийг хангаж ажилладаг. Энэ хуулиуд нь бол хөрөнгийн зах зээл дээр 6 нэр бүхий хууль, даатгал дээр 5, уул уурхайн бирж дээр 1, мөнгөн зээл дээр 1, банк, санхүүгийн салбарт 3. Ингээд нийтдээ 29 хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, санхүүгийн зах зээлийг хянаж, зохицуулж ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр бол Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаан байдаг. Хуралдаанаар бол өнгөрсөн 2024 онд нийтдээ 23 удаагийн хуралдаанаар 657 тогтоол шийдвэр бол гаргаж ажилласан байна. Санхүүгийн үйлчилгээг үзүүлж ажиллаж байна. Санхүүгийн зохицуулах хороо анх 2006 онд байгуулагдсан. Байгуулагдахдаа үндсэндээ 4 үндсэн уламжлалт салбартайгаар анх бол байгуулагдсан. Хөрөнгийн зах зээл, даатгал, тэгээд бичил санхүүгийн салбар буюу банк санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо гэсэн.

2020 оноос хойш мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог Монгол Улсад хэрэгжүүлэх чиглэлээр бол хорооны үйл ажиллагааны чиглэл бол сүүлийн 4, 5 жилийн хугацаанд асар хурдацтай, хяналт зохицуулалтын хүрээ бол нэмэгдсэн. 2020 онд 2 бие даасан салбар бол хяналт зохицуулалтад ирсэн. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, үнэт металл. 2021 онд бол банкны реформын хүрээнд системийн нөлөө бүхий банкнууд бол олон нийтийн компани болсон. Сендбоксын зохицуулалт ирсэн. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хууль батлагдсанаар 2022 онд Санхүүгийн зохицуулах хорооны хяналт зохицуулалтад ирсэн. Тэгээд 2023 онд бол мөнгөн зээлийн үйл ажиллагаа, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа гэсэн ийм үндсэн бие даасан 11 салбарын үйл ажиллагааг бол хянаж зохицуулж ажиллаж байна.

Зохицуулалттай этгээдийн тоо бол үндсэндээ 6930 орчим бий. Үүнээс бол хуулийн этгээд, иргэдийн үйл ажиллагаа бол 4426, даатгалын төлөөлөгч бол үүн дээр бас нэмэгддэг. Даатгалын бүтээгдэхүүнийг орон нутаг болон борлуулдаг ийм үндсэн суваг байгаа. Тэгээд хөрөнгийн зах зээл дээр 618 зохицуулалттай этгээд байна. Даатгал дээр 347, мөнгөн зээл дээр бол 479, банк санхүүгийн байгууллагад 573 зэрэг ийм зохицуулалтын салбарт бол үйл ажиллагаа явуулж байна.

Зохицуулалтын ерөнхийдөө салбарын үзүүлэлтийг бол сүүлийн жилүүдэд хорооны зохицуулалтын салбарын ДНБ-д эзлэх хувь хэмжээ бол тасралтгүй өссөөр ирсэн байгаа. Өнгөрсөн 2024 онд бол нийт зохицуулалтын хөрөнгийн зах зээл, даатгал, банк бус бичил санхүүгийн салбар нийлээд ДНБ-ий 26,5 хувийг эзэлж байгаа. Үүн дотроо задлаад үзвэл хөрөнгийн зах зээлийн үнэлгээ бол 16,3, банк бус санхүүгийн салбар бол 8,9 хувь, даатгалын салбар бол 0,8, хадгаламж, зээлийн хоршооны салбар бол 0,5 гээд ийм хүрээнд бол ажиллаж явж байгаа. Тэгэхээр энэ санхүүгийн зах зээл зохицуулалттай салбар бол нэлээн өсөлттэй ингэж явж ирсэн.

Би салбар салбараар нь товчхон мэдээллүүдийг гишүүддээ бас товч өгчихье.

Хөрөнгийн зах зээл дээр өнгөрсөн онд бол хөрөнгийн зах зээлийн нийт зах зээлийн үнэлгээ бол 13 их наяд орчим боллоо. Энэ нь бол 2023 оноосоо бол 11,8 хувиар өссөн. Нийт нээлттэй хөрөнгийн бирж дээр 1,5 их наяд төгрөгийн санхүүгийн хэрэгслийн арилжаа явагдлаа. Үүнийг бол хэлбэрүүдээр нь ангилбал 4 төрлийн нийт үнэт цаас арилжаалагдаж байгаа.

1 дүгээрт нь бол компанийн бонд 913 тэрбум, Хувьцаа 358 тэрбум, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гэсэн ийм шинэ төрлийн бүтээгдэхүүн бий 206 тэрбум, Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх 100 тэрбумын ийм арилжаанууд бол хийгдсэн. Энэ дээр бас онцлоод 1 зүйл хэлэхэд сүүлийн жилүүдэд компанийн бондын арилжаа нийт хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж байгаа бүтээгдэхүүний 50 гаруй компанийн бондын арилжаа бол явагдаж байгаа. Тэгэхээр компанийн бонд гэдэг бүтээгдэхүүн хөрөнгийн зах зээл дээр бол их чухал бүтээгдэхүүн болж байна гэж бол харж байгаа юм.

2021 оноос Монгол Улсад бол биржийн бус зах зээл буюу хөрөнгийн зах зээл дээр 2 үнэт цаасны арилжаа эрхлэх үндсэн ийм платформ 2 дахь платформ бол ажиллаж эхэлсэн. Өөрөөр хэлбэл хаалттай, биржийн бус зөвхөн мэргэжлийнхэн оролцдог компаниудын бондын бүтээгдэхүүн энэ дээр гардаг ийм онцлогтой зах зээл бол арилжаалагдсан. 2021 оноос хойш бол нийтдээ 4 их наяд орчим

төгрөгийн санхүүжилтийг 160 гаруй компани байна, 300 удаагийн ийм бүтээгдэхүүн гаргаж, мэргэжлийн хөрөнгө оруулагчдаас татаж санхүүжилтээ бол хийгээд явсан байна. Өнгөрсөн 2024 оны тухайд бол нийтдээ 95 компани. Энд бол дунд хэлбэрийн компаниуд бий. Компани 131 бүтээгдэхүүн бонд биржийн бус зах зээл дээр гаргаж, 1,6 их наяд төгрөгийн арилжаа хийгдсэн. Мөн үүн дээр нэмээд бас долларын бондууд энэ дээр арилжаалагддаг 72 сая долларын бонд бас арилжаалагдсан байна. Тэгэхээр манай хөрөнгийн зах зээл дээр бас ийм хөрөнгийн биржтэйгээ өрсөлдөхүйц ийм арилжаа эрхлэх бүтэц бол Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо дээр зохион байгуулагдаад явж байгаа. Санхүүгийн зохицуулах хороо зохицуулалтынх нь орчныг бүрдүүлээд ажиллаж байна.

Хөрөнгийн зах зээл дээр нэмээд зүйлүүд хэлэхэд бол топ 20 индекс бол сүүлийн жилүүдэд нэлээдгүй өсөж байгаа. Шинээр нийтдээ Монгол Улсын үнэт цаасны төвлөрсөн хадгаламж дээр бол 2 сая 598 мянган иргэний хувьцааны үнэт цаасны данстай байгаа. Өнгөрсөн онд шинээр бол нийтдээ 204 орчим мянган данс бол нээгдсэн байна. Нийт арилжаанд оролцогчдыг хэлбэрээр нь үзвэл өнгөрсөн 2024 оны хувиар нийт дотоодын арилжааны 66,3 орчим хувь нь дотоодын аж ахуйн нэгж буюу байгууллагын хөрөнгө оруулагч нар маань энэ хөрөнгийн зах зээл дээр ордог болсон. Тэгэхээр энэ бол нийт үндсэндээ 2/3 нь институцийн буюу байгууллагын ийм хөрөнгө оруулагч нар хөрөнгийн зах зээл дээр бол ажиллаж байна.

Даатгалын салбар байгаа. Монгол Улс арилжааны даатгалын зохицуулалт бол Санхүүгийн зохицуулах хорооны бас нэг Үндсэн хууль зохицуулалтын салбар. Нийтдээ өнөөдөр 20 даатгалын компани үйл ажиллагаа явуулж байна. Монгол улсад. Ердийн даатгалын 17, урт хугацааны даатгалын 2, давхар даатгал үндэсний давхар даатгалын 1 компани үйл ажиллагаа явуулж байгаа.

Даатгалын салбар дээр бол бас чухал оролцогч нар байдаг. Даатгалын зуучлагч буюу брокерууд өнөөдөр нийтдээ арилжааны банкнуудаас эхлээд даатгалын дагнасан зуучлагч брокерын компаниуд нийтдээ 60 брокерын компани үйл ажиллагаа явуулж байгаа. Даатгалын хохирлын үнэлэгч бол 29 компани хохирлын үнэлгээний үйл ажиллагаа явуулж, мэргэжлийн зуучлалын үйл ажиллагаа энэ даатгалын салбар дээр бол явж байна. Нийт хөрөнгийн хэмжээ сүүлийн жилүүдэд бол нэлээдгүй өсөлттэй байгаа. 2023-2024 онд даатгалын салбарын нийт актив бол 20 орчим хувиар өссөн байж байгаа. Мэдээж бол манайд энэ даатгалын гүнзгийрэлт гээд даатгалын салбарын хөгжлийг гол харуулдаг ийм үзүүлэлт олон улсад байдаг. Энэ гүнзгийрэлт бол ерөнхийдөө энэ хөгжиж байгаа орнуудын дундаж түвшин бол 3,1 хувьтай байхад, манай даатгалын салбарын түвшин 0,64 хувьтай байгаад байгаа. Тэгээд амьдралын даатгал, урт хугацааны даатгал, ердийн даатгал 2-ын харьцаа бол манайд 99/1 гэсэн харьцаатай. Энийг бол цаашид тэр 55/45 буюу олон улсад байдаг ердийн даатгалын компани, урт хугацааны даатгалын компани зэрэгцэж ажилладаг тэр орчин нөхцөл бол зайлшгүй хэрэгцээтэй байж байгаа. Нийтдээ бол даатгалын салбар бол томоохон хөрөнгө оруулагч байдаг. Нийтдээ 406 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг бол энэ салбар дээр байсан. Сүүлийн жилүүдэд бол хөрөнгийн зах зээлээр дамжиж, даатгалын нөөц сангууд тодорхой санхүүгийн хэрэгсэлд, компаниудад байрших хөрөнгө оруулалт хэлбэрээр байрших ийм хандлага бол нэлээдгүй нэмэгдэж байна.

Банк бус санхүүгийн салбар бий. Энэ бол үндсэндээ бичил санхүүгийн байгууллагууд. Нийтдээ 573 ББСБ Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа. Эдгээрийн бол 69 нь финтекийн зээлдэгч байгаа. Финтек буюу цахим аппликэйшнээр үйл ажиллагаа явуулдаг. Энэ салбарын 1 онцлог нь бол богино хугацааны, бага дүнтэй ийм зээлүүд байдаг. 1 хүнд ноогдох дундаж зээлийн хэмжээ бол 2 сая 500 мянган төгрөгийн дундаж зээлийн хэмжээ бий. Финтек буюу цахим хэлбэрээр зээл авч байгаа зээлийн дундаж хэмжээ бол 771 мянган төгрөгийн ийм үзүүлэлттэй байгаа. Нийт зээлийн өрийн үлдэгдэл бол 2024 оны байдлаар бол 5,7 их наядын зээлийн үлдэгдэлтэй. Энэ нь бол банкны салбарын зээлтэй харьцуулахад 13 орчим хувьтай байгаа юм. Нийт хөрөнгийн хэмжээ бол сүүлийн жилүүдэд бол нэлээдгүй өсөж байгаа. Энэ дээр Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс энэ ББСБ-ын эрсдэлээ даах чадвар, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх чиглэлээр бодлогын үе шаттай олон арга хэмжээнүүд авч хэрэгжүүлээд явж байгаа.

Хадгаламж, зээлийн хоршоо гээд бичил санхүүгийн яг орон нутагт гэдэг юм уу иргэдэд хүрч үйлчилдэг ийм бичил санхүүгийн институт бол Монгол Улсад 2011 оноос хойш хуультай үйл ажиллагаа явуулж байна. Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын ийм салбар бий. Нийтдээ өнөөдөр 178 хадгаламж зээлийн хоршоо Монгол улсад үйл ажиллагаа явуулж байна. Хадгаламж зээлийн хоршооны онцлог бол зөвхөн гишүүддээ үйлчилдэг. Гишүүддээ санхүүгийн зээл, хадгаламжийн санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг ийм онцлогтой бичил санхүүгийн институт байж байгаа. Нийтдээ 75252 гишүүнтэй. Хоршоологчдын өмчийн дүн бол нэлээдгүй өсөж байгаа. Зээлийн дүн бол нийт зээлийн өр үлдэгдэл 2024 оны байдлаар Хадгаламж, зээлийн хоршоо дээр 258,7 тэрбумын, хадгаламж нь бол 248,6 тэрбумын хадгаламжтай ийм онцлогтой салбар байгаа. Зүгээр нийт 178 Хадгаламж, зээлийн хоршооны 50 орчим хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулдаг. Өөрөөр хэлбэл орон нутагт яг санхүүгийн үйлчилгээг хүргэдэг ийм бичил санхүүгийн институт гэж үзэж ойлгож болно.

Нөгөө талаасаа нийтдээ энэ салбарын нийт активын 90 хувийг 1 тэрбумаас дээш хөрөнгөтэй 39 Хадгаламж, зээлийн хоршоо бүрдүүлж байгаа юм. 90 орчим хувийг. Тэгээд энэ 39 Хадгаламж, зээлийн хоршооны 20 орчим нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа юм. Яг орон нутаг аймаг дээр, сум дээр бичил санхүүгийн зээл, хадгаламж болон бусад санхүүгийн үйлчилгээг үзүүлж явдаг ийм онцлог ийм статустай бичил санхүүгийн институт байж байгаа.

Санхүүгийн зохицуулах хороонд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, тэмцэх тогтолцооны хүрээнд үл хөдлөх эд хөрөнгө, үнэт металлын ийм зохицуулалтын салбар бол нэмэгдсэн. Санхүүгийн зохицуулах хороо илүү мөнгө угаах чиглэлийн үйл ажиллагаанд бол хяналт тавьдаг. Нийтдээ үл хөдлөх хөрөнгө, үнэт металл дээр бол Санхүүгийн зохицуулах хороо бүртгэл хийгээд, тэгээд тайлан мэдээг нь аваад, мэдээлэх, тайлагнах үүргийн хэрэгжилтийг нь бол хангуулаад ингээд ажилладаг байж байгаа.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны салбар байгаа. Мөнгөн зээлийн салбар дээр .../минут дуусав/

Р.Батболд: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон дээр гүйцээж танилцуулгаа дуусгая.

Т.Жамбаажамц: Баярлалаа. Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг 2022 онд Улсын Их Хурлаас баталсан. Тэгээд энэ хуулийн хүрээнд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн ажлыг бол Санхүүгийн зохицуулах хороо, орон нутаг хамтарч хэрэгжүүлж байгаа. Өнөөдрийн байдлаар нийтдээ энэ бүртгэлтэй Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй хуулийн этгээд нь 71, орон нутаг буюу аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар дээр бүртгэлтэй хуулийн этгээд нь 255, иргэн нь 153 ийм бүртгэлтэй иргэн, хуулийн этгээд бол мөнгөн зээлийн үйл ажиллагаа бол явуулж байна. Нийтдээ мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлдэгч нь бол 499408 ийм зээлдэгчтэй. Нийт зээлийн хэмжээ бол 642,4 тэрбумын зээлийн өрийн үлдэгдэлтэй ийм байдалтай мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэл явагдаж байгаа. Санхүүгийн зохицуулах хороо бол хуулиараа ийм онцлогтой салбар. Хоёрдмол ийм зохицуулалттай. Өөрөөр хэлбэл Санхүүгийн зохицуулах хороо 1 хэсгийг нь бүртгэдэг. Томоохон мөнгөн зээлийн үйл ажиллагааг бүртгэдэг. Бусад жижиг дүнтэй, бага дүнгээр өөрийн хөрөнгөтэй болон иргэдийн зээлийн үйл ажиллагаа хийдэг иргэдийг бол орон нутгийн засаг захиргаа бол бүртгээд явж байгаа.

Хөрөнгийн зах зээл дээр 2024 онд онцлох хэд хэдэн ажлууд бид бүхэн хийж хэрэгжүүлсэн байна. Ялангуяа бондын зах зээлийг хөгжүүлэх, дотоодын бондын зах зээл дээр компаниудыг олноор гаргах, санхүүжилтийн хямд, урт хугацаатай эх үүсвэр татах чиглэлээр бол нэлээн томоохон бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Ялангуяа энэ топ 100 аж ахуйн нэгжүүд дээр бол тусгай ийм бондын хөтөлбөрийг бол хэрэгжүүлээд явж байгаа. Кастодианы үйл ажиллагааны зохицуулалтыг нэлээдгүй сайжруулсан. Ялангуяа хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч, хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр бол нэлээдгүй өөрчлөлтүүд хийгдсэн байж байгаа. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зохицуулалтуудыг сайжруулснаар манайд Хөрөнгийн бирж дээр бол хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны суурь ийм бүтээгдэхүүнүүд бол нэлээдгүй гардаг ийм байдалтай болсон.

Дараагийн дугаарт нь Улсын Их Хурлаас 2023 онд Даатгалын тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хуулиудад бол холбогдох өөрчлөлтүүд оруулсан. Энэ хуулийн гол агуулга нь бол даатгалын баталгааг өргөнөөр хэрэглэх, ялангуяа энэ төрийн болон хувийн хэвшлийн худалдан авалтууд, тендерүүд дээр даатгалын баталгаа гаргах ийм эрх зүйн орчныг бол бүрдүүлж өгсөн. Энэ хүрээнд бол Санхүүгийн зохицуулах хороо холбогдох зохицуулалтыг нь журмыг нь баталж, энэ хүрээнд нийтдээ 2024 онд 5 даатгалын компани тендерийн урьдчилгаа төлбөрийн болон гүйцэтгэлийн нийтдээ 22,5 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий даатгалын баталгаа бол гаргасан байж байгаа.

Нөгөө талаас банк бус санхүүгийн байгууллагууд дээр 2024 онд Санхүүгийн зохицуулах хорооноос эрсдэл даах чадварыг нь сайжруулах, өөрийн хөрөнгийн хүрэлцээг нь нэмэгдүүлэх, эздийн өөрийнх нь хөрөнгийг нэмэгдүүлэх чиглэлээр бол нэлээн томоохон бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Өөрөөр хэлбэл өөрийн хөрөнгө буюу хувь нийлүүлсэн хөрөнгө, дүрмийн санг 1 дахин, 2 дахин нэмэгдүүлсэн одоогийн байгаагаар. Тэгэхээр шинэ банк бус санхүүгийн байгууллагууд бол 5 тэрбум, итгэлцлийн үйл ажиллагаа явуулдаг буюу бусдаас эх үүсвэр татдаг банк бус санхүүгийн байгууллагуудаар бол 10 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн буюу хөрөнгөтэй, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, эрсдэл даах чадварыг бол ингэж нэмэгдүүлж ажилласан байж байгаа.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуулиар Санхүүгийн зохицуулах хорооны дэргэд бодлогын зөвлөл ажилладаг. Мөнгөн зээлийн бодлогын зөвлөлөөс бол мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдүүдийн хүүгийн дээд хязгаарыг бол шинэчилж тогтоосон, шинээр тогтоосон. Өөрөөр хэлбэл 4,5 хувиар хүүгийн дээд хязгаарыг бол тогтоогоод, мөрдүүлээд явж байгаа. Хяналт шалгалтын ажлыг бол санхүүгийн зохицуулах хороо салбаруудтай бол мөрдүүлж ажиллаж байна. 4 үндсэн уламжлалт салбарууд дээр бол өөр өөрийн зайны хяналтыг хэрэгжүүлж байгаа. Хөрөнгийн зах зээл дээр бол Айскогийн зарчмуудын хэрэгжүүлэлтүүдийг хангадаг бол даатгал дээр орсо, ББСБ дээр базил, ХЗХ-н дээр бол Камил гэсэн ийм өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгалтыг, хяналтыг тавьж хэрэгжүүлж явдаг. Нийтдээ хяналт шалгалтын чиглэлээр ажлууд бол хэрэгжүүлээд, тухай бүрдээ зайны болон газар дээрх хяналт шалгалтуудыг бол хэрэгжүүлж ажиллаж байна.

Санхүүгийн боловсролын асуудал байгаа. Санхүүгийн боловсролын чиглэлээр бол ер нь Санхүүгийн зохицуулах хороо бас нэлээдгүй ажлууд бол хийсэн. Энэ дээр бол 2 үндсэн чиглэлээр хийж байгаа. Олон нийт буюу бага, дунд, ахлах ангийн сурагчид гэдэг юм уу, олон нийтэд чиглэсэн санхүүгийн боловсролын үйл ажиллагаанууд явуулж байгаа бол мэргэжлийн салбарууддаа ялангуяа даатгал, хөрөнгийн зах зээл, үл хөдлөх хөрөнгө, мөнгө угаах чиглэлээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд гээд ингээд маш олон төрлийн ийм сургалтуудыг салбарын мэргэжлийн холбоодтой нь, холбоодоор нь хамтарч, ингэж хэрэгжүүлээд явдаг.

Нөгөө талаасаа ахлах ангийн сурагчдад зориулсан Level up гээд хөтөлбөрийг бол Улсын Их Хурлын даргын санаачилгаар хэрэгжүүлж явж байгаа. Үүний бол бас гол хэрэгжүүлэгч байгууллагынх нь нэгээр бол Санхүүгийн зохицуулах хороо ажиллаж байна. Нийслэлийн 6 дүүрэг, нэр бүхий 6 аймагт бол нээлтээ хийгээд, үйл ажиллагаа бол ахлах ангийн сурагчдыг санхүүгийн боловсролыг дээшлүүлэх тусгай ийм хөтөлбөр бол хэрэгжээд явж байгаа.

Хамтын ажиллагааны чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороо гадаад хамтын ажиллагааны чиглэл дээр бол нэлээдгүй үйл ажиллагаанууд хэрэгжүүлдэг. Ялангуяа олон улсын санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг, Ай Эс Ко үнэт цаасны хороодын олон улсын байгууллагууд, дэлхийн Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулагчдын зөвлөл, даатгалын зах зээлийн зохицуулагчдын олон улсын холбоо гээд энд бол манайх үндсэн гишүүнээр ажилладаг. Энэ хүрээндээ бол холбогдох бүс нутгийн болон олон улсын тэр байгууллагуудын гишүүнчлэлийнхээ хүрээнд бол үйл ажиллагаанд идэвхтэй хамтарч оролцдог. Ялангуяа санхүүгийн хүртээмжийн олон улсын нийгэмлэгт бол Санхүүгийн зохицуулах хороо бол маш .../минут дуусав/

Р.Батболд: Гишүүд гүйцээж сонсох уу. Эсвэл тараачихсан юм чинь шууд явуулчих уу. Асуулт хариулт дээрээ л гүйцээе. Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны тайлангийн ажлын хэсгийг танилцуулъя.

Т.Жамбаажамц Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Б.Итгэлсүрэн Ажлын албаны дарга, Т.Цэрэнбадрал орон тооны гишүүн бөгөөд дэд дарга, Н.Хүдэрчулуун орон тооны гишүүн бөгөөд дэд дарга, Б.Дөлгөөн Үнэт цаасны газрын дарга, З.Батболд Даатгалын газрын дарга, Ц.Алтантуул Хадгаламж, зээлийн хоршооны газрын дарга, Б.Долгорсүрэн Хяналт шалгалт, зохицуулалтын

газрын дарга, Ж.Мөнх-Оргил Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Б.Батчимэг Сендбоксын албаны дарга, У.Ганчимэг Мөнгө угаахтай тэмцэх албаны дарга, Т.Билэгсайхан Зах зээлийн судалгаа хөгжлийн газрын референт.

Танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгөх үү. Батнайрамдал гишүүнээр тасаллаа. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя. Асуулт үг 2 хамт шүү.

Л.Соронзонболд: Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны тайлантай танилцлаа. Ерөнхийдөө бол Санхүүгийн зохицуулах хороо бол бас хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх тал дээр бол нэлээн бас ажлууд хийсэн гэж дүгнэж байгаа. Гэхдээ цаашдаа гадаад хөрөнгө оруулагчдыг Монголын хөрөнгийн зах зээл рүү татах тал дээр яг ямар бодитой ажлууд хийхээр төлөвлөж байгаа вэ. 2025 онд. Ер нь бол татварын тодорхой хэмжээний ийм дэмжлэг бодлогууд бол гаргасан ажиллаж байгааг бол ойлгож байгаа. Гэхдээ яг бодитой, хэдийгээр ийм татварын ийм урамшуулал байгаа боловч яг ингээд орж ирж байгаа гадаадын хөрөнгө оруулагч бол байхгүй харагдаад байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр ямар дорвитой арга хэмжээ авах гэж байна вэ гэж 1 дүгээр асуулт.

2 дугаарт болохоор бол Санхүүгийн зохицуулах хорооны хариуцаж байгаа санхүүгийн зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний хамрагдах хүрээ бол Улаанбаатар хотод маш сайн байгаад байгаа. Хөдөө, орон нутагт энэ талаар бол маш сул байгаад байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр 2025 онд яг ямар ажил хийх юм бэ. Тийм учраас бол ер нь ажлын төлөвлөгөөгөө Улаанбаатар хот болон орон нутаг гэж салгаж төлөвлөгөө гаргадаг байх нь зөв болов уу гэж харж байгаа юм.

Мөн дээрээс нь бол 2024 онд орон нутгаас хэдэн компани энэ биржийн болон биржийн бус зах зээл дээр бонд гаргав. Тэдний дундаж хүү хэд байсан бэ. 2025 онд энэ чиглэлээр ямар зорилт тавьж байна вэ гэж 2 дахь асуулт.

3 дугаар асуулт болохоор бол ард иргэдээс ирсэн санал, гомдлыг харахад бол энэ даатгалын салбартай холбоотой санал, гомдол маш их байдаг юм байна. Дараагаар нь 2024 онд бол энэ үл хөдлөх хөрөнгийн зуучлалын салбартай холбоотой гомдол их байсан гээд энэ тайлан дээр тусгагдсан байна. Тэгэхээр энэ үл хөдлөх хөрөнгийн зуучлалын салбарт ямар гомдол байдаг юм. Борлуулалтын захиалгатай холбоотой гомдол байдаг юм уу. Эсвэл шинэ байрны захиалгатай холбоотой юм болов уу. Яг ямар гомдлын тухай яригдаад байна вэ гэдэг ийм 3 асуулт.

Р.Батболд: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Т.Жамбаажамц: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Гадаадын хөрөнгө оруулагч нар бол хөрөнгийн зах зээл дээр бол үнэхээр ус, агаар шиг хэрэгтэй байгаа. Соронзонболд гишүүн сайн мэдэж байгаа. Сүүлийн 2 жилийн хугацаанд, бараг 3 жилийн хугацаанд байна уу Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс салбарын оролцогч, мэргэжлийн байгууллага, банк санхүүгийн байгууллагууд, хөрөнгийн биржтэйгээ энэ гадаадын санхүүгийн төвүүдэд Хонконг, Шанхай, Сөүл, тэгээд Сингапур, Нью-Йорк гээд энэ санхүүгийн төв болсон хотуудад салбарын мэргэжилтнүүдтэйгээ очиж хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүд хийгээд байгаа. Энд бол манай банк, санхүүгийн салбарынхан бүгд оролцдог. Энэ арга хэмжээний хүрээнд бол нэлээдгүй гаднын хөрөнгө оруулагч

нар бол сонирхлоо илэрхийлдэг. Манайд хөрөнгө оруулах сонирхлоо илэрхийлдэг. Бид бүхэн бол очоод Монгол Улсад хөрөнгийн зах зээл дээр ямар ямар бүтээгдэхүүн байна, ямар боломжууд байна, татвар болон бусад хууль, эрх зүйн зохицуулалтын шинэчлэл ямар, ямар түвшинд хийгдэв гэдэг энэ мэдээллүүдээ бол тухай бүр мэдээлээд явж байгаа. Хамгийн сүүлд сая хоёр 7 хоногийн өмнө Нью-Йоркт хөрөнгө оруулалтын форум болсон. Нью-Йоркт болсон хөрөнгө оруулалтын форум дээр бол гадаадын хөрөнгө оруулалтын сангууд, хөрөнгө оруулалтын банкнууд нийтдээ 70, 80 гаруй хөрөнгө оруулалтын банкнуудын төлөөлөл бол оролцсон. Тэд нар бол маш тодорхой нэр бүхий компаниуд бол Монголд салбараа байгуулаад, тэгээд үйл ажиллагаагаа явуулаад эхэлж байгаа. Энэ бол бас нэлээдгүй тийм нааштайдуу мэдээ байгаа. Зүгээр бид нарт тоо харахаар өнгөрсөн оны жишээ нь арилжаа дээр гадаадын иргэн, аж ахуйн нэгж гэхээр жишээ нь нийт арилжааны 0,7 хувьд нь гадаадын иргэн, аж ахуйн нэгж 0,8 хувьд нь л оролцсон байгаад байгаа юм. Үнэхээрийн хангалтгүй үзүүлэлт.

Гэтэл 2012 онд нийт хөрөнгийн зах зээлдэх арилжааны 90 орчим хувийг бол гадаадын хөрөнгө оруулагч нар оролцдог ийм байсан. Тэгэхээр бид бүхэн бол энэ дээр ийм үе шаттай арга хэмжээнүүд хэрэгжүүлж байгаа.

Улсын Их Хурлаас 2024 оны 4 сард Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн хуульд болон Татварын хуулиудад өөрчлөлт оруулсан. Энэ хуулиудаар гадаадын хөрөнгө оруулагч нарт орж ирэх татварын нэлээдгүй ийм таатай орчин үйлчилж байгаа. Тэгэхээр бид бүхэн энэ арга хэмжээг цааш нь бол маш хурдан шуурхай хэрэгжүүлнэ. Энд бас 1 зүйл хэлэхэд энэ оны 9 сарын 13, 14-нд Азийн хөрөнгийн зах зээлийн форум Монгол Улсад болох гэж байгаа. Энд бол Азийн хөгжиж байгаа болон хөгжсөн нийт 30 гаруй орны хөрөнгийн зах зээлийн гол оролцогч, мэргэжлийн байгууллагууд ирж, Монгол Улсад Азийн хөрөнгийн зах зээлийн чуулган анх удаа болж байгаа. Тэгээд энэ хүрээнд бол энэ Азийн томоохон хөрөнгө оруулалтын сангууд, андеррайтерууд бол манайд сонирхлоо илэрхийлээд, бид бүхэн энэ дээр бол цаашид ажиллана гэж харж байгаа.

2 дахь асуулт. Улаанбаатар хот, хөдөөгийн санхүүгийн хүртээмжийн асуудлыг Соронзонболд гишүүн хөндлөө. Санхүүгийн хүртээмжийн асуудал бол хэдийгээр яг нөгөө салбар үйл ажиллагаа бол хөдөө, орон нутагт Улаанбаатар хоттой харьцуулахад бага байгаа боловч ер нь бол манай хөрөнгийн зах зээл, даатгал, банк бус санхүүгийн салбар дээр бол нэлээдгүй үйлчилгээ бол цахимжсан. Иргэн, аж ахуйн нэгж хаана байгаагаас үл хамаараад санхүүгийн үйлчилгээг бол хөрөнгийн зах зээл дээр оролцох даатгалын үйлчилгээгээ, зээлийн болон хадгаламжийн үйлчилгээнд цахимаар оролцоод явах бүрэн бололцоотой болсон. Тэгээд бид бүхэн бол энэ 2025 онд юунд гол анхаарч байна гэхээр ер нь бол энэ орон нутагт санхүүгийн үйлчилгээг цогцоор нь хүргэдэг тийм бичил санхүүгийн, тэгэхдээ энэ нь өөрөө ашгийн төлөө биш, гишүүддээ үйлчилдэг ийм институцийг бол бэхжүүлэх зорилготой ажиллаж байгаа.

Үүний тулд санхүүгийн Хадгаламж, зээлийн хоршооны хууль 2011 онд батлагдсан. Энийг бол санхүүгийн хоршооны хууль гэдэг ийм агуулгаар өөрчилж, орон нутагт бичил санхүүгийн үйлчилгээ, зээл, хадгаламжаас гадна бусад санхүүгийн үйлчилгээг бол.../минут дуусав/

Р.Батболд: Гүйцээж яриулах уу.

Т.Жамбаажамц: Орон нутагт санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг илүү сайжруулахад бол энэ бичил санхүүгийн буюу энэ санхүүгийн хоршоонууд орон нутагт зээл, хадгаламж, даатгалын төлөөлөгчийн болон бусад санхүүгийн болон соёлын хэрэгцээг бол хангаад ажиллах боломж нөхцөлийг бол бүрдүүлнэ гэж харж байгаа.

Бондын хүү бол манайд өнөөдөр нийтдээ хөрөнгийн бирж дээр 1 орчим их наяд төгрөгийн бонд арилжаалагдсан байна. Биржийн бус зах зээл дээр 2 орчим тэрбум төгрөгийн бонд 2024 онд арилжаалагдсан байна. Нийтдээ 100 гаруй компанийн. Энэ хүү нь бол бирж дээр байгаа бондын хүү бол арай бага бий. Ерөнхийдөө 17 орчим хувийн дундажтай, биржийн бус дээр бол 18, 19 хувийн дундажтай ийм бондын хүүгээр санхүүжилт татаад явж байгаа.

Улаанбаатар хот сүүлийн үед орон нутгийн засаг захиргаанаас бонд гаргаж байгаа. Ялангуяа өнгөрсөн онд бол нийслэлээс орон нутгийн бондыг бол нийтдээ 500 тэрбумын орон нутгийн бондыг бол 36 сар, 24 сар, 12 сарын хугацаатай 3 транчаар нийслэлийн Засаг даргаас бол ийм бонд гаргаж байгаа. Тэгэхээр бондын санхүүжилт бол бас санхүүжилтийн 1 чухал ийм хэлбэр болоод явна. Зөвхөн аж ахуйн нэгжүүд банкнаас биш, банкнаас гадна бондын санхүүжилтээр олон нийтээс мэргэжлийн хөрөнгө оруулагч нараас биржийн болон биржийн бас зах зээл дээр санхүүжилт татаад явах энэ боломж нь нээлттэй. Энэ дээр бол юунууд бол нэлээдгүй ажиллаж байгаа.

Үл хөдлөх хөрөнгийн салбар дээр ер нь бол манай дээр үл хөдлөх хөрөнгийн зуучлалуудыг бол бүртгэдэг. Нийтдээ 350 орчим үл хөдлөх хөрөнгийн зуучлалын компаниуд бол тусгай зөвшөөрөлтэй. Зуучлалын компаниудтай холбоотой гомдол бол Соронзонболд гишүүн ээ, харьцангуй бага байгаад байгаа юм. Хэрэв зуучлалын компанийн үйл ажиллагаатай холбоотой гомдол бол Санхүүгийн зохицуулах хороонд хандаад шийднэ. Зуучлалын .../минут дуусав/

Р.Батболд: Гүйцээж хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Т.Жамбаажамц: Үл хөдлөх хөрөнгийн брокеруудаар дамжиж, үл хөдлөх хөрөнгийн зах дээр худалдах, худалдан авах, түрээслүүлэх хөрөнгө оруулалтын менежментээ хийлгэх ийм үйлчилгээ бол сүүлийн жилүүдэд нэлээдгүй бий. Энэ дээр бол яг манай дээр тусгай зөвшөөрөл авсан үл хөдлөх хөрөнгийн брокеруудаар бол дамжиж үйл ажиллагаа явуулбал харьцангуй хохирох, санхүүгийн эрсдэлд орох ийм зөрчил бол харьцангуй бага байгаа.

Тэр үл хөдлөх хөрөнгийн захиалгын гэрээ гэдэг юм уу бусад өөр түрээс дээр нь луйварддаг гэдэг юм уу ийм зүйлүүд бол нэлээдгүй. Ялангуяа цагдаагийн байгууллага дээр бол маш их бүртгэлтэй байдаг юм байна лээ. Тэгэхээр энэ дээр бол харьцангуй манайд зуучлалын компаниар дамжаагүй өөр бусад зөвшөөрөлгүй ийм хүмүүсээр оролцох нь бол өөрөө эрсдэлтэй байгаад байгаа юм. Тэгэхээр манай дээр бол энэ үл хөдлөх хөрөнгийн брокерын зуучлалын гадаадын нэр нөлөө бүхий франчайзын 3 компани Монголд үйл ажиллагаа явуулж байгаа. Эдгээрээс гадна дотоодын зуучлалын олон жил үйл ажиллагаа явуулсан үл хөдлөх хөрөнгийн брокерын агентууд бол үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгээд бид нар бол энэ үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн дээвэр холбоо бий. Дээвэр холбоотой бол бид нар маш нягт хамтарч ажилладаг. Байнгын сургалтыг нь хийдэг. Үл хөдлөх хөрөнгийн брокеруудын ёс зүйн болон мэргэжлийн бүх сургалтуудыг нь тогтмол

явдаг. Аттестатчилдаг, агентын эрхийг нь олгодог. Холбоогоор нь дамжуулж ингэж бол явдаг. Тэгэхээр энэ дээр бол харьцангуй мэргэжлийн болж төлөвшиж байгаа ийм салбар бий. Хэрвээ үл хөдлөх хөрөнгийн зуучлалын үйл ажиллагаатай шууд холбоотой иргэд, хуулийн этгээдэд хохирол учруулсан, хууль бус үйл ажиллагаа явуулсан бол тэрийг бол санхүүгийн зохицуулах хороо дор нь арга хэмжээ аваад, шаардлагатай бол тусгай зөвшөөрлийн түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл арга хэмжээ аваад явдаг. Баярлалаа.

Р.Батболд: Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Шинээр баригдах гэж байгаа барилгын борлуулалтын захиалга, өөрөөр хэлбэл Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад байдаг үл хөдлөх хөрөнгийн зуучлагчаар дамжиж байна уу, дамжихгүй байна уу. Энэ дээр хэн хяналт тавьж байгаа вэ. Энэ дээр ер нь хууль, эрх зүйн хувьд ямар өөрчлөлт оруулах талаар бодож байна вэ. Би ойлгохдоо бол шинэ байрны захиалгын гомдол санал бол маш их байдаг гэж ойлгоод байгаа. Энийг бол бас манай Энхбаяр гишүүн их ярьдаг. Баттөмөрийн Энхбаяр гишүүн их ярьдаг. Тэгэхээр энэ дээр Санхүүгийн зохицуулах хороо дээр ямар мэдээлэл байна.

Р.Батболд: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Т.Жамбаажамц: Соронзонболд гишүүний нэмэлт тодруулгад хариу өгье. Шинээр барилгын төслүүд хэрэгжүүлж байгаа компаниуд бол ер нь бол өөрсдөө борлуулалтаа хариуцаж байгаа. Өөрсдөө маркетингийн алба нь, компани нь өөрөө борлуулаад явдаг. Энэ нь бол хуулиараа нээлттэй. Шаардлагатай бол хүсвэл тэр төсөл хэрэгжүүлж байгаа компаниуд энэ үл хөдлөх хөрөнгийн зуучлалын компаниудтай гэрээ байгуулаад, зуучлалын компаниуд бол борлуулаад, захиалгыг нь хийгээд явдаг ийм зохицуулалттай байж байгаа. Үл хөдлөх хөрөнгийн зуучлалын салбар бол Соронзонболд гишүүн бол маш сайн мэдэж байгаа. Бие даасан хуульгүй байгаа. Ямар ч хуулийн зохицуулалтгүй байгаа. 2020 онд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулаад, тэгээд Санхүүгийн зохицуулах хороог бол бүртгэл хяналт тавих, бүртгэлжүүлэх, мөнгө угаах эрсдэлийг үнэлэх, мөнгө угаах тэр мэдээлэх тайлагнах үүргийн хэрэгжилтийг хангуулах энэ үүргийг бол хороонд өгсөн. Энэ хүрээндээ Санхүүгийн зохицуулах хороо энийг бол бүртгээд явж байгаа.

Р.Батболд: Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууж, үг хэлье.

О.Батнайрамдал: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Ер нь Монгол Улсын макро эдийн засгийн түвшнийг аваад үзэх юм бол ер нь эдийн засгийг боомилж байгаа гол хүчин зүйлүүдийн 1 бол яалт ч үгүй маш үнэтэй санхүүжилт, өндөр хүү, зээлийн өндөр хүү гэсэн үг. Тэгээд дээрээс нь нийт зах зээлээ аваад үзэх юм бол хэтэрхий арилжааны хэдэн банкнуудаасаа хамааралтай явж ирсэн. Арилжааны банкнуудыг аваад үзэх юм бол ер нь 5 банк нь нийт зах зээлийнхээ бараг 80, 90 хувийг бүрдүүлдэг. Эдийн засаг талаас нь аваад үзэх юм бол илүү олигополистик буюу цөөхөн оролцогч зах зээлийнхээ дийлэнхийг бүрдүүлж явдаг гэсэн үг. Тэгэхээр энийг системийн хувьд, бүтцийн хувьд өөрчлөхөд ерөөсөө л хөрөнгийн зах зээлийн өсөлт, хөрөнгийн зах зээл, арилжааны зах зээлүүдтэйгээ өрсөлдөхүйц хэмжээнд л томрох ёстой. Ер нь дэлхийн хөгжилтэй орнуудыг аваад үзсэн ч гэсэн ер нь хөрөнгийн зах зээл нь бол арилжааны банкнуудаа бодох юм бол хамаагүй том байдаг шүү дээ. Тэгэхээр бид нар энэ голдирол руугаа л явах нь зүйтэй.

Тэгээд Монгол улсын хөрөнгийн зах зээлийн өсөлтийг аваад үзэх юм бол ялангуяа сүүлийн 4, 5 жилийн хувьд өмнөх мөн үетэйгээ харьцуулах юм бол нэлээн өндөр өсөлтүүд явсан. Энэ бас 1 талаасаа яалт ч үгүй амжилт мөн шүү. Хөрөнгийн зах зээлийн үнэлэмжийг аваад үзэх юм бол ДНБ-тэй харьцуулахад 16,3 хувь болж өссөн. Гэхдээ Монголдоо ойролцоо орнуудын жишээг аваад үзэх юм бол жишээлбэл миний хамгийн сүүлд санаж байгаагаар Казакстан улс байна. Бараг 50, 60 хувьд хүрчихсэн байгаа юм. Тэгэхээр бид нар тэр хэмжээнд хүрч чадах юм бол нэг ёсондоо арилжааны банкнуудтай өрсөлдөхүйц хэмжээнд тэднээс бага илүү бүтээгдэхүүн үйлчилгээг хөрөнгийн зах зээлд санал болгоно гэсэн үг. Хэрэглэгчдээ ЖДҮ-лэлүүдэд, том аж ахуйн нэгжүүдэд. Тэгэхээр 2 зүйл байгаа юм 1 дүгээрт биржийн зах зээл дээр цаашаагаа хөгжүүлэхэд мэдээж гадаадын хөрөнгө оруулалтыг татахад бүтээгдэхүүн нь байх ёстой. Өнөөдрийн бүтээгдэхүүнийг аваад үзэх юм бол цөөхөн хэдэн компани л харагдана. Тэрнээс цаашаагаа бүтээгдэхүүн байхгүй болохоор гадаадын хөрөнгө оруулагчид ялангуяа институцийн томоохон хөрөнгө оруулагчид сонирхохгүй гэсэн үг. Тэр бүтээгдэхүүнүүд гарч ирэх ёстой. Энэ дээр бол Засгийн газартайгаа ажиллаад энэ том төрийн өмчит компаниудыг хөрөнгийн бирж дээр бид нар гаргаж, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдад сонирхох бүтээгдэхүүнүүдийг гаргаж ирэх ёстой. Би хэлээд байгаа. Үүний хамгийн тод жишээ жишээлбэл Оюутолгой өөрөө байхгүй юу. Оюутолгойг бүгдээрээ мэднэ. Гадаадын хөрөнгө оруулагчид Монголыг бараг Оюутолгойгоор мэддэг. Тэгэхээр Оюутолгойг жишээлбэл дотоодын хөрөнгийн бирж дээрээ яагаад гаргаж болохгүй гэж. Энэ бол Монголын дотоодын хөрөнгийн бирж дээр нэлээн цахиур хагалсан, дараагийн түвшинд гаргасан шийдэл гэж бодож байгаа юм. Та бүхний бас саналыг сонсьё 1 дүгээрт.

Дарга аа, минутаа үргэлжлүүлээд авчихъя. Амжихгүй байх.

2 дугаарт бист биржийн бус зах зээл сүүлийн бас 3 жил гарч ирээд, ер нь бол маш сайн явсан. Сүүлийн 3 жилийн хугацаанд та нарын тайлан дээр байна. Өү Ти Си буюу биржийн бус зах зээлээр 148 компани 3,4 их наяд төгрөгийг босгож чадсан зээлээр. Тэгэхээр энэ хэрвээ биржийн бус зах зээл байгаагүй бол арилжааны банкнаас л авах мөнгө байсан байхгүй юу. Тэгэхээр энэ хүү багатай биржийн бус зах зээлээс авахаар бизнест нь хүртэл илүү ашигтай үнээ бууруулах боломж нь олдоно гэсэн үг. Тэгэхээр энийг бид нар хэрхэн цаашаа илүү төгөлдөршүүлэх вэ. Яаж ЖДҮ-лэлүүд жижиг, дунд бизнес эрхлэгчид биржийн бус зах зээлээс жишээлбэл санхүүгийн хэрэгцээтэй бүтээгдэхүүнээ үйлчилгээгээ авдаг боломжийг бид нар нээх вэ. Тэгэхээр энэ 2 багц асуултыг асууя.

Р.Батболд: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Т.Жамбаажамц: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Маш чухал асуудал хөндөж байна. Хөрөнгийн бирж дээр бид бүхэн бол бүтээгдэхүүний нэр төрөл, чанарыг нэмэгдүүлэх чиглэлээр бол ажиллаж байна. Энэ дээр бол та мэдэж байгаа. Ерөнхийдөө 4, 5 жилийн өмнө бол манай бирж дээр үндсэндээ хувьцаа гэдэг л ганцхан бүтээгдэхүүн үндсэндээ зарагддаг. Засгийн газрын бонд байхгүй, компанийн бонд байхгүй, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас байхгүй, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх гээд ийм бүтээгдэхүүн ерөөсөө байдаггүй байлаа. Тэгээд хорооны сүүлийн хийж хэрэгжүүлж байгаа гол ажлууд бол хөрөнгийн зах зээл дээр арилжаалагдах бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ гэдэг дээр бол онцгой анхаарал хандуулж ажиллаж ирсэн. Үүний гол тоон үзүүлэлт бол саяын миний тэр юун дээр хэлдэг нийт 1,5 их наядын арилжааны өнгөрсөн

оны арилжааны компанийн бонд бол бараг 1 их наяд орчмын арилжааны дүнтэй. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гэдэг ирээдүйд мөнгөн урсгал бий болгох боломжтой активуудаар суурилсан ийм бүтээгдэхүүнүүд бол гараад эхэлчихсэн.

Одоохондоо бол бид бүхэн зөвхөн зээл дээр гараад байна. Компаниуд зөвхөн зээлийг үнэт цаасжуулаад бүтээгдэхүүн болгож гаргаад байна. Цаашид бол энэ зээлээс гадна, зээлийн картын авлага, түрээсийн орлого гээд өөрөөр хэлбэл ирээдүйд мөнгөн урсгал нь баталгаатай орж ирдэг ийм жижиг дунд хэлбэрийн компаниуд үнэт цаас, өөрийнхөө ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалаа, мөнгөн орлого, активаа үнэт цаасжуулаад гаргах энэ боломж бол нээлттэй. Энэ дээр бол манайх бол нэлээдгүй тийм нээлттэй ажиллаж байгаа.

3 дугаарт нь бол энэ компанийн бондын зах зээл. Бид бүхэн бол энэ бонд дээр бол онцгой анхаарал хандуулна. Бүр онцгой анхаарлаа хандуулна. Ялангуяа судалгаа ингээд хараад үзэхээр бонд татаж байгаа компаниуд бол харьцангуй татаж байгаа компанидаа бол нэлээдгүй таатай нөхцөлөөр татагдаад байгаа юм. Төлбөр нь бол 3 сараар юм уу, 6 сараар хүү бол үндсэн төлбөр нь төлөгддөг. Хугацааны эцэст үндсэн төлбөр нь төлөгддөг. Дундаа хүүгээ бол үнэт цаас гаргагч нь өөрөө тогтоогоод явдаг. Гэтэл банкнаас зээл авбал дараа сараас нь эхлээд л хүүг нь төлөөд л явдаг шүү дээ. Тэгтэл төлбөрийн ийм уян хатан нөхцөлтэй.

2 дугаарт нь бол хүүгийн хувьд харьцангуй банкуудын жижиг дунд компаниудад олгогдож байгаа бизнесийн зээлийн хүүгээс бага хүүтэй байгаа. Өөрөөр хэлбэл биржийн болон биржийн бус зах зээл дээр. Тэгэхээр энэ тал дээр бол бид нар бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх, тэгээд бид нар бол өнгөрсөн жил Эй Ти Эф буюу Эксченж Трейд Фанд гээд биржүүдийн индекс дээр суурилсан бүтээгдэхүүнүүдийг бол гаргасан. Анх удаа журам зохицуулалтыг нь бий болгоод гаргасан. Одоо бид нар яг юун дээр тооцож энэ 2025, 2026 онд юу гэж тооцож байна гэхээр бид бүхэн энэ хөрөнгийн зах зээл дээр нөгөө си ди буюу хадгаламжийн сертификатуудыг арилжаалах гэж байгаа юм. Хуулийн орчин нь бүрдчихсэн. Өнгөрсөн оны 4 сард хуульд өөрчлөлт орсон. Өөрөөр хэлбэл банканд байгаа тэр хадгаламжийн сертификатуудыг хөрөнгийн зах зээлийн 1 чухал бүтээгдэхүүн болгоно гэж харж байгаа. Тэрний дараагаар ритүүдийг, өөрөөр хэлбэл үл хөдлөх хөрөнгийн сангуудын хувьцааг энэ дээр арилжаалдаг болно. Тэгэх юм бол манай бүтээгдэхүүн дээр .../минут дуусав/

Р.Батболд: Оюутолгой холбоотой, төрийн өмчит компанитай холбоотой нэмэлт хариулт өгье. Ажлын хэсгийн 4.

Т.Жамбаажамц: 2 дахь асуулт бол маш чухал асуулт. Энэ бол ер нь дэлхий нийтээр өнөөдөр олон нийтийн паблик компани бол бизнесийн үйл ажиллагааны хамгийн сонгодог хэлбэр юм гэдгийг бол бүгд зөвшөөрчихсэн. Өөрөөр хэлбэл бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, аж ахуйн нэгж бол олон нийтэд нээлттэй, олон хувьцаа эзэмшигчтэй, мэргэжлийн томоохон хөрөнгө оруулагч нар орж ирдэг, засаглалын хувьд тунгалаг, ил тод гээд энэ маш олон олон улсын стандартуудыг хангасан Ой Си Ди-ээс ч гэсэн үндсэн ийм зарчмуудыг тавьж байгаа. Тэгэхээр энэ шаардлагыг хангасан олон нийтийн компаниуд бол манайд бол ус, агаар шиг хэрэгтэй. Ялангуяа төрийн өмчтэй болон үндэсний томоохон компаниуд ай пи өү хийхийг бол хороо бодлогоор дэмжинэ. Тэгээд тэрний урьдач нөхцөлд бол бид нар топ 100-ийн хөтөлбөрийг бол хэрэгжүүлээд явж байгаа. Ялангуяа топ 100 компаниудтай бид нар уулзаад танайх олон нийтийн

болооч ээ, паблик болооч ээ, тодорхой хувиа олон нийтэд зараач ээ гэхээр бид нар одоохондоо тийм хэрэгцээ шаардлага алга байна гэдэг л ийм л хариулт хэлээд байдаг. Тэгэхээр бид нар бол эхний ээлжид олон нийтийн болж хувьцаа гаргахын өмнөх шат буюу тэр олон нийтийн санхүүжилт татах, бондын санхүүжилт татаад, тэгээд олон нийтээс санхүүжилт татаад олон нийтийн хяналтад ороод олон нийтийн мэдээлэх тайлагнах үүргээ хэрэгжүүлээд явах энэ юунуудаас нь эхлээд ингээд явбал маш зүйтэй юм гэж үзэж байгаа.

Ашигт малтмалын энэ томоохон компаниуд, ялангуяа стратегийн ордуудыг эзэмшиж байгаа энэ компаниуд бол дотоодын хөрөнгийн бирж дээр 10-аас доошгүй хувиа арилжаална гэсэн хуулийн заалттай. Ашигт малтмалын тухай хуулийн заалттай. Тэгээд энэ хуулийг бол хэрэгжүүлж ажиллах ёстой. Санхүүгийн зохицуулах хорооны хувьд бол бүтээгдэхүүнийг нь бүртгэдэг байгууллага. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулагч талын мэдээ, тайлан нь үнэн зөв байна уу, нөөц нь зөв тогтоогдсон байна уу, хөрөнгийн үнэлгээ, тайлан, хуулийн дүгнэлтийг нь хянаж бүртгэдэг. Өөрөөр бол зах зээл дээр гаргадаг ийм байгууллага. Энийг бол хувьцаа эзэмшигч нь тэр олон нийтийн болгох, паблик болгох энэ үүргээ бол биелүүлээд явна. Хорооны хувьд бол ялангуяа ашигт малтмалын төрийн өмчтэй энэ компаниудыг бол нээлттэй болоход бүрэн дэмжиж, бүх зохицуулалтын орчин нөхцөлийг бол .../минут дуусав/

Р.Батболд: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон нэмж хариулъя.

Т.Жамбаажамц: Жижиг дунд хэлбэрийн манай энэ Өү Ти Си дээр гарч байгаа 150 орчим компанийн бонд байгаа. Энэ бол үндсэндээ том хэлбэрийн компаниуд бол маш бага. Том компаниуд ерөөсөө бага. Дандаа л энд бид нарын нөгөө ЖДҮ-ийн тухай хуулиараа ер нь бол дунд хэлбэрийн тийм компаниуд л энэ дээр бонд гаргаж байгаа. Дунд хэлбэрийн бонд гаргаж байгаа. Яагаад ингэж байна гэхээр харьцангуй шаардлага багатай. Нөгөө мэргэжлийн хөрөнгө оруулагч нарын хүрээнд хаалттай зарагддаг учраас шаардлага шалгуур нь харьцангуй багатай. Андераторын компани нь өөрөө хяналтаа тавиад, өөрөө бүх бичиг баримтыг нь үзээд, тэгээд тэр хаалттай хүрээндээ зардаг учраас энэ дээр бол ихэнх нь жижиг дунд хэлбэрийн компаниуд л энэ дээр бондоо зарж байгаа. Бирж дээр нээлттэй бонд гаргавал арай өөр шаардлагатай байна. Тэр нь өөрөө олон нийт худалдаж авдаг учраас паблик олон нийтэд зарагддаг учраас тэр дээр бол шаардлага шалгуур нь арай өндөр байдаг. Бид нар бол топ 100 дээр бол тэр шаардлагуудыг нь нэлээн багасгачихсан. Гарч ирээрэй, бондоо гаргаарай гээд. Баярлалаа.

Р.Батболд: Батнайрамдал гишүүн 1 минут.

О.Батнайрамдал: Тэгэхээр зах зээлийн үнэлэмж 18 хувь руу дөхлөө. Энийгээ бүгдээрээ хэрвээ даблдаж чадах юм бол өнөөдрийн дүр зураг шал өөр болох юм л даа. Тэгэхээр ялангуяа тэр та сая хэллээ. Биржийн бус зах зээлээр бондын санхүүжилт босгож байгаа 150 компанийн дийлэнх нь дунд хэлбэрийн компаниуд гэж байна. Тэгэхээр энэ өөрөө яг миний бодлоор эрүүл зүйл гэж хараад байна л даа. Зөв зүйл. Тэгэхээр тийшээгээ яаж олон компанийг илүү татан оролцуулах вэ. Яаж ЖДҮ-лэлүүдийн бизнес эрхлэх тэр орчинд нь зээлийн хүүг нь бууруулахад жишээлбэл бодлогыг нь зүгээр бид нар тусалж, дэмжиж чадах уу. Тэгэхээр энэ л өөрөө цаашдаа Монгол Улсын эдийн засагт ч гэсэн буцаад зээлийн хүү буурах үндсэн гол нөхцөлүүд нь болно л гэж хараад байгаа юм л даа. Тэгэхээр энэ дээрээ та бүхэн тэр ЖДҮ-лэлүүдээ сайн дэмжээрэй. Тэд нарт .../минут дуусав/

Р.Батболд: Батнайрамдал гишүүн үг хэллээ. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дууслаа.

14.29 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 4.

Үндэсний статистикийн хорооны 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж эхэлье.

Тайлангийн танилцуулгыг Үндэсний статистикийн хорооны дарга Батдаваа хийнэ. Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг нээнэ үү.

Б.Батдаваа: Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Үндэсний статистикийн хорооны 2024 оны үйл ажиллагааны тайланг та бүхэнд товч танилцуулъя.

Бид өнгөрсөн онд нийгэм, эдийн засаг, байгаль орчны 346 багц статистик мэдээллийг тогтмол бэлтгэхийн зэрэгцээ мэдээллийн аюулгүй байдал, эрсдэлийн удирдлага, статистикийн дэд бүтэц, хүний нөөцийг бэхжүүлэх үйл ажиллагааг өгөгдлийн шинжлэх ухаанд суурилан боловсронгуй болгох зорилтууд тавьж ажилласан. Энэ хүрээнд статистикийн мэдээллийн чанар, хамралтыг сайжруулах, гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэх, мэдээллийг өргөтгөх их өгөгдөл орон зайн мэдээллийг статистикийн үйлдвэрлэлд нэвтрүүлэх зэрэг томоохон ажлуудыг эхлүүллээ.

Ингээд 2024 оны үйл ажиллагааны онцлох ажлуудыг товч танилцуулъя.

1 дүгээрт Үндэсний статистикийн хороо 2024 онд мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүллээ. Ингэснээр статистикийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагад ахиц гарсан.

2 дугаарт төрийн зарим байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэж, төрийн нэгдсэн өгөгдлийн сан болон төрийн мета өгөгдлийн нэгдсэн сангийн цахим талбаруудыг ашиглалтад орууллаа. Эдгээр цахим талбаруудын мэдээлэлд тулгуурлан хэрэглэгчид олон хэмжээст нарийвчлал бүхий өгөгдөл ашиглан шийдвэр гаргах, судалгаа шинжилгээ хийх өргөн боломжтой болж байна.

3 дугаарт судалгаа шинжилгээний ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын 1918-1991 он хүртэлх нийгэм, эдийн засгийн түүхэн мэдээллийг нэгтгэж, Статистикийн мэдээллийн нэгдсэн санд байршууллаа.

4 дүгээрт статистикийн суурь болон төрөлжсөн мэдээллийн сангууд болох бизнес регистрийн сан болон хүн ам, өрхийн мэдээллийн санг шинэчилж, газар зүйн мэдээллийн санг анх удаа цогц хэлбэрээр хөгжүүллээ.

5 дугаарт хэрэглэгчдэд статистикийн мэдээллийг хялбар түргэн шуурхай хүргэх, хиймэл оюунд суурилсан статистикийн нэгдсэн мэдээллийн санд чатботыг шинээр нэвтрүүлээ.

6 дугаарт мэдээлэл цуглуулалтаас тархаалт хүртэлх алхмыг цахимжуулсан статистикийн үйлдвэрлэлийн системийн нэвтрэлтийг нэмэгдүүлж байна.

7 дугаарт дотоод үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, түүвэр судалгааны мэдээлэл цуглуулалтыг хянах цахим системийг шинээр нэвтрүүлээ.

8 дугаарт сансрын зураг ашиглан мал аж ахуйн мэдээллийг хянах, тооцох, машин, сургалтын аргаар малыг ялган тоолох ажлыг эхлүүллээ. Энэ туршлагаа бид байгаль орчин, хөдөө аж ахуй, хүн ам, нийгмийн статистикт ашиглах бүрэн боломжтой болж байна.

9 дүгээрт гадаад хамтын ажиллагааны хүрээнд НҮБ-ын Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын статистикийн товчооны дарга, мөн Ази, Америк, Номхон далайн орнуудын Үндэсний Тооллого Статистикийн Нийгэмлэгийн дэд ерөнхийлөгчөөр ажиллаж бүс нутаг болон Монгол Улсыг төлөвлөлөө.

Түүнчлэн Бүгд Найрамдах Солонгос Ард Улс, БНХАУ болон Австралийн Холбооны Улсын статистикийн байгууллагуудтай хамтарч, шинэ технологийн хэрэглээг статистикт нэвтрүүлэх төслүүдийг эхлүүлж мөн Монгол Улсын Улаанбаатар хотод олон улсын түвшний 6 удаагийн хурал, сургалтыг зохион байгууллаа.

Өнгөрсөн онд бид статистик мэдээллийг 7 хоног, 15 хоног, сар, улирал, хагас жил, жилийн давтамжтай боловсруулж, сарын танилцуулга, сэдэвчилсэн судалгаа эмхэтгэл хэлбэрээр олон нийтэд хүргэлээ. Үүнээс гадна хүн амын эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, боловсролын чанар, амьдрах орчны аюулгүй байдалтай холбоотой нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, гэмт хэрэгт хохирох, эрсдэлийн судалгаа, цаг ашиглалтын судалгаа зэрэг 6 түүвэр судалгааны үр дүнг боловсруулж, 7 түүвэр судалгааг зохион байгуулж, 1 тооллого явууллаа.

Эдгээр статистик мэдээлэл судалгааны тайлангуудыг Үндэсний статистикийн хорооны цахим хуудсаар дамжуулан Монгол, Англи хэлээр тогтмол тархааж, мөн нийгмийн сүлжээний сувгуудаар дамжуулан нийтэд бид мэдээлж байна. 2024 онд статистик энэ мэдээллийн нэгдсэн сангаас нийтдээ 1 сая 21 мянган хэрэглэгч мэдээллийн үйлчилгээ авсан байна.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын статистикийн систем нь мэдээллийн хамрах хүрээ нээлттэй байдлаар дэлхийд 11 дүгээр байрт, Зүүн Азид 2 дугаарт, Дэлхийн банкны гүйцэтгэлийн үнэлгээгээр зүүн Ази, өмнөд Ази, Номхон далайн орнуудаас 7 дугаар байрт, дэлхийд 51 дүгээр байрт. Дэлхийн эдийн засгийн байгууллагын үндэсний тооцооны өгөгдлийн чанараар Ази, Номхон далайн улсуудаас 9 дүгээр байрт, дэлхийд 49 дүгээрт, хүн амын статистикийн чанарын үзүүлэлтээр Ази, Номхон далайн улсуудаас 8 дугаарт, дэлхийд 25 дугаарт эрэмбэлэгдэж байна.

Бид статистик мэдээллийн чанарыг үнэлэх, мэдээллийн үйлчилгээг сайжруулах, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага, цаашдын чиг хандлагад нийцсэн статистик мэдээллийг гаргах зорилгоор хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг 2025 оны эхэнд зохион байгуулсан. Энэ судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн 98 хувь нь статистикийн мэдээлэлд зайлшгүй чухал ач холбогдолтой гэж үзсэн бөгөөд мэдээллийн чанарыг 66 хувь нь сайн болон маш сайн, 29 хувь нь дунд, 5 хувь нь муу гэж бичсэн байна. Харин судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн 28 хувь нь статистик мэдээллийг илүү нарийвчлалтай, хугацааны хоцрогдолгүй гаргахаас гадна статистикийн нэгдсэн мэдээллийн санг хэрэглэхэд хялбар болох талаар санал, хүсэлтийг илэрхийлсэн.

Бид Үндэсний статистикийн хорооны зүгээс Монгол Улсын статистикийн системд ОУБ болон гадаад улсуудын байгууллагуудаас хийсэн дээрх үнэлгээ, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаанд үндэслээд үйл ажиллагаагаа цаашид сайжруулахаар анхаарч ажиллаж байна.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Бид 2025 онд дараах ажлуудад анхаарч ажиллана.

1 дүгээрт хүн ам, орон сууцын завсрын тооллого. Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогыг бүртгэлд суурилсан аргаар зохион байгуулна. Ингэснээр бид төрийн нэгдсэн мэдээллийн санг өргөтгөж чадна. Энэ нь хүн ам, нийгэм, эдийн засгийн дэлгэрэнгүй судалгаа мэдээллийг бид цаашдаа жил болгон тооллого хэлбэрээр шинэчилж байх системийн хөгжүүлэлтийн эхлэл болж байгаа юм.

2 дугаарт Монгол Улсын үйлдвэрлэл үйлчилгээ, нэмүү өртгийн хэрэглээ, хамаарлын илэрхийлэх нөөц, ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцлийн судалгааг бид энэ жил боловсруулж, ДНБ-ий суурь оны тооцоог жил бүр шинэчлэх хэлхээ индексийн аргад шилжинэ.

3 дугаарт статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн системийг шинэчилж, хэрэглэгчид ашиглахад хялбар болгоно.

4 дүгээрт статистик боловсруулах үйл ажиллагаанд өгөгдлийн шинжлэх ухааны арга зүйг түлхүү ашиглах, эх өгөгдөл, өгөгдлийн нэгтгэл, хиймэл оюуныг статистикийн үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд анхаарч ажиллана.

5 дугаарт Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хууль санаачлагчид шилжүүлэхээр ажиллаж байна.

6 дугаарт Статистикийн байгууллагын олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, бүс нутагт Монгол Улсын статистикийн байгууллагын гүйцэтгэх үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор НҮБ-ын Ази, Номхон далайн статистикийн институцийн удирдах зөвлөл, цаашлаад НҮБ-ын Статистикийн товчоо ЭЗХАХБ-ын дэргэдэх хиймэл оюуныг статистикт ашиглах ажлын хэсэгт гишүүнээр элсэж, бүс нутаг болон 2 талт хамтын ажиллагааг бид эрчимжүүлэхээр ажиллаж байна.

Үндэсний статистикийн хорооны 2024 оны ажлын тайланд анхаарал хандуулсан Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд та бүхэнд баярлалаа.

Р.Батболд: Үндэсний статистикийн хорооны тайлантай холбогдуулан ажлын хэсгийг танилцуулъя.

Б.Батдаваа Үндэсний статистикийн хорооны дарга, Д.Лхамсүрэн Дэд дарга, Б.Лхагва Тамгын газрын дарга, Ц.Тэгшжаргал Нэгдсэн статистикийн газрын дарга, М.Оюунжаргал Эдийн засгийн статистикийн газрын дарга, Б.Мягмарханд Эдийн засгийн статистикийн газрын Хөдөө аж ахуй, байгаль орчин үйлдвэрлэлийн статистикийн хэлтсийн дарга, М.Оюунцэцэг Нийгмийн статистикийн газрын дарга, Л.Ундрал Нийгмийн статистикийн газрын Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн дарга, Ш.Ариунболд Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын дарга, Д.Оюунбилэг Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын Өгөгдөл, судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга, Н.Мөнхбаяр Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газрын дарга, Б.Цацралт Нэгдсэн статистикийн газрын Олон нийттэй харилцах хэлтсийн дарга.

Танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Батнайрамдал гишүүнээр тасаллаа. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууж, үг хэлье.

Л.Соронзонболд: Статистикийн хорооны тайлантай танилцлаа. Ер нь бол сайн ажилласан байна гэж хувь гишүүний хувьд бол дүгнэж байна. Ялангуяа малын тооллогод бас дрон энэ тэр ашиглаад, шинэлэг технологи ашиглаад явж байгаа юм байна. Бас үүний гол нь иймэрхүү технологи ашигласны үр дүнд өмнө гардаг байсан зардлыг ямар хэмжээгээр бууруулсан юм бэ. Энэ талаараа бас мэдээлэл өгвөл сонирхолтой байна.

2 дугаарт болохоор бол энэ Үндэсний статистикийн хорооноос энэ салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгт гээд энэ мэдээллийг 5 жил тутамд гаргадаг юм байна. Гэтэл бид нар одоо бол Монгол Улс уул уурхайн бус зөвхөн бол уул уурхайгаас хамааралтай энэ эдийн засгийн бүтцээ өөрчилье гээд бодоод байдаг. Тэгэхээр энэ уул уурхайн бус бусад салбараа хэмждэг энэ ажлыг бол нэлээн богино хугацааны давтамжтай хийх шаардлагатай юм болов уу гэж харж байгаа юм. Тэгэхээр энэ ажлыг хийхэд 5 жил биш, 2 жил тутамд байдаг юм уу хийхэд хэдий хэмжээний зардал мөнгөний асуудал гардаг вэ. Энийг бас бид нар Эдийн засгийн байнгын хорооны хувьд бол ялангуяа эдийн засгийнхаа, макро эдийн засгийнхаа асуудлыг хэмжихийн тулд ийм өөрчлөлтийг бол хийх ёстой юм болов уу гэж бодож байгаа. Тэгэхээр энэ асуултад хариулбал сайн байна.

3 дугаарт болохоор бол яамдын бүтцэд бол Статистикийн тухай хуулиараа бол статистикийн хэрэгжилтийг хангах ёстой ийм нэгж байх ёстой гээд. Гэтэл өнөөдөр 2024 оны байдлаар зөвхөн 4 яаманд статистикийн асуудлаа хариуцсан нэгж байдаг тухай бол энэ Улсын Их Хурлын Тамгын газрын тайлан дээр бас орсон байна л даа. Тэгэхээр энэ тал дээр ер нь яамд энэ статистикийн нэгж байхгүй байсны улмаас Үндэсний статистикийн хорооны ажилд ямар хэмжээний бэрхшээл хүндрэл учруулж байгаа вэ. Энэ талаар мэдээлэл өгөөч.

Р.Батболд: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Б.Батдаваа: Эрхэм гишүүн Соронзонболдын асуултад хариулъя. Монгол улсын хэмжээнд мал тооллогыг 1961 оноос хойш ер нь зохион байгуулж байгаа. Мал тооллогыг жил болгоны 12 сарын 7-оос 17-ны өдрүүдэд орон нутагт 21 аймаг,

9 дүүрэгт нийтдээ 12-15 мянган албан хаагчид ажиллаад, тооллогын ажлыг зохион байгуулдаг маш их хүн хүч, цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулдаг ийм ажил байгаа. Үндэсний статистикийн хорооны төсвөөс шууд гардаг зардал нь 160 сая төгрөг. Орон нутгийн төсвүүдийг улсын хэмжээнд нийтэд нь авч үзэх юм бол 900-аад сая төгрөгийн зардал гардаг ийм ажил байгаа. Үүний дээр бол бас эдийн засгийн хувьд бол 12 мянган албан хаагчийн 10 өдрийн ажил зарцуулагдаж байгаа гэдэг утгаараа бол нэлээн бас их хүн хүч зарцуулдаг ийм хүндрэлтэй ажил байгаад байгаа. Энийг бид 2022 оноос хойш ер нь технологид шилжүүлэх талаар бол маш их олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа.

1 дүгээрт юу вэ гэхээрээ жил болгон малд тоологдож байгаа 240 гаруй мянган малчин өрхийн тооллогын мэдээллийг бид 2022 оноос хойш мессежээр мэдээллийг нь хөөж баталгаажуулдаг болж байгаа. Дээрээс нь бид нар 2023 оноос эхлээд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтраад тооллогын мэдээллийг цаашдаа цахимд шилжүүлэх буюу малын үндэсний бүртгэлийн нэгдсэн систем рүү шилжүүлэх ажлыг 2023, 2024 онд бэлтгэл хангаад, ажиллаад явж байгаа.

Дээрээс нь бид бас орон зайн мэдээлэл буюу сансрын зураг ашиглаад энэ малыг тоолох тэр боломжийг ноднин туршилтаар судалгаа хийсэн байгаа. Энэ судалгааг харахад бол Архангайн аймгийн хэмжээнд хийхэд бол бод мал дээр оновчлол 81,6 хувьтай. Дээрээс нь малчин өрхийн гэр байшинг тоолох оновчлол бол 96-98 хувийн оновчлолтой. Цаашдаа бол ашиглаж болох юм гэдэг ийм дүгнэлт гарсан. Гэхдээ энэ дээр нэг зүйл гарч байгаа нь юу вэ гэхээр бид илүү нарийвчлалтай бог мал дээр ашиглая гэх юм бол бас гадаад улсаас сансрын зураг худалдаж авах ийм эрсдэл гарч байгаа. Тийм учраас бид нарын одоогийн төлөвлөгөө бол энэ Хөдөө аж ахуйн яам дээр хөгжүүлээд байгаа энэ малын үндэсний бүртгэлийн нэгдсэн системийг цаашдаа нэгэнт сум болгон дээр хөдөө аж ахуйн тасаг байгаа учраас энийг нь ашиглаад малын тооллогоо явуулъя гэдэг ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Ингэж чадах юм бол бид нар өвөл болгон орон даяар албан хаагчдыг 10 хоног ажиллуулж байх энэ ажлыг бол хөнгөвчлөх юм байгаа юм.

2 дугаар мал тоолохтой холбоотой бидний энэ жилээс нэвтрүүлэгдэж байгаа ажил бол малыг нүдээр үзэж болохоор, гараар тооцдог тэр хоцрогдсон технологийг халъя гэж зорьж байгаа. Өөрөөр хэлбэл имиж рокигнэйшн буюу видео дүрс бичлэгээс шууд малыг төрлөөр нь ялгаад тоолдог энэ технологийг бид бол энэ жил нэвтрүүлэхээр ажиллаж байгаа. Ноднин үүний бэлтгэл болгож машин сургалтаа бэлтгэх зорилгоор 4 мянга гаруй видео бичлэг, дүрсийг улсын хэмжээнд цуглуулаад, сургалтын моделио хөгжүүлээд ажиллаж байгаа гэж хэлж болно.

2 дугаар асуултын хүрээнд бол Соронзонболд гишүүний хэлдэг бол яг үнэн. 5 жилийн хугацаатай бид нар эдийн засгийн суурь бүтцээ, тооцоогоо шинэчлээд байх нь бол бас одоо хангалтгүй байгаад байгаа юм. Бид энэ жил хийх гэж байгаа нэг ажил юу вэ гэхээрээ ноднин төсвийн хэлэлцүүлэг дээр бас Байнгын хорооны гишүүд асууж байсан. Жил болгон эдийн засгийн сууриа шинэчилдэг хэлхээ индекс рүү шилжиж байгаа юм. Тэгээд ирэх юм бол манай эдийн засагт гарч байгаа энэ бүтцийн өөрчлөлтийг бид нар жил болгон илүү оновчтойгоор тооцоолж чадаад статистикийн мэдээллийн чанар маань бол энэ хэрээр илүү ахицтай болно гэдэг ийм үр дүнтэй ажиллана гэж төлөвлөж байгаа. Энэ хүрээнд бол бид нар

салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгтийн судалгааг одоо яг энэ өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж байгаа.

3 дугаарт яамдын бүтцэд статистикийн нэгж байгаагүйгээс гарч байгаа хүндрэл юу байна вэ гэхээр тухайн яаманд тэр хүний нөөцийн эргэлт хэт өндөр байх нь тухайн яамдаас гарч байгаа статистик мэдээллийн чанарт бол шууд нөлөөлдөг. Бидний зүгээс авч байгаа арга хэмжээ бол сургалтад анхаарах, байнга тухайн яам дээрээ .../минут дуусав/

Р.Батболд: Гүйцээж хариулъя. 3 дугаар микрофон.

Б.Батдаваа: Тэгээд яг бидний байгаа мэдээллээр бол Боловсролын яам, Зам, тээврийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Соёлын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бол тусдаа статистикийн нэгжүүд бол бэлэн байгаа. Бусад яамнууд дээр бол яг хариуцсан нэгжүүд байхгүй байгаа. Бид түрүүн бас танилцуулга дээрээ хэллээ. Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бид сүүлийн 2 жилийн хугацаанд ОУБ, төрийн бусад байгууллагуудтай хамтраад боловсруулаад ажиллаж байгаа. Энэ дээр гарах гол бид нарын зорьж байгаа өөрчлөлт юу вэ гэхээр ер нь статистикийг хэрэглэгчдийн эрэлт дээр үндэслэсэн хэлбэрээр боловсруулдаг болъё гэдэг энэ зорилтыг тавин ажиллаж байгаа. Улсын Их Хурлаас Үндэсний статистикийн хороо дээр хийсэн хяналт шалгалтын тайлан дээр ч гэсэн байгаа. Ер нь хууль дээр бүх үзүүлэлтээ заах биш, нийгмийн хөгжил, эдийн засгийн хөгжил өөрчлөгдөх тусам энэ ч шаардлагатай статистик мэдээллийг бол бид нар тухай бүрд нь гаргаж байх, энийгээ системийн хэмжээнд буюу бусад статистик боловсруулж байгаа төрийн бүх байгууллагуудынхаа түвшинд хамтарч боловсруулах арга зүйг сайжруулах уялдааг хангах ажлыг энэ хууль дээр.../минут дуусав/

Р.Батболд: Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Тэгэхээр энэ хэлхээ индекс рүү шилжчихээр салбар хоорондын тэнцлийн мэдээллийг жил болгон гаргах боломжтой болж байна гэсэн үг үү. 1 дүгээр асуулт.

2 дугаарт шууд үг хэлж байгаа учраас энэ бизнес эрхлэгчид бол ер нь 1212.mn гээд сайт руу ороод төрөл бүрийн мэдээллүүд тодорхой хэмжээнд аваад боловсруулалт хийж байгаа. Зах зээлийн судалгаа хийх шаардлагууд эд нар байгаа шүү дээ. Тэгэхээр ялангуяа шинээр бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор ийм тодорхой зах зээлийн судалгаатай холбоотой нээлттэй асуултууд аваад, тэгээд тэр нээлттэй асуултууд дээрээ үндэслээд тодорхой холбогдох яамд руу нь чиглэлийн статистик мэдээллийг хэрэглэгчид шаардаж байна гэдэг байдлаар шаардлагаа тавиад явбал бас зүгээр юм болов уу гэж бодож байна шүү.

Р.Батболд: Соронзонболд гишүүн санал хэллээ. Уучлаарай. Тэр хэлхээ индексийн талаар ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Б.Батдаваа: Асуултад хариулъя. Хэлхээ индекс рүү шилжчихээр бид нар эдийн засгийн нөгөө бүтцийн суурь оноо л жил болгон шинэчлээд яваад байна гэсэн үг. Салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгтийг бол 5 жил тутам бид нар зохион байгуулна хэвээрээ байгаа. Тэгэхдээ энийг бол бид нар төлөвлөгөөнд цаашдаа 3 жил рүү оруулъя гэж зорьж байгаа. Тухайлбал яг үүнтэй

ижилхнээр бид нар хэрэглээний үнийн индексийн сагсыг урьд нь 5 жил байдаг байсныг 3 жил рүү ойртуулсан байгаа. Өөрөөр хэлбэл иргэдийн хэрэглээнд гарч байгаа өөрчлөлтийг илүү богиноор хүлээж авах зорилгоор давтамжуудыг ойртуулж явж байгаа гэсэн үг.

Соронзонболд гишүүний хэлсэнтэй холбоотойгоор бол ер нь бол энэ бизнесийн байгууллагуудын бизнесийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор Үндэсний статистикийн хорооноос төрийн нэгдсэн өгөгдлийн санг бол 2024 онд ашиглалтад оруулсан байгаа. Энэ дээр бол засаг захиргаа, эдийн засгийн ангилал, бараа бүтээгдэхүүний ангилал, нэгжийн түвшинд хоорондоо .../минут дуусав/

Р.Батболд: Гүйцээж хариулъя. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Б.Батдаваа: Энэ дээр бид бас бизнесийн байгууллагуудад мэдээллийг бас илүү түргэн шуурхай хүргэх, нарийн хэмжээст өгөх зорилгоор төрийн нэгдсэн өгөгдлийн санг 2024 оны 5 дугаар сард ашиглалтад оруулсан байгаа. Data.nso.mn гээд сайт байгаа. Энэ дээр бол өгөгдлийн нэгтгэл хэсэг байгаа. Энэ дээр бид төрд байгаа мэдээллийн сангуудыг нэгтгээд, хувь хүн, хуулийн этгээдтэй холбоотой эмзэг мэдээллүүдийг арилгасан хэлбэрээр ингээд бизнесийн байгууллага, судлаачдад ашиглахад бэлэн байдлаар ингээд тавьж ж байгаа. Ингэснээр ямар ач холбогдолтой вэ гэхээрээ аливаа бизнесийн байгууллагууд маань засаг захиргааны хамгийн бага нэгжийн түвшинд, дээрээс нь эдийн засгийн салбаруудын түвшинд, дээрээс нь хүн амын насны бүлэг гээд энэ ангиллууд дээр байгаа тоон мэдээлэл дээр үндэслэж судалгаа, шинжилгээ хийх, бизнесийн шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх датаг бэлэн болгож байгаа.

Р.Батболд: Болсон уу. Одоо Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Үндэсний статистикийн хорооны үйл ажиллагаа, тэгээд гаргаж байгаа үр дүнд бол маш их сэтгэл хангалуун байдаг. Бараг ийм шүүмжлэл хэлэхээргүй цөөхөн хэдхэн төрийн байгууллагуудын нэг болов уу гэж бодож байна. Өнөөдрийн тайлан ч гэсэн ойлгомжтой. Материал нь урьдчилаад ирчихдэг ийм жишгийг бас бусад төрийн байгууллагууд аваад хийгээд яваасай гэсэн тийм бодолтой байдаг.

Статистик мэдээллийн ер нь нээлттэй байдал, чанарын хувьд бол олон улстай харьцуулсан ч гэсэн их өндөр үзүүлэлттэй байгаад байгаа. Энэ бол маш сайн авууштай зүйл. Дээрээс нь нэмээд сая сүүлийн слайдууд байсан. Хэрэглэгчдийн саналд үндэслээд, өөрсдийнхөө байгууллагынхаа анхаарах ёстой асуудлуудыг тодорхойлоод, энэ жилийн хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа тусгачихсан байгаа нь их сайн байна. Ийм хариуцлагатай сайн ажиллаж байгаад баярлалаа. Тэгээд цаашдаа ч гэсэн энэ амжилтаа давтаад үргэлжлүүлээд хадгалаад яваасай гэж хүсэж байна.

Бодлогын чанартай 1 асуулт. Тэгээд хүн ам, орон сууцын завсрын тооллоготой холбоотой 1 асуулт асууя. Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр ажиллаж байна гэж байна. Тэгээд энэ дээр нэг зүйлийг тодруулмаар байна. Манай улс энэ бодлогынхоо хэрэгжилтийг ерөөсөө хэмжиж чадахгүй байгаад байгаа. Бодлогын төлөвлөлт, төсвийн төлөвлөлт, хяналт үнэлгээ

бүгд энд тэнд 100 задгай, хоорондоо уялддаггүй. Татвар төлөгчдийн мөнгийг яг үр дүнтэй зарцуулж байгаа юм уу, үгүй юм уу. Хэзээ нийгэм, эдийн засаг сайжрах юм гэдэг зүйлүүд нь ерөөсөө хэмжигдэж чадахгүй яваад байгаа. Энэ дээр уг нь Үндэсний статистикийн хорооны сайтаас хараад жишээлбэл Алсын хараа 2050 дээр байгаа 73 шалгуур үзүүлэлтүүдийг Үндэсний статистикийн хорооны сайтаас харчхаж болдог. 5 жилийн чиглэл, 4 жилийн хөтөлбөр гээд ийм бодлогын хэрэгжилтийг статистикаар харах боломжтой болгох тийм санал санаачилга ер нь байна уу. Тийм ажил төлөвлөж байна уу. Тэрэнд шаардлагатай мэдээллийг цуглуулах ажил бас төлөвлөж байна уу.

2 дахь нь болохоор сая хэлсэн. Хүн ам, орон сууцын завсрын тооллого энэ жил хэрэгжүүлэх гэж байгаа. Өмнө нь хийгдэж байсан улсын тооллогуудаас ямар онцлогтой вэ. Ер нь цаг үетэйгээ уялдуулаад, шинээр тусгасан асуулгын агуулгууд байна уу. Ямар мэдээллийг цуглуулах гэж байна. Ялангуяа утааг бууруулахад чиглэсэн тоон болон чанарын мэдээлэл ямар ямар зүйлүүдийг цуглуулах гэж байгаа вэ. Ер нь энэ улсын тооллого зохион байгуулахтай холбоотойгоор төрийн байгууллагууд ч юм уу, орон нутгийн байгууллагуудаас санал авдаг уу. Энэ завсрын тооллого хэрэгжүүлэхдээ төр болон орон нутгийн засаг захиргааны байгууллагаас санал аваад, ямар мэдээллүүдийг тусгасан байгаа вэ гэсэн 2 дахь асуулт байна.

3 дахь асуулт бас нэмээд асуучихъя. Их Хурлын Тамгын газраас гаргасан энэ дүн шинжилгээний 7 дээр байна. Үндэсний зөвлөл нь тайлан тоонд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, өгсөн зөвлөмжийн талаар тайлагнаагүй байна гэж байна. Өнөөдөр энэ тайлангаа тавихгүй байсан уу. Эсвэл дараа нь бас тусад нь Байнгын хорооны хурлаар тайлагнаа гэж төлөвлөж байна уу. Ийм 3 асуулт байна.

Р.Батболд: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Б.Батдаваа: Эрхэм гишүүн Лувсанжамцын асуултад хариулъя. Монгол Улсын бодлогын төлөвлөлт, төсвийн төлөвлөлттэй холбоотой шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах чиглэлээр бол өнгөрсөн намраас бол бид нар Эдийн засаг, хөгжлийн яамтай бол хамтарч ажиллаж байгаа. Бас эрхэм гишүүн бас энэ дээр шаардлага тавьсан. Алсын хараа 2050 дээр гэхэд таны хэлдгээр яг 73 шалгуур үзүүлэлтүүд байгаа. Үүний 23-ыг нь Үндэсний статистикийн хорооноос гаргаж байгаа албан ёсны статистик, 37-г нь төрийн байгууллагууд, 13 нь бол олон улсын байгууллагуудаас гаргаж байгаа үзүүлэлтүүд байгаа. Энийг бид бас Монгол улсын 2021-2025 оны хөгжлийн төлөвлөгөөтэй харьцуулаад үзэхэд бол нийт 95 үзүүлэлтээс 69 нь давхардаж байгаа ийм үзүүлэлтүүд байгаа. Зарим төсвийн 1 дүгээр хавсралт болон үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр дээр орсон үзүүлэлтүүд маань яг үр дүн гэхээсээ илүүтэйгээр үйл ажиллагаа оруулчихсан тийм зүйлүүд бол харагдаж байгаа.

Дээрээс нь бас энэ Алсын хараа 2050 болон зарим бодлогын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд дээр байгаа энэ үзүүлэлтүүд маань өөрөө аргачлалын хувьд бас тодорхойгүй, хэмжих хүрэх зорилтууд нь бас хэт ерөнхий ийм үзүүлэлтүүд бас байгаад байгаа. Энэтэй холбоотойгоор 2024 онд бидний хийсэн 1 ажил юу вэ гэхээрээ Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтийн мета датагийн гарын авлагыг боловсруулаад, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн байгаа. Манайхаас гарч байгаа санал юу вэ гэхээрээ энэ 73 үзүүлэлтээс 23 үзүүлэлтийн бид нар тооцоог илүү нарийвчилъя. Аргачлалыг

сайжруулъя гэдэг ийм саналыг хүргүүлсэн. Үүнтэй холбоотойгоор Эдийн засаг, хөгжлийн яамны багтай 2 удаагийн уулзалт зохион байгуулаад, энэ 10 сараас эхлэх 10 жилийн хөгжлийн төлөвлөлтийн үзүүлэлтүүд дээр бас өөрчлөлт оруулах боломжуудыг хэлэлцье гэж ажиллаж байгаа.

2 дугаарт бид энэ 5 сардаа багтаагаад бүсчилсэн хөгжлийн үзүүлэлтүүдийг Үндэсний статистикийн хорооны Статистикийн нэгдсэн мэдээллийн нэгдсэн сан буюу 1212.mn дээр оруулна. Энэ дээр бол яг нөгөө бүсчилсэн хөгжлийн үзүүлэлтүүдийг Алсын хараа 2050-тай уялдуулаад, бид нар гол гол статистик мэдээллийг оруулахаар ажиллаж байгаа.

2 дугаарт хүн ам, орон сууцын завсрын тооллогыг энэ жил бид Хүн ам, орон сууцын тухай хуулийн дагуу хийх гэж байгаа. Энэ тооллогын гол онцлог юу байна вэ гэхээрээ бид нар бүртгэлд суурилсан аргаар явуулна. Өөрөөр хэлбэл төрийн 12 байгууллагын мэдээллийн санг нэгтгэх замаар нөгөө нийт 3,5 сая хүний мэдээллийг шинэчлэх, 1 сая гаруй өрхийн мэдээллийг шинэчлэх энэ ажлыг бол явуулах юм байгаа юм. Үүнтэй холбоотойгоор бид бол төрийн бүх байгууллагуудаас Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагуудаас санал авсан. Мөн энэ талаар судалгаа шинжилгээ хийдэг их дээд сургуулиудын багш нартай 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулаад, тооллогын асуулга, мэдээллээ бол нэлээн нягтлаад сайжруулаад явж байгаа. Энэ хоёр 7 хоногийн дараа Засгийн газраас бол тогтоол батлуулахаар ажиллаж байна. Энэ нь юу вэ гэхээр орон нутгууд дээр энэ тооллогын мэдээллийн чанарыг сайжруулах комиссууд байгуулах, энэ мөрөөрөө мэдээллээ нэгтгэж, 12 сар гэхэд энэ тооллогыг дуусгахаар бол бид нар ажиллаж байгаа.

Улаанбаатар хотын тулгамдсан асуудал буюу түгжрэл болон утаатай холбоотой бол нэлээн статистик үзүүлэлтүүд бол бид нар гарна гэж хүлээгдэж байгаа. Үүнтэй холбоотой бид нар өрхийн орон сууцын галлагааны хэлбэр, цахилгаан, дэд бүтцийн хэлбэрүүдтэй нарийн мэдээллүүдийг авна. Дээрээс нь хөдөлмөр эрхлэлтийн мэдээллүүдийг авахаар байгаа. Өөрөөр хэлбэл сум, баг, хорооны түвшинд бид нар хөдөлмөр эрхлэлт, орон сууцын нөхцөл, боловсролын түвшин гээд нэлээн нарийн мэдээллүүдийг бол энэ тооллогоор цуглуулахаар байгаа. Хамгийн гол бидний бас зориод байгаа ажил юу вэ гэхээрээ цаашдаа жил болгон энэ тооллогын мэдээллийг төрд байгаа мэдээллүүдээр дамжуулж шинэчлэх ийм зорилтыг дэвшүүлээд ажиллаж байгаа юм.

3 дугаарт тэр Үндэсний зөвлөлийн тайлан ирүүлээгүй гэдэг дээр бол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тайлан дээр дурдсан байсан..../минут дуусав/

Р.Батболд: Гүйцээж хариулъя. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Б.Батдаваа: Одоогийн статистикийн тухай хууль дээр бол Улсын Их Хурлаас томилогдож байгаа үндэсний зөвлөл нь бол статистикийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх ийм гол чиг үүрэгтэй ажиллаж байгаа. Үндэсний зөвлөл дээр бол бид нар жил болгон өнгөрсөн оны үйл ажиллагааны тайлан, дээрээс нь ирэх жилдээ хийх гэж байгаа үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл, төсвийн төлөвлөгөөгөө хэлэлцүүлээд санал авсны үндсэн дээр бол Эдийн засгийн байнгын хороонд тайлангаа хүргүүлж ажиллаж байгаа. Бид нар энэ статистикийн тухай хуулийг шинэчлэх ажлын хүрээнд бас олон улсын сайн туршлагыг судлаад, энэ үндэслэлийн зөвлөлийг илүү өргөтгөөд, илүү гол статистик мэдээ боловсруулдаг

Монгол банк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Эрүүл мэндийн яам гэх мэт байгууллагууд нэмээд хэрэглэгчдийн төлөөллийг бүрдүүлсэн бас салбар зөвлөл байгуулахаар хууль дээр оруулахыг зорьж байгаа юм. Ингэснээр яаж байна вэ гэхээрээ энэ статистик мэдээлэл гаргаж байгаа төрийн байгууллагуудын уялдаа холбоо сайжрах, дээрээс нь хэрэглэгчдийн эрэлтэд нийцсэн хэлбэрээр статистик боловсруулах энэ бодлогын хууль, эрх зүйн суурь орчин бий болно гэж харж байгаа. Баярлалаа.

Р.Батболд: Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Их товч, тодорхой хариуллаа. Хариултуудаа авчихлаа. Нэг зүйлийг зүгээр тодруулж асууя. Энэ хүн ам, орон сууцын завсрын тооллогын тайлан ирэх жилийн тайлан гарна гэж тооцож байна уу. Тэгээд хэдэн сард гарах боломжтой вэ. Тэрийг бас тодруулъя.

Р.Батболд: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Б.Батдаваа: Бид төлөвлөгөөндөө бол 12 сарын 17-18 луу шилжих шөнөөр бол тооллогын мэдээллийг таслахаар тооллогын товоо баталсан байгаа. Тооллогын тайланг бол 2026 оны 1 дүгээр улиралд багтаагаад танилцуулахаар зорин ажиллаж байгаа. Бидний гол зорилго юу вэ гэхээр өнгөрсөн оны 5 сард бидний ашиглалтад оруулсан datd.nso.mn дээр бид нар энэ тооллогын мэдээллийг бол дашбоард хэлбэрээр болон өгөгдлийн сан хэлбэрээр байнга шинэчлэхээр оруулна. Тэгэхээр ирэх жилийн 1 дүгээр улирал гэхэд энэ мэдээлэл бэлэн болно гэж харж байгаа.

Р.Батболд: Бадамсүрэн гишүүнийг асуулт асуух нэрсийн жагсаалтад оруулаарай. Одоо Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууж, үг хэлье.

О.Батнайрамдал: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Тайлантай танилцлаа. Маш ойлгомжтой. Ер нь Үндэсний статистикийн хороо, Үндэсний аудитын газар гарч байгаа тайлангууд нь маш цэгцтэй, ашиглахад хамгийн хялбар байдаг. Тэгэхээр ажил сайн явж байгаагийн шинж гэж харж байгаа. Надад 2 асуулт байгаа юм.

Энэ тайлан дээр байна. Төрийн нэгдсэн өгөгдлийн сангийн хөгжүүлэлт, удирдлага, төсөл гээд. Энэ бол маш чухал ажил хийгдэж байгаа юм байна. Дөнгөж өнөөдөр та бүхний өмнө Монгол Улсын Засгийн газраас 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнийхөө хэлэлцүүлгийг хийлээ. Энд хиймэл оюун гэдэг үг бол маш олон давтагдаж байна. Хиймэл оюуныг төрийн албаны төрийн үйлчилгээнд бүх түвшинд ашиглана л гээд ямар ч байсан орж ирж байна. Яах вэ зөв хэрэг. Гэхдээ хиймэл оюуныг энэ төрийн үйлчилгээнд ашиглахад бол өөрөө өгөгдлийн сан нь байх ёстой. Өгөгдөлгүй бол хиймэл оюуныг ашиглана гэж юм байхгүй шүү дээ. Тэгэхээр энэ төрийн нэгдсэн өгөгдлийн сангийн хөгжүүлэлтийг би маш их сонирхож байна. Энэ ер нь дараагийн Монгол Улсын 10 жилийн хөгжилд бол маш чухал зүйл энэ дээр хийгдэж байгаа юм байна шүү дээ.

Бас энэ дээр дүгнэлт байна л даа. Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн менежмент болон өгөгдлийн шинжилгээ хийх бэлэн байдлын түвшнээр үнэлэхэд 79,1 хувь нь тодорхойгүй болон анхан шатны гэж тодорхойлсон байна. Тэгэхээр төрийн байгууллагуудаас мэдээлэл өгөгдлөө авъя

гэхээр хэтэрхий тодорхойгүй, анхан шатны байна гэсэн үг. Тэгээд 1 газар энэ нь базагдаад нэгдсэн өгөгдөл үүсэж байх ёстой. Мөн танай зураглал замын зураглалаа тодорхойлсон нь бол маш сайн хэрэг. Энэ дээр бол ер нь үндэсний өгөгдөл хариуцсан нэг институц байх ёстой гэсэн саналыг энэ судалгаагаар дэвшүүлсэн байна. Тэгэхээр эхний ээлжид ингээд Үндэсний статистикийн хороо дээр бараг явж байгаа нь бараг би зөв гэж харж байна л даа. Ер нь энэ нэгдсэн өгөгдлийг бид нар цаашдаа хэрхэн илүү төгөлдөршүүлэх вэ. Төрийн байгууллагуудаас уг нь бол маш их мэдээллүүд байгаа. Тэрийг мэдээж ашиглахад боломжтой, цэгцтэй, илүү боловсруулагдсан байдлаар нэгдсэн өгөгдөл бид нар үүсгэж чадах юм бол буцаад өгөгдөл дээр үндэслэсэн бодитой шийдвэр гаргаж чадна. Төсвөө илүү цэгцтэй төлөвлөж чадна. Буцаад төрийн үйлчилгээг илүү хиймэл оюун дээр үндэслэх үү, эсвэл илүү өгөгдөл дээр суурилсан бодитой шийдвэр гаргаж чадна. Цаашлаад мөн статистикаас гадна ер нь төрд байгаа тэр том мэдээллийг буцаад хувийн сектор хэрхэн зөв оновчтой ашиглаж чадах вэ гэдэг дээр илүү зөв шийдвэрүүд гараад явах юм. Тэгэхээр энэ дээр бас нэмэлт тайлбар авъя 1 дүгээрт.

2 дугаарт хэрэглээний үнийн индекс дээр надад 1 асуулт байгаад байсан юм. Энийг завшаан гарсан дээр асуугаад авъя гэж бодож байгаа юм. Хэрэглээний үнийн индексэд одоогийн санаж байгаагаар 2, 3 жилийн өмнө сагсанд ойролцоогоор миний ойлгож байгаагаар 25 орчим бүтээгдэхүүн байгаа гэж ойлгож байгаа. Маш олон юм байна шүү дээ. Тэр дотор жингээрээ бас нэлээн том ялангуяа нөгөө шатахуун талаасаа АИ92 А80 2 адилхан жинтэй яваад байсан санагдаад байгаа юм. А80-ын хэрэглээ чинь бараг байхгүй болчихсон шүү дээ. Тэгэхээр АИ92-ын хэрэглээ 1 ёсондоо маш өндөр. Гэтэл АИ92, А80 2-ын тэр сагсанд хэрэглээний индекс тодорхойлоход жингийн хэлбэр нь жингийн тооцоо нь бараг адилхан байсан санагдаад байгаа юм. Тэгэхээр энэ хэрэглээний индекс хэрхэн нийт хэрэглэгчдийн зан төлөвтэйгөө, хэрэглээтэйгээ хэрхэн уялдаж явж байгаа юм. Хамгийн сүүлд хэзээ шинэчлэгдсэн юм бол гээд асуучихъя. Баярлалаа.

Р.Батболд: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Б.Батдаваа: Эрхэм гишүүн Батнайрамдалын асуултад хариулъя. Бид 2022 оны сүүлээс эхлээд Азийн хөгжлийн банктэй хамтраад төрийн нэгдсэн мэдээллийн сангийн удирдлага, хөгжүүлэлт гээд төслийг хэрэгжүүлсэн байгаа. Энэ төслийн гол зорилго юу вэ гэхээр ер нь дэлхийн бүх улсуудад өнөөдөр өгөгдөл буюу дата хамгийн үнэ цэнтэй бүтээгдэхүүн боллоо. Өнгөрсөн 3 дугаар сард НҮБ дээр хуралдсан Статистикийн товчооны хурлаар үндэсний тооцоонд өгөгдлийг хөрөнгө хэлбэрээр бүртгэхээр шинээр SNA 2025 дээр өөрчлөлт орж байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор ер нь улс орнууд бол өгөгдлийн засаглал буюу дата говенанс тал дээр бол нэлээн анхаарч ажиллаж байна. Бид энэ дээр бас олон улсын сайн жишгийг дагах үүднээс бол сүүлийн 2-3 жилд яг төрийн нэгдсэн өгөгдлийн санг хөгжүүлэх гээд эхний бүтээгдэхүүн үр дүн нь төрийн data.nso.mn буюу төрийн нэгдсэн өгөгдлийн сан гээд энэ сайтыг ашиглалтад оруулчихаад байгаа. Үүний цаана бид нарын хамгийн гол анхаарах ёстой асуудал бид нарын хийсэн тэр өгөгдлийн замын зураглал, стратеги, үнэлгээ дээр гарч байгаа гол зүйл юу вэ гэхээрээ энэ төрд байгаа мэдээллийн сангуудын чанарыг сайжруулах, энэ дээр ажиллаж байгаа боловсон хүчний чадавхыг сайжруулах дээр бол бид нар бол маш их анхаарах хэрэгтэй юм байна. Өөрөөр хэлбэл таны хэлдгээр Гартнерын өгөгдлийн үр дүнгийн шинжилгээ гээд 5 шаттай өгөгдлийн түвшин нь хэр байна вэ гэдэг үнэлгээгээр бол 79 хувь нь бол 1-2 дугаар үе дээрээ буюу зөвхөн өгөгдлийг

цуглуулах, энийгээ шийдвэр гаргаж, өөрсдийнхөө үйл ажиллагааг сайжруулах, эргээд бүтээгдэхүүн үйлчилгээгээ илүү автомацац хийх тэр түвшиндээ хүрээгүй байна гэдэг ийм судалгааны үр дүн гарсан. Энэнтэй холбоотойгоор бид нарын Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамтай хамтраад ажиллаж байна. Удахгүй бас энэ өгөгдлийн замын зураглалыг илүү дэлгэрүүлээд, Засгийн газрын хуралд оруулаад ер нь бол Монгол Улсын хэмжээнд бол өгөгдлийн зөвлөл байгаад энэ дээр Үндэсний статистикийн хороо нарийн бичгээр, Цахим хөгжлийн яам манлайлаад, Үндэсний дата төв дээрээ датагаа нэгтгэдэг, шаардлагатай тохиолдолд тоонуудаа нэгтгэж төр шийдвэрээ гаргадаг, хувийн хэвшилдээ ашиглуулдаг байхаар өөрчлөлтүүдийг оруулж байгаа. Эхний гарч байгаа үр дүнгүүд юу вэ гэхээрээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу бид нар аж ахуйн нэгж, иргэдийн эмзэг мэдээллийг хайчлах гэж ярьдаг. Арилгах энэ технологийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам маань өнгөрсөн онд И-монголиа академиар дамжуулаад, шинээр нэвтрүүлсэн ийм үр дүн гарсан.

Ингээд хүн, амын тооллого, аж ахуйн нэгжийн тооллого энэ мэдээллүүд маань ер нь бол цаад тал нь дандаа өгөгдлийг нэгтгэх буюу дата засаглалын асуудлууд бол яригдаад явж байгаа юм. Бид энэ дээр бол нэлээн бас судалгааны суурьтай ажиллаад, төлөвлөгөө гаргаад ажиллаад явж байгаа.

2 дугаар асуултын хүрээнд хэрэглээний үнийн индексийг бол өмнө нь 5 жил тутам шинэчилдэг байсан. 2015 онд хамгийн сүүлд байж байгаад 2020 он болоод, бид нар 2022 оны эхээр 2020 он суурь луу шилжүүлээд, сая 2023 он руу шилжүүлээд давтамж нь илүү ойрхон болоод байгаа.

Таны хэлдгээр 15 суурьтай байхад бол А80 бензиний АИ92-той эзлэх энэ хувь хэмжээ бол маш ойролцоо байсан. Одоо яаж байна вэ гэхээрээ энэ 2-ын зөрүү бол бараг 10 дахин, 9 дахин зөрөөтэй байгаад байгаа. Нийт сагсанд эзэлж байгаа жин нь. Өөрөөр хэлбэл А80-ын хэрэгцээ өөрөө цаг хугацаа өнгөрөх тусам буураад, илүү иргэд АИ92, А95 руу бол нэмэгдэж байгаа нь гээд, нөгөө сагсаа бид нар ойрхон шинэчлээд байгаа нь илүү иргэдийн хэрэглээний чиг хандлага дээр өөрчилж байгаа өөрчлөлтийг багцалж оруулах ийм зорилготой байгаа.

Одоо манай сагсанд бол нийтдээ 430 бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ байгаа.

Р.Батболд: Батнайрамдал гишүүн тодруулъя.

О.Батнайрамдал: Үндэсний өгөгдлийг бид нар хэрхэн сайжруулаад ашиглах вэ. Тэгэхээр Азийн хөгжлийн банктэй хамтраад ямар ч байсан замын зураглалаа гаргасан юм байна. Энийгээ заавал үндэсний хэмжээний том ажил болгох хэрэгтэй. Явж явж энэ маш олон төрийн бүтээмжийг сайжруулах, ер нь цаашдаа бид нар дэлхийн хөгжлөөс хоцрохгүй байх хамгийн том суурь нь болно. Тэгэхээр энийг яаж дэмжих вэ. Энийг бүх талаар дэмжмээр байна. Цаг хугацаа алдалгүй энийг ажил болгомоор байна. Засгийн газар дээр ч гэсэн ер нь аливаа улсад маш олон дата өгөгдөл үүсэж л байдаг. Тэрийг ашиглаж чадах юм бол тэр өөрөө хамгийн үнэ цэнтэй. Ашиглаж чадахгүй бол тэгээд 1 компьютер дээр хадгалагдаад л үлддэг. Өнөөдөр дэлхийн хэмжээний томоохон компаниудыг аваад үзэх юм бол хамгийн том компаниуд дандаа өгөгдөл дээр суурилсан бизнес. Тэгэхээр энэ ажилд нь амжилт хүсээд тэгээд тултал нь дэмжинэ шүү.

Р.Батболд: Одоо Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууж,үг хэлнэ.

М.Бадамсүрэн: Тайлантай танилцлаа. Баярлалаа. 3 асуулт байна.

1 дүгээрт нь энэ хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бэлдэж байгаа юм байна. Тэгээд эндээ орон нутагт буюу сумдад энэ статистик хариуцсан орон тооны ажилтан гэж байдаггүй. Энийг хавсардаг. Яг үүнтэй холбоотой ажлын байрны тодорхойлолтод нь яг тодорхой зааж оруулж, яг ямар албан тушаалтанд хариуцуулж байгаа вэ. Аль нь илүү оновчтой байна гэж та бүхэн дүгнэж байна. Эсвэл энд давхар ажил гүйцэтгэсний төлөө олгох ийм урамшууллын систем эсвэл байгаа юу. Энэ өөрөө их хариуцлагын асуудал л даа. Үнэн зөв мэдээлэл гаргах, ялангуяа энэ чинь малын гоц халдварт өвчнөөр мал хорогдвол тэр сумын статистикийн ажилтны оруулсан тэр дүн мэдээ дээр үндэслэж олгож байгаа шүү дээ. Нөхөн олговрыг 90 хувиар. Тэгээд энэ чинь өөрөө ийм хариуцлага дагуулж байгаа асуудал учраас энийг ер нь яаж шийдэж байгаа вэ. Шийдэхээр шинэчлэхээр төлөвлөж байна вэ.

2 дугаарт нь малын тооллогын хугацааг 12 сарын эхэнд байгаа. Энийг 12 сарын сүүл юм уу, дундаас хойш болгох талаар судалж байгаа зүйл байна уу. Яагаад гэхээр монголчууд ярьдаг байсан. Ах дүүгийн мэддэг 11 сар гээд. 11 сард идшээ хийдэг байсан. Одоо энэ дэлхийн дулааралтай холбоотой энэ хугацаа чинь бол хойшилсон шүү дээ. Хүйтрэх хугацаа чинь бол хойшилсон гэсэн үг. Тэгэхээр энийг цаг үетэйгээ нийцүүлээд яаж өөрчлөх талаар танай байгууллагад ийм судалсан судалгаа байна уу. Хувилбар байна уу. Энийг ер нь юу гэж авч үзэж байгаа вэ. Цаашид яах вэ. Тэгэхгүй бол энэ дүн мэдээнд чинь бас нөлөөлөөд байгаа нөлөөлөл бас байх вий гэдэг ийм болгоомжлол бас байна. Яагаад гэвэл цаг үетэйгээ бид нар яг нийцүүлэх ёстой байхгүй юу.

3 дугаарт нь Улсын Их Хурлаар Засгийн газраас өргөн мэдүүлж энэ гурилын болон малын тэжээлийн импортын татварыг буцааж 15 хувь, 5 хувийн татварыг эргэж сэргээн өмнөх тэглэсэн хуулийг хүчингүй болгох энэ зүйл ингээд хэлэлцэгдээд явж байгаа юм. Тэгээд энэ 7 хоногт бол эцэслэхээр байгаа. Миний хувьд Улсын Их Хурлын гишүүнийхээ бүрэн эрхийн хүрээнд зарчмын зөрүүтэй санал гаргаж, энэ импортын татварыг хэрвээ буцааж 15 хувийн татвар ноогдуулахаар болох юм бол гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн болох гурилын үнэ өсөх, малын тэжээлийн үнэ өсөх эрсдэл байгаа учраас энд тогтоолын төслөөр Засгийн газарт даалгавар чиглэл өгөх ийм зүйлийг санаачлаад, эхний хэлэлцүүлэг дээр дэмжигдээд явж байгаа. Энэ нь юу вэ гэхээр үндэсний үйлдвэрлэлүүдээ дэмжиж, гурилын дотоодын аж ахуйн нэгжүүдийн тариалсан будаагаар дотооддоо гурилын үйлдвэр ажиллах нь зөв гэдгийг бол дэмжиж байгаа. Гэхдээ үнэ өсөхгүй байх ямар арга хэмжээ авах вэ гэдэг дээр энэ тогтоолын төсөл явж байгаа гэсэн үг. Энэ дээр юу гэж зааж оруулсан гэхээр Үндэсний статистикийн хорооны 6 сар тутмын дунджаар гаргасан мэдээгээр гурилын үнэ өсвөл Засгийн газар дахиад гурилын татварыг эргэж тэглэх буюу чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, ард иргэдийг гурилын үнийн өсөлтөөс сэргийлэх чиглэлээр ийм бодлого хэрэгжүүлэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл гурилын үйлдвэрүүдэд хэрвээ үнэ өсвөл дахиад тэглэх юм байна гэдэг ийм бас сэрэмжлүүлэг өгөх нь зүйтэй гэж үзэж л энэ тогтоолын төслийн санаачлаад, дэмжигдээд явж байгаа юм. Тэгэхээр энийг ер нь 6 сар тутамд ингээд тооцоход ямар нэгэн хүндрэлтэй асуудал та бүхэнд гарах уу. Энийг инфляцтай уялдуулах уу. Энэ ер нь яг яавал зүйтэй байна гэдэг талаар яг мэргэжлийн

байгууллагын хувьд бол энэ 7 хоногт хэлэлцэж байгаа учраас та бүхнээс бас тодруулъя гээд ийм 3 асуулт байна. Баярлалаа.

Р.Батболд: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Б.Батдаваа: Эрхэм гишүүн Бадамсүрэнгийн асуултад хариулъя. Бид Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр орон нутагт статистикийн үйл ажиллагааг чанартай эрхлэх, энэ дээр ажиллаж байгаа боловсон хүчнийг бас сайжруулах тал дээр бол хэд хэдэн бас заалтууд төсөл дээр нь оруулаад явж байгаа. 1 хувилбар нь юу вэ гэхээрээ сумдад бол статистик хариуцсан давхар гүйцэтгэх албан хаагч байна. Энэ дээр бол урамшуулал олгох нь зүйтэй гэдэг тийм төсөл оруулаад явж байгаа. Одоо яаж байгаа вэ гэхээрээ сумдад бол статистикийн үйл ажиллагааг төрийн сангийн ажилтан давхар эрхэлж байгаа. Миний санаж байгаагаар 2015 онд төрийн сангийн ажилтан статистикийн үйл ажиллагааг давхар хэрэглэж байхад 20 хувийн нэмэгдэл, урамшуулал авдаг байсныг Үндэсний аудитын газар бас ажлын байрны тодорхойлолт дээр нь орсон ажил учраас болохгүй гээд больчихсон байгаа. Тэгээд үндсэндээ бол яг таны хэлдгээр сумд дээр бол яг статистик хариуцсан ажилтнууд байдаггүй. Энэ бол давхар ажлыг эрхлээд нэлээн ачаалалтай ажиллаад яваад байдаг. Багийн дарга нартайгаа хамтраад ингээд явж байгаа юм. Тэгэхээр энийг бол бид нар бас энэ байдлаар шийдэхгүй бол ер нь сумдаас бол маш их хэмжээний мэдээллээ авдаг. Мал тоолох, хүн ам зүй, тэгээд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ гээд мэдээллүүдийг авдаг. Бид нар мэдээллүүд дээр бол мэдээж хяналтыг бол давхар хийдэг. Жишээлбэл мал тооллого гэхэд бид нар мал тооллогын явцад нийт тоологдсон өрхийг 10 хувь дээр нь хяналтын тооллого хийдэг. Дунджаар алдааны түвшин бол өнгөрсөн оных бол 1,11 хувьтай байсан ийм түвшинтэй байгаа.

Мал тооллогын хугацааны хувьд бол бид нар 12 сарын 7-оос хойшлуулах асуудлыг судалж үзээч гээд 3 жилийн өмнө Тэмүүлэн гишүүнээс бол санал гаргаж байсан. Яагаад вэ гэхээрээ цаг агаарын дулааралтай холбоотой малын нядалгааны цаг бас арай хойшлоод байна гэдэг асуудлуудыг бол тавьж байсан юм. Тэгээд бид энийг бол орон нутгийн удирдлагууд, орон нутгийн сумдын засаг захиргаа нэгжүүдээс бол санал авсан. Энэ дээр бол гол асуудал юу яригддаг вэ гэхээр 12 сарын сүүлийн хагас болоод ирэхээрээ иргэдийн Төлөөлөгчийн Хурал, сумдын тайлангийн хурал, тэгээд шинэ жил гээд асуудлууд гараад байдаг учраас ажил амжихгүй байна, яг энэ хугацаагаараа одоогоороо явж байя гэдэг саналыг гаргадаг.

Бид нар гол хийх гэж байгаа ажил юу вэ гэхээрээ цаашдаа ингэж жил болгон 12-15 мянган төрийн албан хаагчдыг хамруулсан байдлаар ингэж тоолоод хийгээд байх нь эдийн засгийн хувьд бол хэтэрхий өртөг өндөртэй байна. Цаг хугацааны хувьд. Тийм учраас Хөдөө аж ахуйн яам дээр хөгжүүлж байгаа малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг өрхийн түвшинд нь мэдээллийг бид нар байнга шинэчилж оруулах энэ ажлыг бол сүүлийн 2 жил дараалаад хийгээд явж байгаа. Зөрүү гарч байгаа шалтгаан болгон дээр нь бид нар Хөдөө аж ахуйн яам дээр сумдад байгаа Хөдөө аж ахуйн тасаг дээр анхаарах асуудлуудыг яг ингэж ингэж та нар ажилламаар байна. Программ дээр ийм асуудлууд байна гээд гараад явж байгаа. Тэгээд эцэст нь бид нар яах вэ гэхээрээ мал тооллогын үр дүнг бид нар хяналтын тооллогын журмаар бол орон зайн мэдээлэл ашиглаж хянах буюу сансрын зураг, дроноор хянах, дээрээс нь түүвэр байдлаар тооллогыг баталгаажуулах энэ ажил руу шилжье гэж бодож байгаа.

3 дугаарт гурилын үнийн асуудал дээр бол Үндэсний статистикийн хорооноос өргөн хэрэглээний 22 бараа бүтээгдэхүүний үнийг бол 7 хоног тутам бол судалж гаргаж байгаа. Сар болгон бид нар улсын хэмжээнд 2000 цэгээс өргөн хэрэглээний 430 бараа бүтээгдэхүүний үнийг цуглуулж байгаа. Тэгэхээр гурилын үнэ дээр бол хяналтыг бол бид нар үр дүнг сараар, 7 хоногоор бол гаргах боломжтой гэж болно.

Р.Батболд: Бадамсүрэн гишүүн болчихсон уу.

Би бас 1 зүйл асуугаадахъя. Статистикийн газар маань өргөн хэрэглээний барааны үнэ, тэрний судалгааг байнга хийгээд яваад байгаа шүү дээ. Тэгэхээр ерөнхийдөө манай Монголбанкнаас гаргаад байгаа манай инфляцын түвшин чинь ер нь 9 хувь дээр байгаа юм уу, байхгүй юм уу. Та хэд ер нь тусдаа тооцоолж, саналаа өгдөг үү гэдэг асуултад хариулт авчихъя. Ажлын хэсгийн 3.

Б.Батдаваа: Инфляцын түвшнийг бол яг албан ёсны статистик хэлбэрээр бол Үндэсний статистикийн хороо улсын хэмжээнд бол бид зарлаж явж байгаа. Монголбанк манай тоог авч ашигладаг. 4 дүгээр сарын байдлаар бол инфляц улсын хэмжээнд 8,6 хувьтай байгаа. 3 сард энэ бол 9,1 хувьтай байсан. Энэ маань өөрөө 9,1 хувийн хурдацтай өсөж байсан үнийн өсөлтийн хурд 8,6 хувь болж хурдац нь бага зэрэг буурсан ийм үзүүлэлт байгаа. 3 сараас 4 сард шилжих хугацаанд бол суурь, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ дунджаар 0,3 хувиар өссөн ийм статистик мэдээлэл байгаа. Тэгэхээр Төв банкны инфляцын зорилт бол бидний мөнгөний бодлогын тайлангаас харж байгаагаар бол 6 дээр +2 байгаа. Үндсэндээ бол 2024 оны эцэс бол энэ жилийн эхээр бол инфляц буцаад нэмэгдсэн байгаа. 2023 онд бол буурах хандлагатай байсан. Энэ дээр гол нөлөөлж байгаа зүйл бол 1 дүгээрт бол нийлүүлэлтийн гаралтай бүтээгдэхүүн дээр бол махны үнэ байгаа. Өнгөрсөн онд бол Монгол Улсын хэмжээнд нийт оны эхэнд тоологдсон малын 14,5 хувь нь хорогдоод, нийт малын хэмжээ бол 7 орчим сая толгойгоор буураад, 57,6 сая руу буурсан байгаа. Зарим аймгууд дээр жишээлбэл Сүхбаатар аймаг дээр бол нийт малынх нь 45 хувь нь хорогдсон нь өөрөө махны нийлүүлэлтэд нөлөөлсөн 1 үзүүлэлт байгаа.

2 дугаарт бол энэ цалингийн өсөлттэй холбоотойгоор мөн цахилгааны төлбөртэй холбоотойгоор бол үйлчилгээний бараа бүтээгдэхүүний үнэ барааны үнээс бол илүү хурдацтай өсөөд байгаа. Жишээлбэл ковидын ид үе буюу дараах үеүдэд бол импортын бараа, барааны үнийн өсөлт, хүнсний барааны өсөлт өндөр байсан бол сүүлийн жил хагасын хугацаанд үйлчилгээний барааны үнэ бол илүү эрчимтэй явж байна. Энэ бол дунджаар 17 хувьтай өсөж байна. Гэхэд бол барааны үнэ бол дунджаар 6-8 хувийн өсөлттэй байгаа.

Р.Батболд: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Үндэсний статистикийн хорооны 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дууслаа. Тайлан танилцуулсан Батдаваа дарга, ажлын хэсгийнхэнд баярлалаа. Та бүхний ажилд амжилт хүсье.

Байнгын хорооны гишүүддээ нэг мэдээлэл байна. Тэгэхээр “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг сая хэлэлцлээ.

Тэгээд энэ маргаашийн чуулганаар ороод, тэгээд манай Байнгын хороо 5 дахийн өглөө 9 цагт хуралдаад, ажлын хэсэг байгуулах товтой байгаа. Тэгэхээр энэ ажлын хэсэгт орж ажиллах саналтай гишүүд байвал тэрийгээ бас бодож байгаарай.

5 дахийн өглөө 9 цагт хуралдъя. Тэгээд ажлын хэсгээ байгуулъя.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

15.20 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ